

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫН ИЛТГЭЛҮҮД



МОНГОЛ УЛСЫН ЦАГААТГАХ
АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН
БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИСС



МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН
ХЭЛМЭГДЭГСДИЙН ХОЛБОО



Конрад
Аденауэр
Сан



МОНГОЛ БОЛОН ХБНГУ ДАХЬ
УЛС ТӨРИЙН ХЭЛМЭГДЭГСДИЙН
ЦАГААТГАЛ: ДҮГНЭЛТ, СУРГАМЖ,
ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД

Эрдэм шинжилгээний бага хурал, 2016 оны 04 дүгээр сарын 25

Улаанбаатар 2017



Зохиогчийн эрх
 ©Конрад-Аденауэр-Сан
 Монгол дахь Суурин төлөөлөгчийн газар
 Сөүлийн гудамж, Браухас-22
 Улаанбаатар 210628, Монгол Улс

Орчуулсан: Сэнгээгийн Дүрзийжалбуу

Хянасан: Др. Даниел Шмюкинг
 Сэнгээгийн Ганзаяа
 Рафаэлла Хелф

Улаанбаатар, 2017

ТОВЪЁОГ

- 4 | ГЕРМАН ОРОН ДАХЬ ТҮҮХИЙН ДУРСГАЛТ ГАЗРУУД БОЛОН ТҮҮХЭН
ҮЙЛ ЯВДЛЫГ ХҮНДЭТГЭН ДУРСГАХ АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙН ТАЛААР
Др. Хүбертүс Кнабе - Берлин хот дахь Хөөншөнхаузен дурсгалын
цогцолборын захирал
- 24 | ХЭЛМЭГДҮҮЛЭЛТ БА ЦАГААТГАЛ
Дашнамжилын Цогтбаатар - Монголын Улс Төрийн Хэлмэгдэгсдийн
Холбооны тэргүүн
- 39 | УЛС ТӨРИЙН ХЭЛМЭГДЭГСДИЙГ ЦАГААТГАХ АЖЛЫН
ТАЛААР ТӨРӨӨС АВЧ БУЙ АРГА ХЭМЖЭЭ
Дэлэгчоймбалын Дамбасүрэн - Монгол Улсын Цагаатгах ажлыг
удирдан зохион байгуулах улсын комиссын нарийн бичгийн дарга
- 48 | МОНГОЛД ГАРСАН УЛС ТӨРИЙН ХЭЛМЭГДЭЛ: ДҮГНЭЛТ, СУРГАМЖ
Оохнойн Батсайхан - Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн
Олон улс судлалын хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний тэргүүлэх
ажилтан, Түүхийн шинжлэх ухааны доктор, профессор
- 58 | КОММУНИСТ ДЭГЛЭМИЙН ҮЕИЙН УЛС ТӨРИЙН ХЭЛМЭГДҮҮЛЭЛТИЙГ
ДҮГНЭН ШИНЖЛЭХ, ХЭЛМЭГДЭГСДИЙГ ЦАГААТГАХ ЧИГЛЭЛЭЭР
ГЕРМАН УЛСАД ХИЙГДЭЖ БУЙ АЖЛУУД
Др. Хүбертүс Кнабе - Берлин хот дахь Хөөншөнхаузен дурсгалын
цогцолборын захирал

ГЕРМАН ОРОН ДАХЬ ТҮҮХИЙН ДУРСГАЛТ ГАЗРУУД БОЛОН ТҮҮХЭН ҮЙЛ ЯВДЛЫГ ХҮНДЭТГЭН ДУРСГАХ АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙН ТАЛААР



Др. Хүбертүс Кнабе
Берлин хот дахь Хөөншөнхаузен
дурсгалын цогцолборын захирал



**Герман орон дахь түүхийн дурсгалт газрууд
болон түүхэн үйл явдлыг хүндэтгэн дурсах арга
хэмжээнүүдийн талаар**


- Берлин хот дахь Хөөншөнхаузен дурсгалын цогцолборын жишээн дээр -

Цогцолборын захирал Др. Хүбертүс Кнабе

Gedenkstätte
Berlin-Hohenschönhausen

www.stiftung-hsh.de

Түүхэн үйл явдлын баримтууд



- Нийтийн гал тогоо
- Тусгай зориулалтын агуулах
- ЗХУ-ын харъяанд байсан хорих газар
- БНАГУ-ын Улсыг аюулаас хамгаалах яамны харъяанд байсан хорих газар
- Засан хүмүүжүүлэх газар
- 1990 оны 10 сарын 3-ны өдөр албан ёсоор хаасан

5

Түүхэн үйл явдлын гэрч болсон газрууд



Хорих газрын орох хаалга

Түүхэн үйл явдлын гэрч болсон газрууд



"U-Boot" буюу "Шумбагч онгоц" хэмээн нэрлэгддэг байсан хэсэг



"Шумбагч онгоц" хэмээн нэрлэгддэг байсан хэсэг дэх ганцаарчилан хорих өрөө

Түүхэн үйл явдлын гэрч болсон газрууд



Коммунист дэглэмийн үед шинээр баригдсан байрнууд



Хоригдлуудыг хүлээн авдаг байсан газар

Түүхэн үйл явдлын гэрч болсон газрууд



Шоронгын хонгил



Ганцаарчилан хорих өрөө

Түүхэн үйл явдлын гэрч болсон газрууд



Хорих газрын дэргэдэх эмнэлэг

Берлин хотын Хээншөнхаузен дурсгалын цогцолбор



- 1992 онд хамгаалалтад авсан
- 1994 онд түүхийн дурсгалт газрын статустай болгосон
- 2000 онд нийтийн эрх зүйн хуулийн дагуу бие даан үйл ажиллагаа явуулж эхэлсэн
- Үйл ажиллагааны чиг үүрэг:
 - Түүхэн үйл явцыг судлах
 - Үзэсгэлэн, яармаг, бусад арга хэмжээ зохион байгуулах, хэвлэн нийтлэх
 - Коммунист дэглэмийн үеийн хэлмэгдүүлэлтэд шүүмжлэлтэйгээр хандаж, дүгнэн шинжлэх

Хүрэлцэн ирсэн зочдод зориулсан үйлчилгээ



Зочдыг хүлээн авах хэсэг

Экскурс

- Өдөр бүр долоон хэл дээр явагддаг
- Экскурсын 50-иас илүү хувийг нь хуучин хоригдож байсан хүмүүс удирдан зохион байгуулдаг

Экскурс



Хэсэг зочид хорих газрын салхилах талбайд


Хуучин хоригдож байсан хүмүүсийн удирдан зохион байгуулдаг экскурс




Сургуулийн хэсэг сурагчид тус газар хоригдож байсан хүмүүстэй уулзаж байгаа нь

Цогцолборыг үзэж сонирхсон хүмүүсийн талаарх тоо баримт

1994 оноос хойшхи нийт үзэгчдийн тоо




Дурсгалын цогцолборыг үзэж сонирхсон нийт хүмүүсийн тоо (1994-2015 он)



Гадаад орноос хүрэлцэн ирж дурсгалын цогцолборыг үзэж сонирхсон хүмүүсийн тоо (2015 он)

Цогцолборыг үзэж сонирхсон хүмүүсийн талаарх тоо баримт



13

Цогцолборыг үзэж сонирхсон хүмүүс



Дурсгалын цогцолборыг үзэж танилцахаар ирсэн 4 сая дахь зочноо хүлээн авч байгаа нь (2015 он)

Хүндэт зочид



Холбооны канцлер Ангела Меркел (2009 он)



Холбооны ерөнхийлөгч Иоахим Гаук (2013 он)

Амьд гэрчүүдийн ажлын өрөө

Erfassungsfeldformular Zeitzeugenböden

1. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

2. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

3. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

4. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

5. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

6. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

7. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

8. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

9. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

10. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

11. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

12. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

13. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

14. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

15. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

16. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

17. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

18. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

19. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

20. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

21. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

22. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

23. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

24. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

25. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

26. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

27. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

28. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

29. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

30. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

31. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

32. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

33. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

34. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

35. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

36. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

37. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

38. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

39. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

40. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

41. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

42. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

43. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

44. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

45. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

46. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

47. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

48. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

49. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

50. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

51. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

52. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

53. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

54. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

55. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

56. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

57. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

58. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

59. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

60. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

61. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

62. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

63. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

64. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

65. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

66. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

67. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

68. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

69. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

70. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

71. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

72. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

73. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

74. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

75. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

76. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

77. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

78. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

79. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

80. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

81. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

82. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

83. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

84. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

85. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

86. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

87. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

88. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

89. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

90. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

91. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

92. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

93. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

94. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

95. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

96. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

97. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

98. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

99. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

100. Person: **Wolfgang** **Georg** **Georg**

Хоригдож байсан хүмүүсийн тухай мэдээллийн сан

Архив




Зургийн архив

Цуглуулга



Төрөл бүрийн объектуудын цуглуулга

Байнгын үзэсгэлэн



Байнгын үзэсгэлэн




Үүдний танхим



Үзэсгэлэнгийн танхим

Байнгын үзэсгэлэн



Хорих газрын даргын ажлын өрөө

Зохион байгуулсан арга хэмжээнүүд



Герман Улс дахин нэгдсний баярын өдөр (2015 оны 10 сарын 3)

Зохион байгуулсан арга хэмжээнүүд



"Гитлерийн Герман болон БНАГУ оршин тогтнож байх үеийн хэлмэгдүүлэлтийн гэм буруутнууд" сэдэвт бага хурал (2015 он)



Өнөө үед амьд буй гэрчүүдтэй хийсэн нээлттэй ярилцлага (2016 он)

Олон нийтийн ажил




Телевизийн шууд
нэвтрүүлгийн явуулын
станц



Холбооны Канцлер хатагтай
Ангела Меркелийг зочилон ирэх
үеэр зохион байгуулсан хэвлэлийн
бага хурал (2009 он)

Эрхлэн нийтлүүлсэн материалууд



Сурган хүмүүжүүлэх чиглэлээр хийгдсэн ажлууд

- Семинар (3 цаг)
- Төслийн өдөрлөг (5 цаг)
- Сургалтыг удирдах багш нар 3



Сургалт мэдээллийн төв

Явуулын сургалтын төв

- Хоригдлуудыг тээвэрлэдэг байсан машиныг тоноглож, засварлан сургуулиуд дээр явуулдаг сургалтандаа ашиглаж байна



Явуулын үзэсгэлэн




Мэдээллийн цэгүүд

Gedenkstätte
Berlin-Mohrenstraße

www.stiftung-hsh.de

"Хэт зүүнийг баримтлагчид өнөө үед" сэдэвт төсөл



Семинарын тараах материалыг таблет дээр харуулсан байдал

Амьд гэрчүүдтэй уулзах улзалтын ажлыг удирдан зохион байгуулах



Одоо амьд буй гэрчүүдтэй сургуулийн сурагчдыг уулзуулах,
ярилцлага хийлгэх ажлыг Герман орны нийт сургуулиудыг
хамруулан зохион байгуулж байна

Олон улсын Хамтын ажиллагаа



Тиран дахь Улсыг аюулаас хамгаалах яамны үйл ажиллагааг харуулсан музейд зөвлөгөө өгч байгаа нь (2015 он)



Коммунист дэглэмийн үед хэлмэгдэгсдийн өнөөгийн нөхцөл байдлын талаар ЕХ-оос хэрэгжүүлж буй төслийн хүрээнд зохион байгуулагдсан арга хэмжээний үеэр (2015 он)

ХЭЛМЭГДҮҮЛЭЛТ БА ЦАГААТГАЛ



Дашнамжилын Цогтбаатар - Монголын Улс Төрийн Хэлмэгдэгсдийн Холбооны тэргүүн

1. Улс төрийн хэлмэгдүүлэлтийн гарал үүсэл, эх сурвалж, түүний хор уршиг
2. Иргэдээ хөнөөн хэлмэгдүүлсэн эрх зүйн акт, баримт болон үйл явц
3. Цагаатгах үйл ажиллагааы эхлэл, өрнөл, сулрал
4. Цагаатгах үйл ажиллагаанд тавих үнэлэлт, дүгнэлт, зорилт

Нэг. Улс төрийн хэлмэгдүүлэлтийн гарал үүсэл, эх сурвалж, хор уршиг

Монгол Улсад улс төрийн хилс хэргээр ард иргэдээ үй олноор нь яргалах, хядах явдал, ер нь хэзээ эхэлсэн юм бэ? Хэн үйлдсэн, хариуцлагыг хэн хүлээх ёстой вэ? Монголчууд бид өөрсдөө. Тэгвэл, түүнийг судлах, бодит үнэнийг олон түмэнд илчлэхийг монголын үе үеийн удирдагчид болгоомжилж ирсэн байдаг. Нэрнээс нь эхлээд харь хэлний орчуулгаар “хэлмэгдүүлэлт” гэдэг зөөллөн ойлгох ойлголтийг олж тавьсан нь сонирхол татдаг. Өмнөх нийгмийн байгууллын үзэл суртлын дарангуйлал, нөлөөгөөр энэ сэдвийг судлах, бодит үнэлгээ өгөх, дүн шинжилгээ хийх нь монгол хүн, хэн бүхэнд халгаатай, шудрагаар хэлэхэд шууд хаалттай байсан. Монгол Улс ардчилал шудрага ёсны зам сонгосон цагаан морин жилээс монгол хүний амны цоож нээгдэж, түмэн зовлон туулж амьд үлдэгсэдийн нуруу тэнийсэн. Харин тэр үеийн эрхтэн дархтанууд гэм буруугаа хүлээж, нүглээ наминчлахгүй л байлаа. Цаг цагаараа байдаггүй, цахилдаг хөхөөрөө байдаггүй. Их эрдэмтэн, гүүш Б.Ренчиний айлдсанаар **мөс мөнх биш** ажээ. 1996 онд “Цагаан морин жилийн ардчилсан хувьсгал”-ыг санаачлан хэрэгжүүлэгчид төрөө түших боломж анх удаа бурханы авралаар олдсон. Тэдэнд УИХ-ын 76 суудлын 50-ыг сонгогчид өгчээ. Тэгмэгц УИХ-аас жил бүрийн есдүгээр сарын 10-ны өдрийг улс төрийн хилс хэрэгт “Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх

өдөр” болгон тэмдэглэж байх тогтоол гаргалаа. Үүний дагуу 1996 оны 9 дүгээр сарын 10-нд Сүхбаатарын талбайд болсон “Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр”-ийн анхны цуглаан дээр УИХ-ын дэд дарга, Цагаатгах ажлыг удирдан Зохион Байгуулах улсын комиссын дарга Цахиагийн Элбэгдорж Монгол төрийн нэрийн өмнөөс ард түмнээсээ анх удаа уучлал гуйсан билээ.

Түүх сөхвөл, Модун шаньюгаас Хүннү Их Гүрний монгол төрийн байгуулал үүсэн хөгжиж, улс орныхоо хил хязгаарыг “овоо” босгон тогтоохоос эхлээд тухайн үеийн олон аймаг, улс орнуудтай, мөн шинэ үеийн Монгол Улс хойт, урд хөршүүдтэй геополитикийн хувьд байнга холбоотой явж ирсэн түүхтэй. Энэ нь наашлаад 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалаар шинэ цаг үеийн Монгол Улсын бие даасан байдал, тусгаар тогтносон улсаа тунхаглахад мөн л урд, хойт улсын нөлөө хэрэгжсээр л байсан. Ийнхүү 1921 оны хувьсгалтай золгосон юм. Үндэсний эрх ашгаа дээдлэн хамгаалж, Монгол Улс аль нэг улс гүрний хараат бус хөгжлийн зам сонгосон, эрхэмлэсэн хэн бүхнээ, ялангуяа 1921 оны хувьсгалыг эхлүүлсэн долоон хүний зургааг хөнөөснөөр Тухайлбал, Д.Бодоо, Д.Чагдаржав, да лам Пунцагдорж нарын 15 хүнийг өчиггүй буудан хороосноор улс төрийн хэлмэгдүүлэлтийн дарь ханхалж эхэлсэн. Улс төрийн хэлмэгдүүлэлтийг харь орны тулган шахалт, хүч түрэмгийллээс эхтэй гэх боловч, чин үнэндээ монголчууд, монголчуудаа хэлмэгдүүлсэн нь бодит үнэн. “Хэлмэгдүүлэлт” гэдэг өргөн ойлголтыг цогцоор нь авч үзэхгүйгээр хэдэн хүн ямар нэгэн гаднын нөлөөнд өртөн хэлмэгдсэн гэх ташаа мэдээллээр өнөөг хүртэл монголын нийгэм төөрөлдөж ирсэн гаж тогтолцоог өөрчлөх цаг болсоныг өнөөдөр хэлэх нь зүйтэй. Монголчууд үндэсний эрх ашгаас урван тэрслэгчдэд, монгол хүний мөс, чанараа алдан дайсагнагчдад хатуу гэсгээл, цээрлэл үзүүлж, шийтгэл зэмлэл хүлээлгэсээр ирсэн, үүгээрээ хүчирхэг төр, улс байгуулж чадсан түүхтэй улс. Харин гэм буруугүй иргэдээ хоморголон хөнөөх хар нүгэл зөвхөн “Ардын хувьсгал”-ын жилүүдэд л тохиолджээ. Энэ нь МАХН/МАН хэмээх улс төрийн хүчний далд, хэзээ ч илрэн илчлэгдэхгүй гэж тооцоолсон захиалга, санаачилгаар хэрэгжиж ирсэнийг шудрага хэлэх ёстой. Монголын төрт ёсны 2000 жилийн түүхэнд нэг л удаа тохиолдсон энэ гутамшигт үйл явдал нь **“аймшигт цуст яргалал, аллага хядлага буюу бүх нийтийг хамарсан демоцит”** байсан гэдэг нь нэгэнт тодорхой болжээ. Гагцхүү Монголын улс төрийн буурал түүхийн нэгэн цаг үед явагдсан энэ яргалал, хядлага нь **улс төрийн демоцид** байсныг Олон Улсын Шүүхээр тогтоолгох, дэлхий дахинд зарлан мэдээлж түүнээс сэрэмжлүүлэн жигшээхийг цаг үе шаардсаар байгаа. Харамсалтай нь өнөөг хүртэл энэ чухал ажил хийгдэхгүй байгаа нь демоцид үйлдсэн хүчин манай төр засгийн эрх мэдлийг удаан хугацаанд барьж ирсэнтэй шууд холбоотой байна. Одоо хэлмэгдүүлэлтийн эх үндсийг хэзээ, хаана,

ямар эх сурвалжаас, хэн бүрдүүлсэнийг товч авч үзье. 1924 онд Улсын анхдугаар их хурлаар батлагдсан Үндсэн хуулийг бид дунд сургуулийн хүүхэд байхаасаа эхлэн “Хамгийн ардчилсан, анхдугаар Үндсэн хууль” гэж бахархан ярьж, тэгж ойлгож, ойлгуулж ирсэн хүмүүсийн төлөөлөл. Тэгвэл тэс өөр ойлголт түүхийн цаг хугацаанд биднийг сэрээлээ. Тодруулбал: 1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 16 цаг 17 минутад батлагдсан тус Үндсэн хуулийн “Монголын **жинхэнэ** ардын эрх чөлөөг илтгэн тунхаглах нь” гэсэн 1 дүгээр бүлгийн «Гурав. БНМАУ-ын хязгаарын дотор бүхий газар ба уурхай хийгээд ... энэхүү хөрөнгө бүрнээ ардын мэдэлд байвал зохих бөгөөд энэ тухай **хувийн өмч байгуулж үл болно**.

Дөрөв. Улсын аж ахуй ба эдийн засгийн бодлогыг чухал болгон...**гадаадтай харилцах худалдааг улсын онц эрх болгон авах нь** ... Ардын Эрхт Засгийг бататгахад чухал нөхцөл болох тул цөм улсаас эрхэлбэл зохино.» гэжээ. Мөн хуулийн “Иргэний сонгох сонгогдох эрхийн тухай” заасан 4 дүгээр бүлгийн «35 дугаар зүйл. Аливаа хурлын төлөөлөгчдийг сонгох ба мөн төлөөлөгчдөд сонгогдох эрхгүй хүмүүс нь:

Нэг. **Ямагт ашгийг эрмэлзэх, бусдыг зарж амьдрагчид**

Хоёр. **Ямагт бусдыг хөлслөн зарах ба хөрөнгө орлого зэргийн үржлээр амьдрагч жинхэнэ худалдааны ба мөнгө хүүлэгчид**

Гурав. **Урьдын ван, гүн ба хутагт хувилгаад, жич орон хийдэд үргэлж суух санваартан лам нар»** гэж ангилжээ. Мөн хуулийн “Улсын тамга тэмдэг туг далбаа гурвын тухай” заасан 6 дугаар бүлгийн «Дөчин есдүгээр зүйл. Улсын туг далбааг **улаан өнгөтэй бөгөөд дунд нь улсын сүлд тэмдгийг оруулан үйлдүүлж гүйцэтгэвэл зохино**.

Тавьдугаар зүйл. Тус Улсын Их, Бага хурлыг **Улаанбаатар** хотод хуралдуулан байвал зохино» гэжээ.

Тайлбар №1: 1921 онд Монгол Улс дахь пүүс компаниуд 234 байсан бол 1924 онд 635 болтлоо өссөн байв. Англи, Америкийнх 62, Хятад 462 байжээ.

Тайлбар №2: Марксист онолоор нийгэм нь хоорондоо эвлэршгүй зөрчил бүхий, эсрэг тэсрэг 2 ангид хуваагдах ёстой байдаг. 1924 оны Үндсэн хуулийн Нэгдүгээр бүлгийн заалтаар Монгол Улсад **жинхэнэ ард, жинхэнэ бус ард** гэсэн 2 ангийг ялган тодруулж өгсөн. Жинхэнэ бус ардад хөрөнгө чинээтэй хүмүүс болон лам нарыг багтаасан. Ийм ч учраас энэ Үндсэн хуулийн заалтын дагуу лам нарыг буудан алж, 1929 оноос өмчтэй хөрөнгөтэй хүмүүс, язгууртнуудын хөрөнгийг хурааж эхэлсэн байдаг.

Тайлбар №3: 1924 оны Үндсэн хуулиар төрийн **Шар хамбан туг нь улаан туг, Нийслэл хүрээ маань Улаанбаатар** нэртэй болж “бүх дэлхийд ялах ёстой” гэж тунхагласан улаан коммунизм Хөх Монголд довтлон орж ирсэн юм.

Тайлбар №4: Монголчууд 1920-иод онд **ардын эрхтэй хэмжээт цаазат** Засгийг хүсэж байв. Харин Оросын Коммунист большевик нам, коминтерний төлөөлөгчид Монголд **Ардын эрхт Бүгд Найрамдах Засаглал** тогтоохыг хүсч байснаас зөрчилдөөн үүсч улмаар цуст тэмцэл өрнөн, олон эх орончдын амь үрэгдсэнээр коммунист үзэл сурталд нийцүүлсэн Үндсэн хууль, коммунист засаглал Монголд тогтсон байна. Тийм ч учраас энэ Үндсэн хуулийг баталсны өдөр болон баяр болгон тэмдэглэдэг өдрүүдэд манай төр засгийн тэргүүн байсан боловч эсэргүүн дайсанд тооцогдсон, өөрөөр хэлбэл **“жинхэнэ ардын засгийн”** эсрэг үзэл бодолтой байсан хүмүүсийг цаазаар авсан байдаг. Тухайлбал: 1937 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Ерөнхий сайд П.Гэндэнг 1940 оны 7 дугаар сарын 25-нд Улсын Бага хурлын орлогч дарга Д.Лосол /ардын хувьсгалыг санаачилсан анхны долоон хүний нэг/-ыг, 1941.07.10-нд Монгол Улсын Ерөнхий сайд А.Амарыг, 1941.07.27-нд Улсын Бага хурлын дарга, бичгийн их хүн Д.Догсом /хувьсгалын анхны долоон хүний нэг/-ыг, 1941.07.27-нд Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга Д.Лувсаншаравыг, 1941.07.07-нд Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга Ө.Бадрахыг тус тус ЗХУ-д цаазласан билээ.

Тайлбар №5: Монгол Улс олон жил коммунизм руу хүчээр чихэгдэн орсон **хар өдөр** буюу жил бүрийн 11 дүгээр сарын 26-ны өдрийг бүх нийтийн баярын өдөр хэмээн тэмдэглэж ирсэнийг өөрчилж, харин 2011 оноос эхлэн 1911 оны 12 дугаар сарын 29-ны өдрийг Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо олж авсан баярын өдөр болгон тэмдэглэх болсон билээ.

Тайлбар №6: 1924 оны Үндсэн хуулийг баталсаны дараа 1925 оны 3 дугаар сарын 7-9-ний өдрүүдэд МАХН-ын Төв Хорооны бүгд хурал хуралдаж дор дурьдсан шийдвэрүүд гаргажээ. Үүнд:

1. Монгол Ардын Намын нэрийг Монгол Ардын Хувьсгалт Нам гэж өөрчлөх
2. Дээрхи шийдвэртэй холбогдуулж МАХН-ын шинэ мөрийн хөтөлбөр, дүрмийг төслүүдийг Коминтерн-д хүргүүлж засварлуулах, улмаар МАХН-ын IV их хурлаар батлуулах
3. МАХН-ыг ариутган цэвэрлэх явдлыг үүсгэн явуулах/намд үгээгүй, ядуу ардуудыг олноор нь элсүүлэх/
4. Ардын журамт цэргийг Ардын улаан цэрэг гэж нэрлэх
5. Марксын онол суртлыг түгээх, залуучуудыг боловсруулваас зүйтэй гэжээ.

Тайлбар №7: 1924 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн намын Төв Хорооны тэргүүлэгчдийн хурлаар **“Аливаа улсын дээд албыг хүлээсэн гишүүдийг Намын Төв Хорооны гишүүд захирна”** гэсэн тогтоол гаргажээ. Энэ шийдвэр нь хэрэг дээрээ МАХН-д хязгааргүй эрх мэдэл олгож, түүнийг төр засгийн бүх байгууллагуудын дээрх байгууллага болоход хүргэсэн байна. Мөн 1924 онд хуралдсан тус намын III их хурлын тогтоолын 4 дүгээр зүйлд **“...Манай ардын намаас өөр нам гаргаж үл болно.”** хэмээн заажээ. Тэгвэл, Ж.Цэвээн, Д.Бодоо нарын бичсэн Үндсэн хуулийн эх бидэнд байна. Тухайлбал, Д.Бодоогийн бичсэн **“Хэмжээт засагтай, Монгол Ард Улсын Үндсэн Хууль”-д:**

«Хоёрдугаар бүлэг. Ардын эрх ба үүргийн тухай.

Аравдугаар зүйл. Монгол ард хэн ч болов хуучин эрх чөлөө, заншилаа эдлэхээс гадна сонгон хэрэглэхүйд нийлэлдэх эрдэм явдал буй бөгөөс бичиг цэргийн их тушаал ба бусад ямар ч албанд орж болно.

Арваннэгдүгээр зүйл. Монгол ард өөртөө засах журмыг яаж хэрэглэх явдлыг тусгаар хуулинд заан гаргамуй.

Арванхоёрдугаар зүйл. Монгол ард өөр өөрийн хөдлөх ба хөдлөхгүй хөрөнгийг эдлэх эрх буй. Гагцхүү тогтоосон хууль ёсоор албан татварыг хураалгаваас зохино.

Арвангуравдугаар зүйл. Монгол ард гагцаар буюу олноор нэр нийлж өөр өөрийн эрх ашгийг дэлгэрүүлэх бодлого гаргаж дээд газар өргөн мэдүүлэх эрх буй. Гагцхүү улсын хууль зөрчих ба захиргаанаас тогтоож үл болно.

Арвандөрөвдүгээр зүйл. Монгол ардууд шашин шүтлэгийг олны амгалан түвшинд нийлүүлж, ардын үүрэгт үл харшлахаар хэмжээг тогтоож шашин мөргөлийн шүтлэгийг үйлдэх эрх чөлөө олгомой.

Арвантавдугаар зүйл. Монгол ардуудыг хуулийн гадна зоримогоор барьж хорих ба гянданд хаах буюу орон нутгаас үлдэн хөөх хийгээд нэрийг нь гутааж доромжилбоос үл болно.

Арванзургадугаар зүйл. Монгол ард хэн болов улс төрийн хэргийг сайжруулах зэргийн санал гаргаж цугларан хэлэлцэх ба хоршоо байгуулах эрх буй. Гагцхүү тэрслүү хортой санаа агуулах хоршоо, нам байгуулах ба зэр зэвсэг барьж эсэргүүцэх зэргийн хэрэг гаргаж үл болмой» гэжээ. Эдгээрээс үзвэл Д.Бодоогийн бичсэн “Үндсэн хууль”-ийн төсөл харин ч ардчилсан агуулгатай, хүний эрхийг дээдэлсэн хууль байсан нь тов тодорхой байна. Тэгвэл бидний шагшин магтаж, бахархан ярьж байсан 1924 оны Үндсэн хууль, харь орноос орчуулагдан, улмаар монголын ард түмэнд хүчээр тулган хүлээлгэсэн, ангийн үл эвлэрэх хагарал, тэмцлийг хуульчилсан, энэ утгаараа **“Хуульчилсан төрийн эргэлт”** хийх

үндсийг бүрдүүлсэн хууль байжээ. Асуудлын зангилаа ийнхүү тайлагдаж, монгол түмнийг хөнөөх “дүүжлүүрийн гогцоо” бэлтгэгдсэн нь илт байхад түмэн олондоо аюумшигт хэлмэгдүүлэлтийн эх үндэс, үйл явцын талаар анхнаас нь зөв ойлголтыг өгөөгүй өдий хүрсэн нь үеийн төрийн буруу юу?, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын оомиссийн үйл ажиллагааны арга менежментийн буруу юу?, Чухам юу гэж ойлгох вэ?

Хоёр. Иргэдээ хөнөөн хэлмэгдүүлсэн эрх зүйн акт, баримт болон үйл явц

1921 онд “Саж ламын хэрэг” гэгчээр эхэлсэн хэлмэгдүүлэлт цаашлаад **1922** оны 1 дүгээр сарын 7-нд Ерөнхий сайд Д.Бодоо албан тушаалаасаа чөлөөлөгдөх өргөдлөө өгч, улмаар мал маллаж, жирийн амьдралд байхад нь дуудан авчирч, 1922 оны 8 дугаар сарын 31-нд Шар хадны энгэрт 14 хүний хамт буудан хороосноор хэлмэгдүүлэлтийн өрнөл өөрийн өнгө, төрхөө улам боловсронгуй болгож, улаан коммунистууд ангийн тэмцэлд ханцуй шамлан орсон байна. Хэлмэгдүүлэлтийн эзэн, түүний гаргасан хар мөрт шийдвэрүүдийн он дараалал, учруулсан гай, гамшгийн заримыг тоймлон харцгаая, анхаарагтун:

- **1925 он.** МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчдийн хурлаар “Намын шалган цэвэрлэх комисс” байгуулан “анги ялгаварлах” бодлого хэрэгжүүлэх шийдвэр
- **1925 он.** МАХН-ын IV их хурлаар баталсан МАХН-ын програмд “хар, шар харгисуудын үлдэгдлийг бүрмөсөн устган арилгах” шийдвэр
- **1927 он.** МАХН-ын VI их хурал “...Нам улсын байгууллагад хуучин феодал, харгис түшмэдийн этгээдийг олноор нь шургалуулан бузарлаж байгаа... Баруун оппортунизмын эсрэг шийдвэртэй тэмцэн устгах...” шийдвэр
- **1928 он.** МАХН-ын VII их хурал “феодалын эдийн засагт халдаж, тэдгээрийн хөрөнгийг хурааж, ангийн хувьд устгах бодлогод шууд шилжих...” шийдвэр
- **1929 он.** Төв Хорооны II бүгд хурал “Хоосон ядууст ван гүн, хутагт лам нар зэрэг баячуудын хөрөнгийг шилжүүлэн эдлүүлэх” шийдвэр,
- **1932 оны 7 сар** хүртэл 1300 хар, шар феодал түшмэдээс 10 сая орчим төгрөгийн хөрөнгө хурааж “МАХН-ын програмд буй “...феодалын өмчийг хурааснаар феодалын ангийг бүрмөсөн устгав.” гэх дүгнэлт
- **1930 он.** МАХН-ын VIII их хурал “...Лам нарын талаар анги ялгаварлах бодлогыг улам нарийвчлан явуулах буддын шашны хуурамч чанар, харгис ролийг... таниулж, шашны эсрэг суртал нэвтрүүлэг өргөн явуулах” шийдвэр

- **1930 он.** “Богд хааны хойт дүрээр тодорсон Сэлэнгэ аймгийн Цэнджавын хүү Лувсандоржийн хэрэг”
- **1931 он.** МАХН-ын Төв Хорооноос “хар шар феодалууд ба харгис толгой лам нарыг 1931 оны дотор хурдан түргэнээр явуулж тус намын IX их хурлыг хүртэл үндсэн дор устгах”-ыг хууль, хяналт, хүчний байгууллагуудад даалгасан нууц тогтоол, Егүзэр хутагт Галсандаш, Манзушир хутагт Цэрэндорж, Дилав хутагт Жамсроанжав нарын “38-ын хэрэг”
- **1932 он.** МАХН-ын Төв Хороо, Төв Хянан Байцаах Комиссын хавсарсан III онц бүгд хурал “феодал ангийг ангийн хувьд устгах, харгис дээд лам нарыг шууд дайсанд үзэж бут цохих...Эсэргүү бослогыг бут цохих...” шийдвэр, З.Шижээ, Ө.Бадрах, Л.Лааган, Л.Цэндсүрэн нарыг МАХН-ын удирдлагаас зайлуулсан үйл явц, Ёнзон хамба Лувсанхаймчиг, Дэд хамба Дамдин нарын “Хувьсгалын эсэргүү лам нарын хэрэг”
- **1934 он.** Монгол угсаатны зарим хэсгийг яргалан устгасан “Лхүмбийн хэрэг”
- **1936 оны** МАХН-ын Төв Хорооны II бүгд хурлын тогтоол, “Жижиг хөрөнгөтний баян чинээлэг хэсгийн ашиг сонирхлыг илэрхийлэгч” П.Гэндэн нарын хэрэг
- **МАХН-ын “Онцгой Бүрэн Эрхт Комисс”** 1937 оны 10 дугаар сард байгуулсан тогтоол, тус комисс 1939 оны 4 сарын 22-ны өдөр хүртэл ажиллахдаа нийт 50 удаа хуралдаж, 25437 хүнийг шүүн 20099 хүнд цаазаар авах ял оногдуулсан хэрэг
- **1937 он.** П.Гэндэн, Д.Дэмидийн “Хувьсгалын эсэргүү хэрэг”
- **1939 он.** Ардын Сайд нарын Зөвлөлийн 1939 оны 12 сарын 1-ний өдрийн **“Тусгай Комисс”** байгуулсан тухай тогтоол, тус комисс байгуулагдаад 1939 онд 78 хүнийг, 1940 онд 42 хүнийг, 1941 онд 86 хүнийг хэлмэгдүүлсний дийлэнхийг ЗХУ-д /хуучин нэрээр/ шийтгүүлэн хөнөөсөн хэрэг
- **1939 он.** А.Амар, Д.Лувсаншарав нарын хэрэг
- **1940 он.** “Зүүн аймаг, Сүхбаатар аймгийн малчдын хэрэг”
- **1942 он.** МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчдийн “...зодох ба занчиж болох эрх, зөвшөөрлийг Дотоод явдлын яамны сайд нөхөр Шагдаржавын өөрийн хариуцлагад хатуу даалган өгсүгэй” гэсэн тогтоол
- **1944 он.** “Хүүхэн хутагтын хойт дүрээр тодорсон Хэнтийн мэргэн жаал Ламаадангийн хэрэг”

- **1947 он.** Порт-Артурын хэрэг
- **1956 он.** МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны “Манай намын бодлогод харш үзэл санаа, үг өгүүлэл гарч байгаа тухай” 413 дугаар тогтоол, “Сэхээтний төөрөгдөл” гэх хэрэг
- **1956, 1958, 1962, 1963** оны МАХН-ын Төв Хорооны IY, II, III, Y бүгд хурлын тогтоолууд, нам төрийн зүтгэлтэн Д.Дамба, Д.Төмөр-Очир, Л.Цэнд Ч.Сүрэнжав нарын хэрэг
- **1964 он.** МАХН-ын Төв Хорооны YI бүгд хурлын тогтоол, Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нар “намын эсрэг бүлэглэсэн явуулга хийсэн тухай” хэрэг.

Энэхүү жагсаалтаас ардын хувьсгалын жилүүдэд монгол түмнээ хэлмэгдүүлэн хөнөөсөн эзэн нь Монгол Ардын Хувьсгалт нам гэдэг улс төрийн байгууллага болохыг төвөггүй харж болно. Тус нам 2008 онд Монгол Ардын Хувьсгалт нам гэдэг нэрээ 1921-1924 онд хэрэглэж байсан Монгол Ардын нам гэдэг уугуул нэрээрээ сольж, хуучин нэрээ сэргээсэн билээ. Тус намын энэхүү үйлдэл 1921-1990-ээд он хүртэл үйлдсэн гэмт хэргээсээ бултан зугтаах гэхээсээ илүү, үйлдсэн нүгэл хилэнцээ хүлээн зөвшөөрөх, монголын ардчилсан сонголтыг хүлээн зөвшөөрч, өөрийгөө үзэл санаа үйл хэргийн хувьд бүрэн шинэчлэхэд чиглэсэн байгаасай. Өөрийгөө хэн гэж нэрлэх нь тухайн нам хүчний хувийн асуудал. Гэхдээ тус нам өөрийгөө яаж ч нэрлээд XX зуунд үйлдсэн сайн, муу үйл хэргээсээ зугтааж чадахгүй. Үүнийг өнөөгийн нийгэм зөвшөөрөхгүй.

Бид асуудлыг ийнхүү хөндөхдөө хэн нэг улс төрийн хүчнийг магтан мандуулах, эсвэл гутаан харлуулах зорилго өвөрлөсөнгүй. Гагцхүү хүн төрөлхтөний түүхэнд ховор тохиолдох яргалал, эрдэнэт хүмүүн бие биеэ хөнөөх гэмт хэрэг үйлдэхдээ ялалт байгуулж, гавьяа бүтээж байна хэмээн тархи мэдрэл нь 180 хэм эргэсэн хэнээрхэгчдийн төөрөгдөл дахин давтагдахгүй байх дархлаа бий болгох зайлшгүй хэрэгцээ байгааг л хэлэх гэсэн хэрэг.

Гурав. Цагаатгах үйл ажиллагааны эхлэл, өрнөл, сулрал

МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчдийн хурлаар ДЯЯ-ны ажлыг авч хэлэлцээд 1939 оны 4 дүгээр сард 15 дугаар тогтоол гаргаж улс төрийн хэрэгт шийтгэгдсэн хүмүүсийн хэргийг дахин хянан үзэх шийдвэр гаргажээ. Энэхүү шийдвэрийн дагуу 1939 оны хавраас мөрдөнд болон хоригдож ял эдэлж байсан хүмүүст холбогдох хэргийг Тусгай комиссоор хэлэлцүүлэн дахин хянаж, суллан тавьж эхэлсэн боловч энэ ажлын эрч саарсаар эх орны дайн эхэлсэн болон бусад шалтгааны улмаас үндсэндээ зогссон бөгөөд энд хэлмэгдүүлэлт, завхрал эхлүүлсэн, хэрэгжүүлсэн хүмүүс энэ

ажлыг зогсооход нөлөөлсөн баримт одоо ч байна. Ялангуяа социализмд аюул учирч фашизмтай үхэх сэхэхээ үзэн тэмцэлдэж байхад ардын дайсан, гадаадын тагнуул гэгдэн шийтгэгдсэн хүмүүсийг цагаатгах явдал байж болшгүй зүйл хэмээн үзэх хүн ялангуяа ДЯЯ-нд олон байсан бололтой. Цагаатгах ажлын сураг чимээ ийнхүү нилээд хугацаад тасарсан бөгөөд харин 1956 онд дахин сонсогдож эхэлсэн байна. Тэр үед буюу 1956 оны 2 дугаар сард ЗХУКН-ын XX их хурал, мөн оны 4 дүгээр сард МАХН-ын Төв Хорооны IV бүгд хурал хуралдаж, бие хүнийг тахин шүтэж байсны уршгаар нэг хүнд хэт их эрх мэдэл төвлөрч, хууль ёс зөрчигдөж, олон тооны гэмгүй иргэд, шудрага хүмүүсийг хэлмэгдүүлж байсныг илчлээд байсан үе юм. Ийнхүү 1956 онд ДЯЯ-ны ажилд гарч байсан алдаа завхралыг илрүүлэн засах Ширэндэв даргатай комисс байгуулагдаж хэдэн сар ажиллаад цагаатгалын асуудал эрхлэх байнгын ажиллагаатай комисс байгуулах, 36 хүнд холбогдох хэргийг цагаатгах санал тавьжээ. Энэ саналын дагуу 1957 оны 7 дугаар сард АИХ-ын Тэргүүлэгчдийн дэргэд Цагаатгах комисс байгуулан ажиллуулжээ. Тус комисс 6 жил шахам ажиллахдаа 700 орчим хүний хэргийг цагаатгасан байна. Үүнтэй зэрэгцэн 1959 оны 3 дугаар сард хуралдсан Намын Төв Хорооны III бүгд хурлаар Намын Хянан Шалгах Хорооны даргаар сонгогдсон Т.Гэндэн, 1930-1940-өөд онд “ардын хувьсгалын эсэргүүн”, “нам, засгийн дайсан” гэгч хэргүүдэд баривчлагдаж шийтгэгдсэн 40-өөд мянган хүн, үнэхээр хувьсгалын эсэргүүчүүд, ард түмнээсээ урвагчид, гадаадын тагнуул, төлөөлөгчид болчихсон хүмүүс мөн эсэхийг шалган тогтоох саналыг 1959 онд Намын Төв Хороонд оруулснаар “цагаатгал” нэртэй ажлын эрчийг нэмэхэд хувь нэмрээ оруулжээ. Ингээд Намын Хянан Шалгах Хорооны дарга, Дээд Шүүхийн дарга, Ерөнхий прокурор, Сайд нарын Зөвлөлийн Хуулийн хорооны дарга, Улсыг Аюулаас Хамгаалах Газрын дарга /хожим Сайд нарын Зөвлөлийн орлогч даргаар солигдсон/, Нийгмийг Аюулаас Хамгаалах Яам (НАХЯ гэх)ны шалгах хэлтсийн дарга нарын бүрэлдэхүүнтэй Намын Төв Хорооны шалгалтын комисс Т.Гэндэнгээр даргалуулан байгуулагдаж, тус комисс НАХЯ-ны Шалгах хэлтэст тулгуурлан 1959-1961 онд уг асуудлаар тусгайлсан ажлыг эхлүүлж, гүйцэтгэсэн байна. Тус комиссын шалгалтаар Лхүмбийн, Ёнзон хамбын, Гэндэн-Дэмидийн гэх зэрэг хувьсгалын эсэргүү байгууллага, бүлэг, Монгол Улсад огт байгаагүй, “хувьсгалын эсэргүүнүүд” гэгдэгчид үнэхээр ард түмнээсээ урвагчид, Японы тагнуул, төлөөлөгчид болсон байсан бус, гагцхүү Х.Чойбалсангийн хатуу дарамтад орсон Монголын аюулаас хамгаалах байгууллага хуулийг ноцтой завхруулж, хүмүүсийг үй олноор нь хилсдүүлэн хэлмэгдүүлж байсныг; хэлмэгдэгчдийг айлган сүрдүүлэх, зодож занчих, тарчлаан зовоох, тамлан туйлдуулах, “орос” аргаар хилс, зохиомол хэргийг хүлээлгэн, хүмүүсийг бууддаг байсныг; тэр завхралын жинхэнэ эзэн нь Оросын большевикчид, Сталины монгол дахь дуулгавартай гар хөл болон хувирсан улсын маршал Х.Чойбалсан

байсныг тодорхой баримтуудаар нотлон тогтоосон дүгнэлтийг хийжээ. Тус комисс 1930-1940-өөд оны их хядлага, яргаллын үед төр засгийн бүх эрхийг дангаар барьж байсан МАХН гэмт халдлагаас ард олноо хамгаалах талаар юу хийж, ямар үүрэг хариуцлагатай байсныг бүрэн дүүрэн гаргаж хэлж чадаагүйг онцлон тэмдэглэж байна. Харин Дотоод явдлын яам (ДЯЯ гэх)-ны үйлдсэн гэх алдаа завхрал, хэлмэгдүүлэлтийн талаар тодорхой баримтуудад түшиглэн түүхэн үнэнийг гаргаж ирсэнээрээ ач холбогдолтой болжээ. Тэр үед шалгалтын комисс “ДЯЯ намын хяналтаас гарч, намын дээр гарах болсноос л хэлмэгдүүлэлт явагдсан” мэт ташаа дүгнэлтийг хийж байжээ. Шалгалтын тайланг МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоо 1962 оны хаалттай хуралдаанаараа хэлэлцэж, мөн хоёр хоногийн дараа болсон Намын Төв Хорооны бүгд хурал бас хаалттай хуралдаанаар хэлэлцэж, аргагүй тодорхой баримт нотолгоонууд бүхий энэ шалгалтын дүнг МАХН албан ёсоор хүлээн зөвшөөрсөн байдаг. Гэвч улс төрийн хэлмэгдүүлэлтийн учир шалтгааныг бүрхэгдүүлж, гол гэм бурууг Дотоод Яамны сайд байсан Х.Чойбалсанд үүрүүлэн өнгөрөөжээ. Шалгалтын дүнгийн тухай мэдээллийг олон нийтэд хүргээгүй, зөвхөн МАХН-ын дээд шатны удирдлагын цөөн хүнд сонсгосноор хязгаарлаж, уг материал олон түмнээс нууцлагдан дарагдсан байна. Ийнхүү цагаатгалын ажил нилээд эрчимжиж ирсэн боловч иргэдээ анги ялгаварлан хөнөөх МАХН-ын ангийн тэмцлийн үзэл хэвээр байсан явдал цагаатгалыг цаашид өргөжүүлэн явуулах боломжгүй байдалд хүргэсэн байна. МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1960 оны 17 дугаар тогтоолд ангийн хувьд зайлшгүй шийтгэгдэх ёстой хүмүүсийг цагаатгах боломжгүй гэж үзсэн бөгөөд мөн МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1963 оны 22 дугаар тогтоолд “МАХН-ын Төв Хорооны санаачлагаар сүүлийн жилүүдэд үргэлжлэн явуулсан судалгаа шалгалтын дүнд 1930, 1940/50/-иад онуудад төрийн эсрэг онц аюултай гэмт хэрэгт холбогдон ихэвчлэн бүлгээрээ хамтран шийтгүүлсэн хүмүүсийн хэргийн төлөв байдал нь тогтоогдсон” гэж дүгнэжээ. Өөрөөр хэлбэл МАХН “хар, шар фиодалууд”-ыг цагаатгахаас шууд татгалзжээ. Улмаар Улсыг Аюулаас Хамгаалах байгууллагын ажиллагаан дахь алдаа завхралаас болж хэлмэгдсэн хүмүүсийн хэргийг хэсэг бүлгээр нь шалгаж дуусгасан хэмээн үзэж, МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1962 оны 4 дүгээр тогтоолоор АИХ-ын Тэргүүлэгчдийн дэргэдэх цагаатгалын комиссыг татан буулгаж, цагаатгалын ажил зогссон байна. 1960-аад онд зогссон цагаатгалын ажил 1988 онд МАХН-ын Төв Хорооны комисс байгуулагдсанаар 3 дахь удаагаа сэргэжээ. Тун удалгүй монголын нийгмийн байгууллын үзэл баримтлал ул сууриараа өөрчлөгдөж, ардчилал, шинэчлэл эрчимтэй өрнөсөн үед буюу 1991 онд Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс /цаашид ЦАУЗБУК гэх/ байгуулагдаж хэлмэгдүүлэлтийн талаар бүрэн шинжлэн судлах, цагаатгах ажлыг шинэ шатанд гаргахаар ажиллаж

эхэлсэн. Аль ч үед түүхийн үнэнийг бодитой тогтоож олон түмэнд элдэв чимэг засваргүй хүргэнэ гэдэг амаргүй бөгөөд хариуцлагатай ажил. Энэ ажлыг олон жил залгуулж зүтгэж явсан Сампилноров гуай болон түүний хамтран зүтгэгчдэд талархал илэрхийлэх ёстой.

1939 оны 4 дүгээр сараас хойш өнөөг хүртлэх хугацаанд нийт 30 гаруй мянган иргэний хэрэг хилс болох нь хууль хяналтын байгууллагуудын шалгалтаар тогтоогдон цагаатгагдсан, нэр төр нь сэргээгдсэн, үүний 25.5 мянга нь ЦАУЗБУК-ын үед шийдэгджээ. 6600 хүний хэрэг материалыг эдүгээ шалгаж байгаа юм байна. 1998-2010 /эхний хагас/ онд гэм буруугүй атлаа хэлмэгдэж хохирсон иргэн, тэдний гэр бүл, үр хүүхэд, төрөл төрөгсөд нийт 17803 хүн 16.3 тэрбум төгрөгийг нөхөх олговор авсан нь нэг хүнд дунджаар 915600 төгрөг ногдож байна. 1991-2010/эхний хагас/ онд 9722 хүнд 110.8 сая төгрөгийн нэг удаагийн мөнгөн тэтгэмж /нэг хүнд дунджаар 11400 төг/, 470 хүнд 2.4 тэрбум төгрөгтэй тэнцэх үнэтэй орон сууц тус тус олгосон байна. Мөн хураагдсан хөрөнгөө нэхэмжилсэн 25 хэлмэгдэгчид 220 мянган төгрөг олгожээ. ЦАУЗБУК байгуулагдсан цагаасаа хойш 49 хөшөө, 114 суварга босгож, 17 музей байгуулж, 99 ном товхимол хэвлүүлж, 29 кино хийсэн буюу дэмжин тэтгэсэн хэмээн тайлагнажээ. Хэлмэгдэгсдийн дурсгалын гэрэлт хөшөөг 1994 онд босгосон. Хэлмэгдэгсдийн музей 1996 оны 9 дүгээр сарын 10-нд байгуулагдсан. “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай” Монгол Улсын хууль 1998 онд батлагдсан. Жил бүрийн 9 дүгээр сарын 10-ны өдрийг “Хэлмэгдэгчдийн дурсгалыг хүндэтгэх өдөр” болгон тэмдэглэж байх болсон. Эдгээр чухал арга хэмжээг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн идэвхтэй оролцоо, дэмжлэг түслалцаа жинтэй хувь нэмэр оруулсан билээ. Өмнө дурьдсан мэдээллүүдээс үзвэл цагаатгалын ажил зарим үр дүнд хүрчээ. Цагаатгалын комиссын хийж бүтээсэн олон жилийн ажлыг үгүйсгэх гэсэнгүй, гэхдээ энэ үр дүн хэлмэгдэгсдийн шаардлагыг хангаж байгаа юу? Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн дурсгал цагаан ном/1993/-д дурьдсанаар 1921-1953 оны хооронд төрийн эсрэг гэмт хэрэг 40 гаруй удаа гарч 80000 орчим хүн холбогдон хэлмэгдсэн баримжаа тооцоо буй гэжээ. 1953 оноос хойш энэ тоо ихээхэн нэмэгдэнэ. Хэлмэгдсэн хүмүүс эхнэр хүүхэд, эцэг эхтэй. Ер нь Монголд хэдэн хүн хэлмэгдсэн, эдгээрийн хэд нь амьд сэрүүн байна вэ? Цагаатгалын ажлыг ингэсгээд дуусгах хэрэг үү? Өмнө дурьдсанаар хэлмэгдсэн 30000 орчим хүнийг цагаатгаж, харин цагаадсан иргэн болон тэдний **төрөл төрөгсөд** 17803 хүнд нөхөх олговор олгосон гэжээ, бусдад нь хэзээ нөхөх олговор олгох вэ? Нэг өрх 5 ам бүлтэй гэвэл $30000 \times 5 / 150000$ хүн болно. Нэг хэлмэгдэгчид дунджаар 900000 төгрөгийн олговор, 11000 төгрөгийн тэтгэмж олгожээ. Энэ хөрөнгө тухайн хэлмэгдэгчид хэр тус нэмэр болох вэ?. Хэлмэгдэгчиддээ арай илүү зүйл хүртээж санаачлага

гаргаж байв уу? Ардын хувьсгалын жилүүдэд болж өнгөрсөн аймшигт аллага, таллага, хэлмэгдүүлэлтийн талаар олон түмэндээ, залуучууддаа, хойч үедээ системтэй мэдээлэл өгөх ажлыг яагаад санаачлахгүй, зохион байгуулахгүй байна вэ? Хэлмэгдүүлэлт, дахин давтагдахаас сэрэмжлэх талаар ЦАУЗБУК-оос өнгөрсөн хугацаанд ямар ажил зохион байгуулсан бэ? Цаашид хэлмэгдүүлэлт гарахгүй гэх баталгаа бий юу?

Гэмгүй иргэдээ үй олноор нь алан хядсан энэ гэмт хэрэг зөвхөн хэлмэгдүүлэлт байсан уу энэ асуудлаар ЦАУЗБУК-ын зүгээс эрх бүхий байгууллагад хандаж байв уу? гэх мэт олон асуудал хариу хүлээж байна.

МАН байгуулагдсаны 90 жилийн ойн баярын хуралд МАН-ын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд тавьсан илтгэлдээ "Их гүрнүүдийн геополитик, Коминтерн, Бүх холбоотын коммунист /Большевикуудын/ намын тулгалтаар хийсэн улс төрийн хэлмэгдүүлэлт Монгол орныг нөмөрч, энэ хэлмэгдүүлэлтэд хамгийн түрүүнд намын удирдлага, гишүүд өртөж, манай нам, төр, ард түмнийхээ хамт гашуун зовлон амссан. Улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртөн амь насаа алдсан, эд хөрөнгө, сэтгэл санаагаар хохирсон иргэд, албан хаагчид, цэргийн дарга нар, лам хуврага, **намынхаа гишүүдийн ах, дүү, төрөл төрөгсөд, үр, ач нарт** гүн эмгэнэл илэрхийлж, хэлмэгдүүлэлтийг таслан зогсоох, газар авхуулахгүй байх талаар хүчин мөхөстсөндөө ард түмнээсээ МАН дахин уучлалт хүсч байна...**Хэлмэгдэгсдийг цагаатгах ажил үргэлжилж, одоо үндсэндээ шувтарч байна**" гэжээ.

Дөрөв. Цагаатгах үйл ажиллагаанд хийх үнэлэлт, дүгнэлт, зорилт

Цагаатгалын үйл ажиллагааны байдлыг тоймлон авч үзлээ. Монгол хүн чонын сүрэгт боорлуулсан эзэнгүй сүрэг шиг арга тасарч, алуулж талуулж ирсэн аймшигт үзэгдэл түүхийн хог дээр нэгэнт хаягджээ. Монгол оронд ардчилал шудрага ёс тогтож, төлөвшиж байна. Монгол Улс хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн хүнлэг ардчилсан, иргэний нийгэм байгуулах шинэ сонголтоо бүх нийтээрээ хүлээн зөвшөөрч хэрэгжүүлж эхлэв. Гэвч ажилгүйдэл ядуурал байсаар байна. Эрх мэдэл, албан тушаал ашиглан гэмт хэрэг үйлдэх явдал ноцтой түвшинд хүрчээ. Хэлмэгдүүлэлт давтагдахаас бүх талаар сэрэмжлэх, үүний тулд бүхий л мэдээллийг нээлттэй болгох шаардлагатай байна. Насанд хүрсэн 5 эр хүн бүрийнхээ 1-ийг буудан алсан гэм нүгэлтнүүд улс төрийн тавцанд нөлөөтэй хэвээрээ явсаар өнөөдрийг хүрсэн. Тэд үйлдсэн жигшүүрт хэргээсээ бултан тойрч, илрүүлэх илчлэх, сэргээх сэдрээх замыг хамаг хүчээрээ хааж ирсэн. Цагаатгалын комиссын ажил урагшлахгүй байсан нэг ноцтой шалтгаан чухамхүү үүнд оршиж байсан. Монголын шинэ төрд хэлмэгдүүлэлтийг далдлах, халхлах шалтгаан байхгүй баймаар. Энэ хэрэгт одоо зоримог

шинэчлэл, санаачлага шаардагдаж байна. Хүний заяагдмал болон олдмол эрх хаа сайгүй зөрчигдсөөр байна. Зөрчил хэтэрвэл дур зоргын үйлдэл буюу анархизмд халтиран орж болзошгүй. Монгол хүмүүний хамгаалалт бэхжиж чадаагүй, хэврэг хэвээрээ байна. Хэлмэгдүүлэлт давтагдсаар цаашид ч үргэлжилсээр байх төлөв, хандлагатай байна. Цагаатгалын комиссыг татан буулгах биш, ажлынх нь үр өгөөжийг улам эрчимжүүлэх, олон нийтийн үүсгэл санаачлагын байгууллагууд иргэдтэй нягт хамтран ажиллах явдал чухал байна. Хэлмэгдэгсэдийн шарх эдгэрээгүй, шаналсаар байна. Хэлмэгдэгсэд тэдгээрийн гэр бүл, үр хүүхдүүд бол нэгд, хамаг хөрөнгөө дээрэмдүүлсэн, хураалгасан ядуу хүмүүс; хоёрт, эмнэлгийн тусламж авах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ хасуулсаны улмаас өвчин зовлонд баригдсан, эрэмдэг зэрэмдэг болж үлдсэн хүмүүс; гуравт, үе удмаараа мэдээллээс таслагдаж, мэдлэг боловсрол олох ямар ч боломжгүй нөхцөлд хамаг амьдралаа үдсэн хүмүүс; дөрөвт, байнгын хардлага, хавчилт, мөрдлөгө хяналтын дор явж, бүхимдаж цөхөрсөн, элэгдэж эмтэрсэн хөөрхий хүмүүс; тавд, энд дурьдсан бүхний эцэст хатаагдаж ширээгдсэн, харин гэм нүгэл үйлдээгүйгээ мэдэхийн учир хугарч нугараагүй, босоогоороо үлдсэн эгэл баатрууд. Эдгээр хүмүүст шинэ цагийн Монголын төр бүх талаар туслах шаардлагатай байна. Цагаатгалын ажил 1991 оноос өмнө эрч далайцтай хэрэгжих бололцоогүй байжээ. Учир нь тэр үед ангийн тэмцлийн онолд суурилсан улс төрийн бодлого хэрэгжиж байв. Эрх баригч МАХН “жинхэнэ ард”-аас бусад нийгмийн давхрагыг дайсан хэмээн үздэг байв. Хөрөнгө чинээтэй хүмүүс, лам нар, сурвалжит ноёд, түшмэл, тайж нар нэгэнт ангийн дайсан тул буудан алах ёстой байсан. МАХН, коминтерн болшевикуудтай нийлж ангийн тэмцлийг сайн зохион байгуулж хэрэгжүүлсэн билээ. МАХН-ын хувьд дайснаа цагаатгах, өршөөх, хамгаалах ямар ч боломжгүй. Нийгэмд ийм сэтгэлгээний үлдэгдэл одоо ч оршсоор байгаа нь болгоомжлох асуудал мөн. Цагаатгалын ажилд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгээс гадна эрх зүйн шаардлагатай орчныг бүрдүүлэх, үзэл бодлын шинэчлэлт хийх шаардлагатай байна. Дор дурьдсан саналыг толилуулж байна. Үүнд:

- Монгол улсын түүхэнд тохиолдсон эмгэнэлт, гутамшигт үйл явдал, бидний хэлж заншсанаар хэлмэгдүүлэлтийн эх сурвалж, хор уршиг, эзэн холбогдогчийг олон нийтэд ил тод зарлан мэдээлэх, хүүхэд, залуучууд, нийт иргэдийг хамарсан сургалт, суртачилгаа явуулах ажлыг шинэ шатанд гаргах
- Улс төрийн хилс, зохиомол хэргүүдийг хэрэг бүрээр судлаж, цагаатгах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх
- Монголын түүхийн өв соёл, сүм хийдүүд, эмгэнэлт дурсгалт газруудын байршилыг тогтоох, багана босгох, дурсгалт цогцолбор байгуулах

- Монгол Их Гүрний хаад, нэрт жанжингууд, Чингис хааны алтан ургийнхан, Монгол Улсын тусгаар тогтнолын төлөө тэмцэгч, төр нийгмийн зүтгэлтнүүдийн түүхэн танилцуулга бүтээж, сурталчилгааны ажлыг өргөн хүрээтэй зохион байгуулах
- 1932 оны “Зэвсэгт бослого”, ор сураггүй алга бологсдын асуудал болон барга, үзэмчиний олзлогдсон цэргүүдийн талаар судалгаа явуулж, цагаатгах талаар улс төрийн шийдвэр гаргах
- 1929-1932 онд феодал, лам нарын хөрөнгө хураах, 1932-1941 онд улс төрийн хилс хэрэгт холбогдогсдын хөрөнгө хураах, 1956-1959 онд нэгдэлжих хөдөлгөөний үеэр иргэдийн мал сүргийг нийгэмчлэх болон дахин нийгэмчлэх зэргээр ард иргэдийн хувийн өмч, хөрөнгөд халдаж, хураасан хэргийг нарийвчлан судалж, хохиролыг барагдуулах арга хэмжээ авах
- Тагнуулын Ерөнхий Газрын Тусгай Архивын баримт материалыг хуульд заасан журмын хүрээнд ил тод, нээлттэй болгох
- Үндэсний монгол бичиг үсгийг устгасан тухайн үеийн төр, засгийн шийдвэрийг хүчингүй болгох, энэ аугаа соёлыг “цагаатган” сэргээж, Олон Улсын “ЮНЕСКО”-ын өв соёлд бүртгүүлэн хамгаалах
- Хэлмэгдүүлэлт давтагдах улс төрийн шалтгааныг арилгахыг эрмэлзэх
- Улс төрийн хэлмэгдүүлэлтийн талаархи судалгааг тогтмол хийж, үр дүнгээр нь үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний бага хурал, чуулган зэргийг тогтмол зохион байгуулж байх
- Улс төрийн хэлмэгдэгдүүлэлтийн түүхэн зурагт фото альбом бүхий “Хар ном” хэвлэн гаргах
- Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын болон төрийн зарим ажил үйлчилгээг Монголын Улс Төрийн Хэлмэгдэгсдийн Холбоогоор гүйцэтгүүлэх боломжийг судлаж, хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх
- Монголын улс төрийн түүхийн судалгаа, түүх бичлэг, кино урлаг, хөшөө дурсгалыг үзэл сурталжсан, коммунист сэтгэлгээ, хэв загвараас ангижруулах урьд өмнө судалгаанд хамруулаагүй зориудаар үлдээсэн бүлэг асуудлуудыг нарийвчлан судалж “түүхийн хар толбо”-ыг арилгах
- Жил бүрийн 9 дүгээр сарын 10-ны өдөр хүний эрхийн асуудлын талаархи тайланг, төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд хэлэлцдэг журам тогтоож, энэ асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг гарган зохицуулах

- Олон Улсын Хүний Эрхийн Байгууллагын эрх зүйн хүрээнд Монгол Улсын Засгийн Газрын хүлээсэн үүрэг хариуцлагын үүднээс “Хүний Эрхийн Ордон” бүтээн байгуулах зэрэг болно.

Улс төрийн талаар хэлмэгдэгсдийг цагаатгаж, нэр төрийг нь сэргээх, хэлмэгдүүлэлт давтагдахаас урьдчилан сэргийлэх, иргэнд учруулсан хохиролыг нөхөн төлөх зэрэг асуудлуудыг зохицуулах хууль тогтоомжуудыг боловсронгуй болгох, холбогдох эрх зүйн орчин бүрдүүлэх явдал чухлаар шаардагдаж байна.

МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН ХЭЛМЭГДЭГСДИЙН ХОЛБОО

УЛС ТӨРИЙН ХЭЛМЭГДЭГСДИЙГ ЦАГААТГАХ АЖЛЫН ТАЛААР ТӨРӨӨС АВЧ БУЙ АРГА ХЭМЖЭЭ



Дэлэгчоймбалын Дамбасүрэн - Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нарийн бичгийн дарга

39

Эрхэмсэг хатагтай, ноёд оо

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс, Монголын улс төрийн хэлмэгдэгсдийн холбоо Конрад-Аденауэр-Сантай хамтран Монгол Улс, ХБНГУ дахь улс төрийн хэлмэгдүүлэлтийн асуудлаар бага хурал зохион байгуулж байгаа нь мэдээлэл, туршлага солилцох, хамтын ажиллагааг өргөжүүлэх ач холбогдолтой чухал ажил болно гэдэгт итгэлтэй байгаагаа онцлохын хамт энэ хурлыг зохион байгуулахад хичээл зүтгэл гаргасан ХБНГУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд ноён Герхард Тийдеманн, Конрад Аденауэр сангийн Суурин төлөөлөгч, доктор Даниел Шмюкинг, УИХ-ын дэд дарга, ЦАУЗБУК-ын дарга Логийн Цог, Монголын Улс Төрийн Хэлмэгдэгсдийн Холбооны тэргүүн Дашнамжилын Цогтбаатар нар болон бусад хүмүүст талархал илэрхийлье. Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн нэр төрийг сэргээн цагаатгах, хэлмэгдэгсэд болон тэдний гэр бүл, үр хүүхэд, ач, зээ нарт хуульд заасан нөхөх олговор олгох, хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг арилгах, хэлмэгдэгсдийн дурсгалыг мөнхжүүлэх, улс төрийн хэлмэгдүүлэлтийн хор уршгийг нийтэд таниулан сэрэмжлүүлэх ажиллагааг улс орны хэмжээнд зохион байгуулах гол чиг үүрэгтэй ажилладаг. Тус комисс хуульд заасны дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд ажлаа танилцуулж, удирдамж чиглэл авч ажилладаг.

Нэг. Улс төрийн хэлмэгдүүлэлт, түүний үе шат, онцлог

1922 онд Ерөнхий сайд С.Бодоо, Д.Чагдаржав нарын хэрэг гэгчээр эхэлж, С.Данзан, Баваасан нарын болон тайж Эрэгдэндагва, дилав хутагт Б.Жамсранжавын хэрэг гэгчээр үргэлжлэн, 1933 оны "Лхүмбийн хэрэг, 1937 оны П.Гэндэн, Г.Дэмид нарын хувьсгалын эсэргүү бүлгийн хэрэг гэгчээр дээд цэгтээ хүрч, 1939 онд А.Амар, Д.Лувсаншарав нарын бүлгийн хэрэг гэгчээр эрч далайц нь хумигдсан улс төрийн залхаан цээрлүүлэлт, хэлмэгдүүлэлт бол 20 дугаар зууны Монголын түүхэнд тохиолдсон аймшигт эмгэнэлт явдал юм.

1937 оны 9 дүгээр сарын 10-аас 1939 оны 4 дүгээр сар хүртэлх хугацаанд улс төрийн өргөн баривчилгаа явагдсан бөгөөд хувьсгалын эсэргүү, тагнуулын хэрэг гэгч улс төрийн хилс хэргийг хүчээр тулган хүлээлгэж байжээ. БНМАУ Япон зэрэг орныг түшиж өөрийнх нь нөлөөнөөс гарахаас ЗХУ болгоомжилж байсан бөгөөд энэ үзэл санаа тухайн үеийн сэхээтний давхаргын дийлэнхийг бүрдүүлж байсан нам засгийн удирдах албан тушаалтнууд, цэргийн дарга нар, лам нараас гарч болзошгүй гэж үзэж дарамт шахалт үзүүлж байсантай холбоотойгоор энэ ангилалд хамаарагдагчид улс төрийн хэлмэгдүүлэлтэд илүүтэй өртсөн байдаг. 1922-1990 оны хооронд гарсан улс төрийн хэлмэгдүүлэлтийг албан тушаал, анги давхарга, цаг хугацааны давтамжтайгаар авч үзвэл манай улсын түүхэн хөгжлийн эгзэгтэй цаг мөчүүд, улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын төлөөх үйл хэрэгтэй салшгүй холбогддог юм. Монгол оронд явагдсан улс төрийн хэлмэгдүүлэлтийг зорилго, шинж чанараар нь дараах байдлаар ангилан үзэж болно.

1.1922-1924 оны "Д.Бодоо, Д.Чагдаржав болон С.Данзан, Х.Баваасан нарын хэрэг"-25 хүнийг хэлмэгдүүлсэн хэрэг.

1922 онд Ардын засгийн газрын Ерөнхий сайд Д.Бодоог "Бүгд найрамдах засгийн эсрэг хэрэг" гэгчид холбогдуулан, гадаадын дайсан этгээдтэй сүлбээлдэн нийлж, ардын засгийг устган, эзэрхэг засгийг байгуулахаар зөвлөлдсөн, энэхүү хэрэг явдлаа нуун дарагдуулсан хэмээн үзэж цаазалсан нь Монгол Улсад улс төрийн хилс хэрэгт хэлмэгдүүлэх балмад явдлын эхлэл болсон юм. Мөн энэ хэрэгт саж лам Жамъянданзан нарын түвдүүд өртөж, хэлмэгдсэн.Мөн Монгол Улсын хөгжлийн талаар үзэл бодлоо илэрхийлж, түүнийгээ хамгаалж байсных нь төлөө Бүх цэргийн жанжин С.Данзан, Х.Баваасан нарыг 1924 онд цаазлан хороосон байдаг.

2. 1930 оны "Эрэгдэндагва тэргүүтэй 38-ын хэрэг"

Банчин богдтой холбоо тогтоохыг эрмэлзсэний учир 1930 онд ял шийтгүүлсэн тайж Эрэгдэндагва ардын засгийг устгахын тулд тусламж гуйх өргөдөл бичиж Банчин богдод хүргэж өгөхийг оролдсоныг далимдуулан энэ хэрэгт Егүзэр хутагт Галсандаш, Дилав хутагт Жамсранжав нарын

хутагт хувилгаадыг хилсээр холбогдуулан шийтгэжээ. Үүний гол зорилго нь эдгээр хутагтын нэрийг ашиглан нийт лам нарыг өргөн хүрээтэй хэлмэгдүүлэхэд оршиж байв. Энэ нь хожим бүр тодорхой илэрч байжээ.

3. 1933-1934 оны “Лхүмбийн хэрэг”-310 хүнийг хэлмэгдүүлсэн.

ЗХУ-ын Дотоодыг хамгаалах ардын комиссариатын газраас Монголд дагаар орсон буриад иргэдийг Зөвлөлтийн эсрэг ашиглагдаж болзошгүй хэмээн сэрдэж, “цагаантны эсэргүү үлдэгдэл” нэрийдлээр устгах зорилготойгоор 1933 оны хавар урьдчилан бэлтгэж, “Лхүмбийн толгойлсон япон тагнуулын байгууллага” гэгчийг зохиомлоор бий болгожээ. Лхүмбийн хэрэг гэгчид холбогдогчдыг Японы тагнуултай хуйвалдаж хувьсгалт засаг төрийг устгахыг завдсан хэмээн хоморголон баривчилж хэлмэгдүүлсэн байдаг.

4. 1937-1939 оны “Хувьсгалын эсэргүү, япон тагнуулын хэрэг” гэгч 26211 хүнийг хэлмэгдүүлсэн дуулиант хэрэг.

ЗХУ-ын тухайн үеийн удирдлага БНМАУ-ыг өөрийн нөлөөнд ямагт байлгах цэрэг-стратегийн зорилгын үүднээс “хувьсгалын эсэргүү, япон тагнуулын хэрэг” хэмээх хэргийг зохиомлоор бий болгон Монголын үндэсний хийгээд дэвшилтэт үзэл бүхий давхаргад хамаарах хүмүүсийг “хөдөлгөхгүй байх”, дарах устгах бодлогыг тодорхой бодлого чиглэл, үе шаттайгаар хэрэгжүүлж ирсний уршгаар улс орны удирдагчид, сэхээтнүүд, захиргааны болон цэргийн албан хаагчид, лам нар, энгийн иргэд зэрэг бүх давхаргынхан өртсөн юм. 1937-1939 оныг дамнан “Хуйвалдаан”, “14-ийн хэрэг”, “Гэндэн, Дэмидийн хэрэг”, “Амар, Лувсаншарав нарын хэрэг”, “Ёнзонхамба Лувсанхаймчиг, дэд хамба Дамдин нарын хэрэг”, “Комбинатын хэрэг” гэхчлэн үргэлжилсэн уг бүлэг хэрэг гэгчийг тус бүрээр нь авч үзвэл:

• “ЗАГОВОР” /ХУЙВАЛДААН/ ГЭГЧ ХЭРЭГ

ЗХУ-ын ДХАК-ын орлогч М.П.Фриновский, БХАК-ын орлогч П.Смирнов, ЗХУ-аас БНМАУ-д суух бүрэн эрхт элчин төлөөлөгч С.М.Миронов нарын бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид 1937 оны 8 дугаар сарын 24-д Улаанбаатарт ирж хувьсгалын эсэргүү, Японы тагнуулын байгууллагын гишүүн хэмээн БНМАУ-ын нам, төр, цэрэг, нийгмийн зүтгэлтэн 115 хүний нэрсийг гардуулж, баривчлахыг даалгажээ. Энэхүү “хэрэг”-ийг Зөвлөлтийн тал “Заговор” хэмээн нэрлэсэн байна. Энэ нь БНМАУ-ын Засгийн газартай урьдчилан тохиролцолгүйгээр Зөвлөлтийн цэргийг байрлуулахад үүсэх дургүйцлээс сэрэмжлэх, Зөвлөлтийн зааврыг дуулгавартай даган биелүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилготой байжээ. 1937 оны 9 дүгээр сарын 10-д дээр дурдсан 115 хүний 65-ыг нь баривчилснаар Монгол орныг бүхэлд нь хамарсан аймшигт залхаан цээрлүүлэлт шатлан өргөжсөн байдаг.

- “14-ИЙН ХЭРЭГ”

Нийтийг хамарсан баривчилгааны дараахан төр, засаг, цэргийн томоохон албан тушаалын 14 хүний хэргийг 1937 оны 10 дугаар сарын 18-21-д Улаанбаатар хотод олон нийтийн өмнө Улсын дээд шүүхийн нээлттэй хуралдаанаар анх удаа таслан шийтгэж байжээ. Энэхүү зохиомол хэрэгт МАХЦ-ийн Жанжин штабын дарга Ж.Малж, ЦЯЯ-ны сайдын болон Бүх цэргийн жанжны орлогч Л.Дарьзав, хуягт бригадын дарга Д.Жамъянжав, Бүх цэргийн хүн эмнэлгийн газрын дарга Л.Дэндэв, Цэргийн гар үйлдвэрийн дарга Б.Очирбат нарыг холбогдуулан цаазаар авах ялаар шийтгэсэн байна.

- “Гэндэн, Дэмидийн хувьсгалын эсэргүү, япон тагнуулын хэрэг”

Аж үйлдвэрийн комбинатад 1934-1935 онд гурван удаа гал гарсан хэргээр тус комбинатын дарга Р.Пүрэвийг баривчлан мөрдөн байцаахдаа 1936 онд нам, төрийн удирдах албан тушаалаас огцруулж, ЗХУ-д “сувилуулах”-аар явуулсан “П.Гэндэнгийн нөлөөнд орж комбинатыг шатаасан” хэмээх худал мэдүүлгийг гаргуулан авсан нь П.Гэндэн, Г.Дэмидийн хэрэг гэгчийн шалтаг болсон байна. П.Гэндэнг 1937 оны 7 дугаар сард Зөвлөлтийн Дотоод хэргийн ардын комиссариат баривчлан, түүнд Ж.Лхүмбийн “Япон тагнуулын байгууллага”-ын гишүүнээр 1932 оноос ажилласан тухай хэрэг тулган хүлээлгэж, хэргийн хань хамсаатан байсан гэж Г.Дэмид нарын удирдах дээд түвшний 35 хүний нэрийг гаргуулсан байна. Үүнийгээ “Заговор” хэргийн нэрсийн жагсаалтаар баталгаажуулжээ. Энэ бүгдээс үндэслэн ДЯЯ 1937 оны 9 дүгээр сараас нийтийн баривчилгаа явуулж, “Гэндэн-Дэмидийн япон тагнуулын хэрэг” гэгч зохимол хэргийг бий болгосон байдаг. Дашрамд дурдахад маршал Г.Дэмид 1937 оны 08 дугаар сарын 22-ны өдөр Сибирийн төмөр замын Тайга станцын ойролцоо галт тэргэнд учир битүүлгээр нас барсан байдаг. Тус хэрэгт холбогдуулан Ерөнхий сайд 2, Намын төв хорооны нарийн бичгийн дарга 2, Улсын Бага Хурлын дарга 2, яам, тусгай газрын сайд, дарга 98, Бүх цэргийн жанжны орлогч, Жанжин штабын дарга 4, корпус, дивизийн захирагч, сэхээтэн, энгийн иргэд зэрэг олон хүнийг баривчилсан байдаг. МАХЦ-ийн даргалах бүрэлдэхүүнээс өнөөгийн генерал цолтой дүйцүүлж болох бригад командлан захирагчаас маршал цолтой 78 дээд даргын 66 нь буюу 84,6 хувийг хэлмэгдүүлж, ихэнхийг нь хуулийн дээд хэмжээгээр шийтгэж, үлдсэнийг нь хорих ялаар шийтгэсэн байна. 1938 онд МАХЦ 14834 хүнтэй, үүний 1390 нь даргалах бүрэлдэхүүн байснаас 525 буюу 37,7 хувийг баривчлан ихэнхийг цаазалжээ.

- Ёнзонхамба буюу “лам нарын хувьсгалын эсэргүү, япон тагнуулын хэрэг”

Зөвлөлтийн удирдагчид өөрсдийн бодлогоо Монголд хэрэгжүүлэхэд саад болно хэмээн Монголын лам нарыг Японы тагнуулын байгууллагын “тавдугаар цуваа”, нөлөө бүхий лам нарыг Японы туршуулууд хэмээн сэжиглэж, тэднийг устгахыг тулган шаардаж байсан юм. Энэ хэрэгт 18700 гаруй лам нарыг хэлмэгдүүлснээс 17000-ыг нь буудан алах ялаар шийтгэжээ. Үүнээс гадна 1922-1990 оны хооронд шар феодал, шашнаар бусдыг мунхруулсан, өргөл барьц авсан зэрэг шалтаг үүсгэн санваартан жирийн лам нарыг хэлмэгдүүлж байжээ.

5. 1943 оны “Германы тагнуулын бүлэг хэрэг”

Дэлхийн хоёрдугаар дайн эхэлсний дараахан “Германы тагнуулын бүлэг хэрэг” гэгчийг бий болгон Германд суралцаж байсан хүмүүсийг хэлмэгдүүлсэн юм. Уг “хэргийг” 1943 оны 12 дугаар сард БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор шийдвэрлэж Н.Бат-Очирыг 25 жил, Д.Наваан-Юндэнг 20 жил, Т.Нацагдоржийг 10 жил, Д.Намдагийг 7 жил, Д.Гомбыг 8 жил, Г.Цэвээнийг 7 жил, С.Лхүндэвийг 3 жил хорихоор шийджээ.

6.1964-1990 оны “Намын эсрэг бүлэг, Сэхээтний төөрөгдөл, үндсэрхэг үзэл” гэгчээр нэр бүхий дэвшилтэт үзэлтэй сэхээтэн 202 хүнийг хэлмэгдүүлсэн байдаг.

Дээрх хүмүүс үзэл бодлоо илэрхийлснийхээ төлөө үндсэрхэг үзэлтэн, үгүйсгэгчид, төөрөлдөгчид гэхчлэн нэрлэгдэж, ял шийтгүүлсэн, нутаг заагдсан, ажил албан тушаалаасаа өөрчлөгдөн хэлмэгдсэн бөгөөд тэдний дотор сэхээтнүүд, эрдэмтэд, зохиолчид илүүтэй өртсөн юм. Иймэрхүү байдлаар 1922-1990 оны хооронд нийтдээ 35,0 мянга орчим хүн улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртсөн гэдэг баримжаа судалгаа байдаг.

Улс төрийн хэлмэгдүүлэлтийн явцад ЗХУ /хуучин нэрээр/-д монгол иргэд, Монголд амьдарч байгаад баригдаж хүргэгдсэн буриад иргэд нийт 349 хүн хэлмэгдэж цагаатгагдсаны дотор Монгол Улсын Ерөнхий сайдаар ажиллаж байсан П.Гэндэн, А.Амар нарын зэрэг төрийн засгийн өндөр албан тушаалтнууд цөөнгүй байдаг.

Хоёр. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах үйл ажиллагаа

ЗХУ-д улс төрийн хэлмэгдүүлэлт, түүний учир шалтгааныг авч үзэх болсны нөлөөгөөр Онцгой бүрэн эрхт комиссоор хорих ял шийтгүүлсэн хүмүүсийн хэргийг ДЯЯ-ны дэргэд байгуулагдсан Тусгай комиссоор 1939 оны 11 дүгээр сараас хэлэлцсэнээр хувьсгалын эсэргүү, тагнуулын хэрэг гэгчид холбогдон ял шийтгүүлсэн хүмүүсийг шалгаж цагаатгах ажил эхэлсэн юм.

Гэвч улс төрийн хэлмэгдүүлэлтэд хамгийн их өртсөн лам нарыг цагаатгах асуудал Монголд өөрчлөлт шинэчлэлтийн асуудал хөндөгдөж эхэлсэн 1988 оны төгсгөл хүртэл яригдаж байгаагүйг дурдах ёстой. Дотоод явдлын яамны дэргэдэх Тусгай комиссоос 1939 онд Монголын түүхэнд хар толбо болон бичигдсэн улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртсөн иргэдийн хэргийг шалгаж, суллаж эхэлснээр цагаатгалын ажлын үндэс суурь тавигдсан гэж үздэг. Түүхийн хувьд авч үзвэл 1939-1956 онд ДЯЯ-ны дэргэдэх Тусгай комисс, 1957-1962 онд Цагаатгах ажлыг эрхлэх комисс ажиллаж эхэлснээр тэр үеийн БНМАУ-ын Дээд шүүх, Улсын прокурорын газраас Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу цөөн тооны иргэдийг цагаатгасан байдаг.

Үүнийг тоогоор илэрхийлбэл:

- ДЯЯ-ны дэргэдэх Тусгай комисс 1939-1956 оны хооронд 1256 хүнийг,
- ЦАЭК 1956-1962 онд 532 хүнийг,
- БНМАУ-ын Дээд шүүх 1943-1989 онд 1115 хүнийг
- БНМАУ-ын Прокурорын газар 1942-1989 онд 23 хүнийг, нийтдээ 1939-1989 оны хооронд 2926 хүнийг цагаатгажээ.

Монгол Улс ардчилсан нийгэмд шилжсэний дараа буюу БНМАУ-ын Ерөнхийлөгчийн 1990 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 56 дугаар зарлигаар байгуулагдсан Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, Монгол Улсын Засгийн газрын тогтоол зэрэг эрхийн актыг үйл ажиллагаандаа баримтлан улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, хэлмэгдэгсдийн дурсгалыг мөнхжүүлэх, хэлмэгдүүлэлтийн хор уршгийг арилгах ажлыг өргөн хүрээнд зохион байгуулж ажилласнаар өнгөрсөн 25 жилийн хугацаанд цагаатгагдсан нийт иргэдийн 90 хувь буюу 28256 хүнийг цагаатгуулж нэр төрийг бүрэн сэргээгээд байна. Энэ дашрамд тус комиссын үндэс суурийг тавьсан Монгол Улсын анхны ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбат, ЦАУЗБУК-ын даргаар ажиллаж улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсан ноён Ц.Элбэгдорж, Р.Гончигдорж, Л.Цог, С.Оюун, Д.Лүндээжанцан, Н.Энхболд, Д.Ганболд, Ж.Бямбадорж, Д.Идэвхтэн, Ж.Гомбожав нарын төр, нийгмийн зүтгэлтнүүдэд талархал илэрхийлэх ёстой юм. УИХ-аас 1998 онд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийг баталснаар цагаатгах ажлын эрч далайц нэмэгдэх, улс төрийн хэлмэгдүүлэлтийн хор уршгийг арилгах ажилд тодорхой ахиц дэвшил гарах эрх зүйн үндэс бүрдсэн юм. Уг хуулийн 13 дугаар зүйлд хэлмэгдэгчид болон тэдний гэр бүлийнхэнд нэг удаагийн нөхөх олговрын 500,000-аас 1 сая төгрөг, 23 дугаар зүйлд амьд сэрүүн байгаа хэлмэгдэгч

болон нас барсан хэлмэгдэгчийн эхнэр /нөхөр/-т орон сууц олгох тухай заалт орсон хэлмэгдэгсэд болон тэдний гэр бүлийн амьдралд тус дэмтэй чухал шийдвэр болсон гэж үздэг. Цагаатгалын хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасан цагаатгуулах өргөдөл гаргах, 12 дугаар зүйлийн 12.3-т заасан нөхөх олговор нэхэмжлэх хугацааг УИХ-аас 2000, 2002, 2006, 2009 онд нийтдээ 4 удаа сунгасан хэдий ч цагаатгалын ажлыг хугацаа тогтоож шахах боломжгүй нарийн төвөгтэй ажил юм байна гэдэг нь өнгөрсөн 25 жилийн ажлаас тодорхой харагдаж байгаа юм. Тиймээс УИХ-ын дэд дарга, Улсын комиссын дарга хуулийн үйлчлэх хугацааг сунгуулахаар хуулийн төсөл боловсруулж УИХ-д өргөн барьсан бөгөөд холбогдох байнгын хорооны хуралдаанаас дэмжигдэж, УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэгдэх шатанд явж байгаа нь төр засгаас цагаатгалын ажлыг бүрэн гүйцэтгэх ёстой гэсэн байр суурь баримталж буйн илрэл юм. Цагаатгалын хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл Улсын комиссын ажлын тайланг 1995, 2000, 2014 онд хэлэлцэж үүрэг чиглэл өгснийг хэрэгжүүлэн ажиллаж ирсэн юм. Улсын комисс, түүний Ажлын алба, аймаг, нийслэлийн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Салбар комиссуудынхаа оролцоотойгоор хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийн төлөө чармайн ажиллаж ирсэн.

1. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн нэр төрийг сэргээн цагаатгах чиглэлээр:

Цагаатгалын хуулийн 4 дүгээр зүйлд 1922-1990 онд улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн асуудлыг шийдвэрлэхээр заасан байдаг. Тагнуулын ерөнхий газрын албан мэдээллээр, Монгол Улсад улс төрийн хэлмэгдүүлэлтэд 36,0 мянган хүн өртсөн бөгөөд 1939 оноос хойш өнөөг хүртэлх хугацаанд 31,208 хүн цагаатгагдаад байна. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 66/39 дүгээр зөвлөмжөөр өгсөн улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийг цагаатгаж дуусгах үүргийг хэрэгжүүлэх үүднээс Улсын комиссоос шүүх, прокурор, тагнуулын байгууллага, салбар комиссуудтайгаа хамтран төв, орон нутгийн архивуудад шалгагдаагүй хэргүүд байгаа эсэхийг тодруулах, илэрсэн хэргүүдийг татаж Тагнуулын ерөнхий газрын Тусгай архивт төвлөрүүлэх, цагаатгуулах ажлыг 2015 оноос зохион байгуулсны үр дүнд шалгагдаагүй 1352 хэрэг, хэлмэгдсэн гэх боловч хэрэг материал нь олдохгүй байгаа 922 хүний асуудал байгааг тогтоосон.

Улсын комисс ОХУ-ын холбогдох байгууллагуудтай хамтран ажилласны үр дүнд ЗХУ-д хэлмэгдсэн 349 хүний материалыг хуулбарлан авсан бөгөөд зогсонги байдалд ороод байгаа энэ ажлыг үргэлжлүүлж, тус улсад

хэлмэгдэгсдийн материалыг бүрэн авах шаардлагатай байгаа юм.

2. Хэлмэгдэгчид болон тэдний гэр бүлийнхэнд нөхөх олговор олгох ажлын чиглэлээр:

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль мөрдөгдөж эхэлснээс хойших 18 жилийн хугацаанд уг хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгч, тэдний гэр бүлийнхэн 18,0 мянга гаруй иргэнд 16 тэрбум 300 сая төгрөгийн нөхөх олговор, мөн хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу амьд сэрүүн байгаа хэлмэгдэгч, нас барсан хэлмэгдэгчийн эхнэр /нөхөр/ 153 иргэнд орон сууц, 198 иргэнд орон сууц орлосон мөнгөн олговор, 310 иргэнд 84 сая 370 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгоод байна. Төв, орон нутгийн салбар комиссууд өөрсдийн нөөц бололцоо, тухайн орон нутгийн аж ахуйн нэгжүүдийн дэмжлэг туслалцаатайгаар хэлмэгдэгчид болон тэдний гэр бүлийнхэн 14,328 иргэнд 214 сая 186 мянган төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлжээ. Одоо улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийн нөхөх олговрыг аваагүй 13,0 мянга орчим иргэн байгаагаас 1000 орчим нь нөхөх олговроо авахаар идэвхтэй хөөцөлдөж байна. Эдгээр иргэн хуульд заасан журмын дагуу нөхөх олговроо авахын тулд хэлмэгдэгчтэй садан төрлийн холбоотойг Үндэсний төв архивын хүн амын тооллогын баримтаар нотлуулах хэрэгтэй болдог бөгөөд иргэдэд энэ асуудлаа шийдвэрлэхэд нь туслах үүднээс Улсын комисс, Нийслэлийн салбар комиссын санхүүжилтээр гэрээт ажилтан ажиллуулсны үр дүнд 100 орчим иргэн хэлмэгдэгчийн үр хүүхэд, ач зээгээр тогтоогдож нөхөх олговроо авах боломжтой болоод байна.

3. Хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг арилгах чиглэлээр:

Монгол Улсын Их хурал 1996 онд жил бүрийн 9 дүгээр сарын 10-ны өдрийг улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр болгон орон даяар тэмдэглэж байхаар шийдвэрлэснээс хойш энэ өдрийг 20 дахь удаагаа тэмдэглэх гэж байна. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг мөнхжүүлэх зорилгын хүрээнд хэлмэгдэгсдийн намтрын 40 гаруй судалгааны товхимол, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, "Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн намтрын товчоон", баримт бичгийн эмхтгэл зэрэг 20 боть, Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалын "Цагаан ном"-ын I-IV /30378 хэлмэгдэгчийг багтаасан/ ботийг хэвлүүлэн нийтийн хүртээл болгоод байна. Улаанбаатар хот, орон нутагт болон ОХУ-ын Москва хотын Бутовод нийт хэлмэгдэгсдийн дурсгалд зориулсан 60 хөшөө, 134 суварга, 37 гэрэлт самбар, 31 дурсгалын багана босгосон байна. Түүнчлэн Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн музей ажиллаж байна. Мөн орон нутгийн музейд хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх булан байгуулах, улс төрийн хэлмэгдүүлэлтийн талаар кино, жүжиг, телевизийн нэвтрүүлэг бэлтгэн нийтэд хүргэх, эрдэм шинжилгээний хурал зохион

байгуулах, гэрэл зургийн үзэсгэлэн гаргах, хэлмэгдэгсдийн цол хэргэмийг буцаан олгуулах, байгууллага, гудамж, талбайг хэлмэгдэгсдийн нэрэмжит болгох зэрэг ажлыг зохион байгуулж ирсэн юм. УИХ-ын гишүүд, Улсын комиссын нарийн бичгийн дарга, Судалгааны төвийн захирал нар 1998 онд ХБНГУ-д зочлон холбогдох байгууллагын удирдлагуудтай уулзаж ярилцсанаас гадна Монгол дахь улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах чиглэлээр хийж буй ажлын талаар Конрад-Аденауэр-Сангийн ажилтнуудад мэдээлэл хийж, баримтат кино үзүүлж байсан нь манай байгууллагын түүхийн нэг тод хуудас болж үлдсэн юм. Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс цаашид ХБНГУ-ын холбогдох байгууллагуудтай хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх сонирхолтой байгаагаа энэ ялдамд илэрхийлье.

Анхаарал тавьсанд баярлалаа. Бага хурлын ажилд амжилт хүсье.

МОНГОЛД ГАРСАН УЛС ТӨРИЙН ХЭЛМЭГДЭЛ: ДҮГНЭЛТ, СУРГАМЖ



Оохнойн Батсайхан
Монгол Улсын Шинжлэх Ухааны
Академийн Олон улс судлалын
хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний
тэргүүлэх ажилтан, Түүхийн шинжлэх
ухааны доктор, профессор

Монгол улсад улс төрийн хэлмэгдүүлэлт гарсан явдал нь Орчин үеийн Монголын түүхийн хуудсанд тодорхой орон зай эзэлсэн хар толбот үзэгдэл болсон билээ. Монгол үндэстэнийг дайрч гутаасан хэдэн арван жилээр үргэлжилсэн энэхүү хар дарсан зүүд мэт үзэгдэлд бүхэлд нь түүхийн үүднээс ул суурьтай хандаж, үндэслэлтэй судалгаа хийж, шинжлэх ухааны чанартай дүгнэлт өгсөн явдал өнөө хэр гарсангүй. Эл олон жил шууд болон шууд бус хэлбэрээр үргэлжилсэн эл үзэгдлийг хэсэг хэсгээр нь, тодорхой асуудлуудыг түүвэрлэх маягаар судалж ирсэнийг¹ энд үгүйсгэхгүй байна. Улс төрийн хэлмэгдэл хэмээх үзэгдэл ганцхан Монголд гарсан бус бөгөөд ЗХУ, социалист гэж байсан бараг бүхий л орнуудад гарсан нийтлэг үзэгдэл юм. Тиймээс эл хэлмэгдэл хэмээх үзэгдлийг социалист гэж нэрлэж ирсэн орнуудад тохиолдсон нийтлэг үзэгдэл хэмээхэд болно. Түүний учир шалтгааныг ч социализмтай холбох нь гарцаагүй хэрэг. Монголоос бусад социалист хэмээн нэрлэж байсан улсууд уг асуудлыг түүхийн үүднээс шинжлэн судалж, улс төрийн дүгнэлт өгч, аль хэдийн нэг мөр шийдсэн байх юм. Гэвч бид тэгсэнгүй. Яагаад нийгэм өөрчлөгдөөд зууны дөрөвний нэг хугацаа өнгөрсөн байхад ингэж чадсангүй бэ. Бидний дунд социализм амь бөхөд оршиж байгаа бус уу. Эл монгол үндэстэн өөрийгээ таньж, өөрөө өөртөө эзэн байх учиртай бус уу. Ийм сэтгэл үндэстэнд алга гэж үү. Тиймээс монгол үндэстэнийг дайрч гутаасан эл хар толбот үзэгдлийн тухайд өөрийн үзэл бодлоо илэрхийлэхийг хүссэн болно. Улс төрийн

1 Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгал Цагаан ном, Улс төрийн хэлмэгдэгсдийн намтрын товчоон, хянан тохиолдуулсан М.Ринчин, Цагаатгах ажлыг Удирдан зохион байгуулах улсын Комиссын дэргэдэх Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн судалгааны төв, УБ., 2004-2008 он, одоогоор ная гаруй дэвтэр, арван хоёр боть цуврал хэвлэгдсэн байна.

хэлмэгдүүлэлтэнд нийтдээ Монгол улсын 35 мянга орчим хүн цаазаар авхуулсан тухай мэдээ буй.² Мэдээж хэлмэгдэлд өртсөн хүмүүсийн тоо зуун мянга хол давах нь ойлгомжтой. Монгол Улсын хүн амын тооллогоор шүүн тунгааж үзэх аваас үүнээс ч илүү тоо гарах магадлалтай юм. Хэлмэгдүүлэлтэд өртөөгүй гэр бүл нэгээхэн бээр ч үлдээгүй гэхэд болно. Хэлмэгдсэн хүмүүс бол монголчуудын элит буюу үндэстний сор болсон алтан ургаас гаралтай, сэхээтэн, лам хуврагууд байлаа. Тэд цөм үндэстний үзэлтэй байсан төдийгүй нийгмийн хөтлөгч сэхээтэн байсан юм.³ Улс төрийн хэлмэгдүүлэлтийн оргил буюу 1937 – 1940 оны үед Монгол улсын 25 мянга орчим хүн өөрийн биеэр хэлмэгдэлд өртсөний дотор 17 мянган лам алагдсан гэдэг. Эл тоог ч улам нарийвчлан гаргаж тогтоох нь зүйд нийцнэ. Энд хилс хэргийн улмаас өөрийн биеэр алагдсан, шоронд хоригдосон, цөлөгдсөн хүмүүсийн талаар л ярьж байна. Тэгвэл монгол үндэстний уламжлал, соёл, түүх, шашны үнэт хэдэн мянган өв дурсгалын зүйлсийг санаатайгаар устгаж, шатаасан үгүй хийсэн явдлыг хэн судалж тогтоох юм бэ. Яагаад монгол үндэстэний үнэт зүйлсийг бүхэлд хамарч, үндэстэний оршихуйн үндсийг тасалсан эл хэлмэгдэл хэмээн нэрлэсэн хорт үзэгдлийн талаар иж бүрэнээр судалж, дүгнэлт өгөхгүй байна вэ.

Улс төрийн хэлмэгдэл хамрах хугацааны талаар

Одоо мөрдөж буй хуулиар хэлмэгдэгсдийн дурсгалын тэмдэглэх өдрийг 9 дүгээр сарын 10-ны өдөр тэмдэглэж байгаа.⁴ Зарим хүмүүс улс төрийн хэлмэгдүүлэлт 1937 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр эхэлсэн гэж үздэг. Х.Чойбалсан тэргүүтэй Онцгой бүрэн эрхт комисс (ОБЭК) 1937 оны 9 дүгээр сарын 10-нд байгуулагдаж, 1939 оны 4 сарын 22 хүртэл ажиллахдаа 51 удаа хуралдаж 25824 хүний хэргийг шүүж 20474 хүнд буудан алах ял өгч, 5103 хүнд 10 жил хорих ял, 240 хүнд 10 аас доош жилээр хорих ял оногдуулжээ. 1937 оны 9 дүгээр сарын 10-нд баривчлагдсан хүмүүсийн дотроос Монголын төр, цэргийн нөлөө бүхий 14 хүнийг хилс хэрэгт хэлмэгдүүлэн мөн оны 10 дугаар сард хөнөөсөн билээ. Иймээс 9 сарын 10 ны энэ өдрийг Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн дурсгалын өдөр болгон төрөөс 1996 онд албан ёсоор зарлаж жил бүр тэмдэглэж буй билээ. Хэлмэгдүүлэлт оргилдоо хүрсэн энэ үед нам, төр, цэрэг, залуучуудын болон лам нарын маш өргөн хүрээг хамарсан баривчлгаа явагдаж, нийт ард олныг ангичлан ялгаварлах, хүн хүндээ үл итгэх явдал дээд цэгтээ хүрсэн байжээ. Улс төрийн хилс хэрэгт баривчлагдсан хүн өөрөө егүүтгэгдээд зогсохгүй, түүний ар гэр, ахан дүүс, төрөл төрөгсөд, танил нөхөд нутаг усныхан хэлмэгдлийн давалгаанд өртөж, тэднийг нийгэмд эзлэх өөрийн

² <https://mn.wikipedia.org/wiki/их> хэлмэгдүүлэлт

³ Япон үндэсний үзэл, УБ., 2010 он.

⁴ 1937 оны есдүгээр сарын 10-ны бямба гарагийн шөнө ЗХУ-ын ДЯАК-ын орлогч, генерал М.П.Фриновскийн авчирсан "Заговор" (хуйвалдаан) хэмээх нэртэй Хувьсгалын эсэргүү, Японы тагнуулын байгууллагын гишүүн гэх 115 хүний нэрсийн жагсаалтаар ДЯА-ны сайд Х.Чойбалсан төрийн болон цэргийн томоохон албан тушаалтан нарыг олноор нь баривчилж, удалгүй тэдний 14-ийг олны өмнө цааш харуулсан юм.

байр суурьгүй болгож, ирээдүйдээ итгэх итгэлгүй, амьдралын баталгаагүй болгон хөсөр хаях явдал Монголын бүх нутгийг асар хурдацтайгаар тархан газар авч байжээ. Гэвч улс төрийн хилс хэргээр хэлмэгдүүлэлт энэ үеэс нилээд эрт бүр 1922 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Монгол улсын Ардын Засгийн газрын анхны Ерөнхий сайд Догсомын Бодоо нарын 14 хүнийг цаазлан хороосноор эхэлсэн байх гэж өчүүхэн судлаач бибээр боддог юм. 1921 оны Монголын үндэсний тэмцэлд өөрийн хувь нэмрийг оруулж, оройлох үүрэгтэй байсан нэгэн бол Догсомын Бодоо билээ.⁵ 1924 оны 8 дугаар сарын 30-ны өдөр МАН-ын Төв Хорооны дарга, Сангийн яамны тэргүүн сайд, Бүх цэргийн жанжин Солийн Данзанг⁶ Эвлэлийн Төв Хорооны Баваасангийн хамтаар Шар хаданд учир начирыг ялгаж салгалгүйгээр хороосон явдлыг энд бас дурьдах нь зүйтэй мэт санагдана. Энэ бол МАН-ын 3 дугаар их хурлын хуралдааны дундуур хурлынхаа даргыг буудаж хороосон явдал байв.⁷ 1928 он МАН-ын Төв Хорооны дарга Ц.Дамбадорж, Н.Жадамба нарыг албан тушаалаас нь хүчээр зайлуулж, улмаар Москвад аваачсан явдал болов.⁸ 1930 он Төгсбуянтад гарсан лам нарын бослогыг цэргийн хүчээр дарсан явдал гарав. 1932 оны хавар Монгол улсын бараг бүх нутаг дэвсгэрийг хамарсан зэвсэгт бослого буюу ардын хөдөлгөөн дэгдэж, улмаар иргэний дайны шинжийг агуулсан үйл явдал болж мөн л цэргийн хүчээр номхотгогдов. Үнэндээ энэ бол нийгэм журам буюу монголын хөрсөнд таарч нийцэхгүй социализмын ангичлан ялгаварлах үзлийг эсэргүүцсэн тэмцэл байсан юм. Хожим үүнтэй агаар нэгэн хөдөлгөөн 1956 онд Унгарт, 1968 онд Чехословакт гарсаныг дэлхий нийт мэднэ. Харин Монголд юу болсон талаар бол дэлхий мэдэхгүй байлаа. Учир нь монгол дэлхийгээс хаагдмал ертөнцөд оршиж байв. 1934 он Лхүмбийн хэрэг хэмээх хилс хэрэг гарч, МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн даргын нэр оролцсон энэ хэрэгт буриад голдуу хүмүүс хамрагдан хэлмэгдэв. 1936 он Монгол улсын Ерөнхий сайд П.Гэндэнг албан тушаалаас нь зайлуулж, Москвад «эмчлүүлэхээр» илгээсэн явдал болов. 1937 оны 9 сарын 10 Гэндэн Дэмидийн хэмээх хилс хэрэг гарч, түүнд Монголын олон арван хүмүүсийг хамруулсан их баривчилгаа дэгдэв. 1938 он Ёнзон хамбын хэрэг хэмээх гарч бас лам хувраг олныг цааш харуулав. 1947 он Порт Артурын хэрэг гарсан үйл явдал болов. 1956 он Сэхээтний төөрөгдөл хэмээх дэгдэж, бас л монголын сэхээтнүүд өртөв. 1959 он Дашийн Дамбыг МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн даргын албан тушаалаас зайлуулсан явдал гарав. 1962 он МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга Төмөр Очирын хэрэг гарчээ. 1964 он Намын эсрэг бүлэг хэмээгчдийн

5 Монгол улсын дээд шүүхийн 1997 оны 6 сарын 11-ны өдрийн 236 тоот тогтоолоор Догсомын Бодоод ногдуулсан хилс хэргийг хэрэгсэхгүй болгон нэр төрийг нь цагаатгасан байна. Л.Бат Очир Догсомын Бодоо, УБ., 2010 он

6 МАН-ын дарга, Бүх Цэргийн жанжин Солийн Данзанг 1962 онд цагаатгасан бөгөөд түүний нэр төрийг сэргээж, түүх шастирт бичсэн нь мөн 1990 оны үе билээ. Д.Даш Солийн Данзан, УБ., 1990 он.

7 О.Батсайхан Монгол үндэстэн бүрэн эрхт улс болох замд, УБ., 2007, 194-195 дахь тал

8 МАХН-ын долдугаар их хурлын материал

хэрэг гэх зэргээр явсаар эдгээрийн үр хөврөл 1990 ээд онтой золгосон байна.Дээр зөвхөн заримыг дурьдсан улс төрийн хилс хэргүүд бол ХХ зууны Монголын түүхийн нэгэн талыг илэрхийлж харуулсан үйл явцууд билээ. 1922 оноос 1990 он хүртэлх хугацаанд Монгол Улсын төр, засаг, намын тэргүүнээр нийт давхардсан тоогоор 33 хүн (нарийн бичгийн дарга нар ороогүй) ажилласанаас 8 хүнээс бусад нь ямар нэгэн хэмжээгээр хэлмэгдсэн буюу учир битүүлэг, харийн оронд нас барсан байна.⁹Ийм дүр зургаас үзвэл, эл үед эгэл нэгэн монгол хүний эрх, аюулгүй байдлын тухай асуудал ярих ямар ч утгагүй байсаныг тодорхой харж болно.Жижиг орны удирдагчдыг ийм хувь заяа хүлээж байдаг юм гэж үү? Эл зөвхөн Монголд болсон үйл явдал уу?

Энэ орны жирийн иргэдийн оршихуйн үндсийн тухай хэн хэлж ярьж хамгаалж байх учиртай вэ?

Бодож тунгааж, түүхээс сургамж авч, өнөөгөө бодитой цэгнэн, ирээдүйдээ итгэлтэй болох хэрэгтэй бус уу.Иймээс улс төрийн хэлмэгдэл эхэлсэн цаг хугацааг 1922 оны 8 дугаар сарын 30-наар тогтоож, үргэлжилсэн хугацааг нарийвчлан авч үзэх нь зүйд нийцэх болов уу. Өөрөөр хэлбэл улс төрийн хэлмэгдэл хэмээх эл үзэгдэлийг бүхэлд нь социализмын гэж нэрлэж ирсэн он жилүүдэд хамааруулан улс төрийн дүгнэлт өгөх нь зүйд нийцнэ.

Цагаатгалын талаар

Улс төрийн талаар хэлмэгдэгсдийг цагаатгах ажил ЗХУКН-ын ХХ их хурлын дараа эхлэсэн гэхэд болох болов уу. Хэдийгээр 1939 он, 1940 өөд оноос гэм зэмгүй хүмүүсийг олноор шууд буудан хороодог явдал тодорхой хэмжээнд хязгаарлагдсан ч гэсэн эл хэлмэгдэл хэмээх аймшигт үзэгдэл үргэлжилсээр байсан юм. Мөсөн уулын бэлээс бага ч атугай ханзрах нь уу гэмээр үйл явц 1956 оноос эхлэсэн байдаг. 1956 оны хоёрдугаар сарын 25-ны өдөр ЗХУКН-ын ХХ их хуралд ЗХУКН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Н.С.Хрущев “Нэг хүнийг тахин шүтэх явдал ба түүний үр дагаврын тухай” гэсэн дуулиант илтгэлээ их хуралд оролцогчдод танилцуулсан байдаг. ЗХУКН-ын ХХ их хурал дууссаны дараа ЗХУКН-ын Төв Хорооны хаалттай хуралдаанд Хрущев илтгэлдээ Сталиныг илчилсэн баримтууд дэлгэж, түүнийг хурцаар шүүмжилжээ. Гэвч “хэвлэлд зориулаагүй” гэсэн тамгатай Н.Хрущевын илтгэл тухайн үеийнхээ намын байгууллагууд, социалист орнуудын Төв хороодод тараагдсан ч 1989 он болтол албан ёсоор уг илтгэл нийтийн хүртээл болоогүй байсан юм.

ЗХУКН-ын Төв Хорооны ХХ их хуралд оролцсон Д.Дамба нарын хүмүүс

9 О.Батсайхан МОНГОЛД ГАРСАН ХЭЛМЭГДЭЛ, ТҮҮНД ӨРТСӨН ТӨР, ЗАСАГ, НАМЫН ТЭРГҮҮН НАРЫН ТУХАЙД ӨГҮҮЛЭХ НЬ, Монголын Улс төрийн хэлмэгдэгсдийн холбооноос Конрад Аденауэрийн сангийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан Монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлт, сургамж (1970-1980) сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд тавьсан илтгэл, 2015.10.08-09

Монголд ирэнгүүт 1956 оны 4 дүгээр сард МАХН-ын Төв хорооны IV бүгд хурлыг хуралдуулж, Х.Чойбалсанг шүүмжлэн, нэг хүнийг тахин шүтсэний улмаас хувьсгалт хуулийг зөрчиж байсан явдлыг нарийвчлан шалгаж илрүүлэх шийдвэр гаргасан юм. МАХН-ын Төв хорооны Улс төрийн Товчооны 1956 оны 4 дүгээр сарын 21-ний тогтоолоор улс төрийн зарим хэргийг хянан үзэх комисс байгуулж, Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга байсан Б.Баасанжав нарын зэрэг 1940 оны эхээр хэлмэгдсэн 36 хүнийг цагаатгасан байна. 1957 онд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дэргэд Цагаатгах ажлыг эрхлэх комисс байгуулагдаж, 1937-1947 онд Дотоод яамны үйл ажиллагаанд гарсан завхарлын асуудлыг нарийвчлан шалгаж, 1930-аад онд хилс хэрэгт ял шийтгүүлсэн 294 хүнийг цагаатгажээ.

МАХН-ын Хянан Шалгах Хорооны дарга Т.Гэндэнгээс “Улсыг аюулаас хамгаалах байгууллагын ажилд гарч байсан алдаа завхралыг шалгасан дүнгийн тухай” 600 гаруй хуудас илтгэлийг 1961 оны 12 дугаар сард бэлтгэж, Намын Төв Хороонд танилцуулахаар оруулсан байдаг.

МАХН-ын Төв Хорооны 1960 оны 7 дугаар сарын 20-ны 17 тоот тогтоолын 26-д заахдаа: “Ангийн хувьд зайлшгүй шийтгэгдвэл зохих байсан этгээдийн хэргийг шалгахгүй байх нь зүйтэй гэж үзсүгэй. Хувьсгалын өмнө хөдөлмөрчдийн биш ангид багтаж байсан боловч хувьсгалын үйл хэрэгт идэвхтэй үнэнч шударгаар оролцон явсан хүмүүсийн хэргийг шалгаж шийдвэрлэж байвал зохино”¹⁰ хэмээжээ. Х.Чойбалсанг тахин шүтсэний хор уршгийг арилгах шийдвэрийг XX их хурлын дараачаас гаргаж, цагаатгах ажлыг хийхийг оролдсон ч улс төрийн хэлмэгдүүлэлтэнд биечлэн оролцсон хийгээд тэдний үзэл санааг үргэлжлүүлэгчид Монголын нам, төрийн удирдлагад хэвээр байсан нь цагаатгах ажил саад болсон төдийгүй хязгаарласан байна. 1962 оны 2 дугаар сарын 8-нд хуралдсан МАХН-ын Улс Төрийн товчооны хурал цагаатгах ажлыг эрхлэх комиссын ажил дуусан гэж дүгнээд түүнийг татан буулгаж, ажил үүргийг нь Улсын дээд шүүх болон НАХЯ-нд шилжүүлсэн байна. Энэ үеэс хойш цагаатгах ажил удааширч, үндсэндээ зогсонги байдалд оржээ. Тиймээс Хянан шалгах хорооны дарга Т. Гэндэнгээс бэлтгэсэн илтгэлд дурьдсан улс төрийн талаар хэлмэгдэлд өгсөн үнэлэлт дүгнэлт таалагдаагүй учраас Намын Төв Хороо уг ажлыг зогсоосон төдийгүй түүний 600 гаруй хуудас илтгэл алга болсон гэдэг. Хожим Т.Гэндэн гуай тэрхүү 600 гаруй хуудас илтгэлийнхээ гуравны нэгийг “Гурван түмэн хүний амь” хэмээх нэртэй нийтлэсэн байдаг.¹¹ Үүнээс хойш 1989 он хүртэл хэлмэгдлийн талаарх ажил үндсэндээ зогссон юм. 1989 онд ЗХУ-д өрнөж байсан перестройка буюу өөрчлөлт шинэчлэлийн нөлөөгөөр Монголд Улс төрийн хэлмэгдсэн

10 МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1960 оны 7 дугаар сарын 20-ны 17 дугаар тогтоол - Улс төрийн хэлмэгдэгсдийн намтрын товчоон, 11 боть, Хянан тохиолдуулсан М.Ринчин, Цагаатгах ажлыг Удирдан зохион байгуулах улсын Комиссын дэргэдэх Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн судалгааны төв, УБ., 2008 он, 10 дахь тал

11 Гурван түмэн хүний амь – Т.Гэндэн, УБ 1999 он

нам, төрийн удирдах хүмүүсийг цагаатгах ажил дахин сэргэсэн байна. Гэвч 1989 онд байгуулсан комиссын ажиллах ажлын хүрээ хэмжээ хязгаартай байлаа. Тэрхүү комисс “1930-1940-өөд онд хэлмэгдэгсдийн тухай асуудлыг үргэлжлүүлэн нөхөн хянан үзэх, үнэн байдлыг тогтоож тэдний шударга нэр хүндийг сэргээх, хэлмэгдэгсдийг цагаатгуулах” үүрэгтэй байв. Түүнээс гадна улс орны нөхцөл байдал ч бүрэн дүүрэн утгаар ажиллах боломж хомс байсан биз ээ. 1956 оноос 1989 оны хооронд улс төрийн талаар хэлмэгдэгсдийн талаар болон тэднийг цагаатгахтай холбоотой ажил хийж байсан комиссынхон МАХН-ын архив, НАХЯ-ын архив, ЗХУ-ын тусгай архивуудаас баримт бичгүүдийг илрүүлэн авч, ихэвчлэн нам, төрийн өндөр алба хашиж байсан хүмүүс болон тодорхой хэргүүдийн талаар цагаатгах ажлуудыг хийж иржээ.

Ингээд 1990 оны ардчилсан хувьсгалтай золгов. 1993 онд Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат, ОХУ-ын ерөнхийлөгч Б.Н.Ельцин нар хамтарсан мэдэгдэл гаргаж, шинэ цагийн хоёр улсын харилцааны эх суурийг тавихдаа “Монголын олон иргэн ЗСБНХУ-д хэлмэгдэн, цаазлагдсаны хариуцлага өнөөгийн ОХУ-д холбогдолгүй”¹² гэсэн мэдэгдэл гаргажээ. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн 1990 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн зарлигаар байгуулсан Цагаатгах ажлын удирдан зохион байгуулах улсын комисст улс төрийн хэлмэгдэлийн асуудлыг ацаглаад орхисон гэхэд болно. 1998 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай” хуулийг Монгол Улсын Их Хурал батлан гаргаснаар энэхүү хэлмэгдэлийн асуудлыг дуусгавар болсон гэж үзэж байх шиг байна. Тиймээс жил бүр Цагаатгалын комиссоос “Улс төрийн хэлмэгдэгсдийн хохиролыг барагдуулах зорилгоор 1998 оноос хэлмэгдэгч болон түүний ар гэрт 500 мянга болон 1 сая төгрөгийг цагаатгалын нөхөн олговор, буцалтгүй тэтгэмж олгож байна. Одоогоор 18036 хэлмэгдэгчид 16 тэр бум 247,4 сая төгрөгийн нэг удаагийн нөхөн олговрыг олгосон бөгөөд бас нас барсан, цаазлагдсан хэлмэгдэгсэд болон тэдний гэр бүлийн хүнд хашаа, орон сууц худалдаж авахад нь зориулж тодорхой хэмжээний буцалтгүй тэтгэмж олгоод байна” хэмээн тайлан тавьж ам хаасаар ирэв. Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн хэргийг үүссэн улс төрийн нөхцөл байдал, олон улсын болоод монгол дотоод, гадаад орчины судалгаанд түшиглэж улс төрийн дүгнэлт өгөх замаар шийдвэрлэх нь оновчтой юм. Эс тэгвээс одоо мөрдөж буй хуулийн хүрээнд Шүүхийнхэн, Цагаатгалын комиссынхоны ажил эргэлдэж, хэлмэгдлийн салаа мөчир төдийгээр оролдохоос хэтрэхгүй байгаа юм. Иймээс эл асуудалд улс, үндэстэний эрх ашгийн үүднээс хандаж, Монгол Улсын Их хуралд “Монголд өрнөсөн улс төрийн хэлмэгдэл, түүнд өгөх улс төрийн дүгнэлт” гэсэн асуудлыг боловсруулан өргөн барьж шийдвэрлүүлэх нь зохистой болов уу.

12 Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ, УБ., 1993 он.

Хэлмэгдэл гарсан шалтгааны тухайд

1. Монгол төрийн уламжлал шингэсэн бодлого – нэг талаас, нөгөө талаас Монголд туршилт хийсэн нийгэм журмын (социализм) үзэл онолтой зөрчилдсөн явдлыг улс төрийн хэлмэгдүүлэлт гарах нэг үндсэн шалтгаан гэж үзэж байна. 1921 оноос эзэн хааны эрхийг хязгаарлаж, 1924 онд Богд хаан таалал болонгуут бүгд найрамдах засаг тогтоон, улмаар, хорь, гучаад онуудад Монголын төрийн уламжлалт бодлого, Монгол төрийн ноён нурууг тээгч - алтан ургийнханы залгамж халааг хөрөнгий нь хурааж, үзэл суртал, оюун санааг нь таягдан хаяж, үндсийг нь бараг тасалсан юм.
2. Ангийн тэмцлийн тухай онол хэлмэгдэл гарах нэгэн шалтгаан болжээ. Карл Марксын үүсгэсэн, В.Лениний хөгжүүлсэн онол, И.Сталины хэрэгжүүлсэн ангийн тэмцлийн онол, улс төрийн үйл ажиллагаа \Гол зохион байгуулагч нь ЗХУКН-ын Төв Хороо, түүний УТТ, хэрэгжүүлэгч нь Коминтерн, Монголд МАХН\ нь нийгмийг ангичлан үзэх, аливаа асуудалд ангийн байр сууринаас хандах, нийгмийн болон хүний аливаа үзэгдлийг зөвхөн нэг өнцөгөөр харах, нэг үзэл сурталд таацуулах хандлага бий болгож, тэр нь үндэсний ардчилсан үзэл бодол, бурханы шашинаар тэжээгдсэн хөрс суурьтай нүүдлийн монголчуудын амьдрал, үйл ажиллагаатай таарч нийцээгүй юм. Энэ нь Монголд улс төрийн хилс хэргээр хэлмэгдүүлэлт бий болох бас нэгэн шалтгаан байв.¹³
3. ЗХУ хэмээх Их гүрний үзэл нэг талаас, нөгөө талаас өөрийн үндэсний онцлог, өвөрмөц байдал, нүүдлийн иргэншлийн өнгө төрхийг хадгалсан монголчуудын бие даасан байх үзэл бодолтой зөрчилдсөн явдал нь хэлмэгдэл гарах нэгэн шалтгаан мөн буй за.¹⁴
4. Төрийн өндөр алба хашиж байсан хувь хүмүүсийн үүрэг роль, тухайлбал, И.Сталин, Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал нарын зэрэг хувь хүмүүс болон тэдгээрийг тойрсон хэсэг бүлэг хүмүүсийн үйл ажиллагаатай улс төрийн хилс хэлмэгдүүлэлтийг холбон үзэх нь ч зүйд нийцнэ.
5. Мөн түүнчлэн дээд, дунд, доод шатны тодорхой албан тушаалтай эрх мэдэлтнүүдийн бусармаг үйл ажиллагаа, ёс суртахуунгүй байдал хэлмэгдүүлэлт гаарч газар авахад өөрийн хувь нэмрийг оруулсан гэж үзэж байна.

13 Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичигт 1920-1952, УБ., 2008-2009 он, Монгол ба Коминтерн, УБ., 1996 он.

14 С.Кузьмин, Ж.Оюунчимэг Социализмын эсрэг 1932 оны Монгол дахь бослого, УБ., 2014 он

Улс төрийн хэлмэгдэлийн асуудлаар санал дүгнэлт болгох нь

Энэхүү улс төрийн хэлмэгдэл нь Монгол үндэстэний оршихуйн үндсийг тасалж, үндэсний уламжлал, соёл, эх бичиг, эх түүх тэргүүтэй үнэт зүйлсээ гээхэд хүргэсэн юм. Үүний хор уршиг одоо хэр арилаагүй гэхэд болно. Учир нь хэлмэгдэл хэмээх хорт үзэгдэл монгол хүн бүрийг, монгол өрх бүрийг дайрсан гэхэд болох биз ээ. Гинжин урвал мэт нэгийг нь нөгөөгөөр нь хөнөөлгөсөн эл хэлмэгдэл монгол үндэстэний оршихуйн үндсийг тасалжээ. Ийм байхад энэхүү үндэсний хэмжээнд явагдсан улс төрийн хэлмэгдлийн талаар улс төрийн дүгнэлт гаргахгүйгээр үнэн мөнийг тогтоож чадахгүй юм. Улс төрийн хэлмэгдлийн хамарсан хүрээ, цаг хугацааг аваад үзсэн ч эл асуудлын эрэг шураг төдийг шүүхээр цагаатгаснаас хэтрэхгүй байна.

Чухамдаа монгол үндэстэнийг он удаан жилийн турш авч ирсэн тэрхүү үнэт зүйлсийг тасалдуулсан нь хамгийн хохиролтой зүйлс болсон байна. Улс төрийн хэлмэгдлийн уршгаар өнөөдөр бид өөрөө өөрсдийгээ танихгүй шахам болтлоо өөрчлөгджээ. Дэлхийн талыг эзэлж явсан түүхтэй атлаа дэргэдэхээ танихаа байтлаа өөрчлөгджээ, бид. Хүн хүндээ чоно хэмээсэн латин зүйр үгийн нэгэн утга монгол монголдоо чоно болтлоо өөрчлөгдөө юу хэмээлтэй.

Нэг. Хэлмэгдэл монгол үндэстэнийг бүхэлд нь тодорхой урт цаг хугацаанд хамарсан улс төрийн асуудал тул улс төрийн дүгнэлт Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллага болох УИХ-аас өгөх нь зүйтэй хэмээн үзнэ.

УИХ-аас хэлмэгдэлд улс төрийн дүгнэлт өгсөний дараа эл асуудлаар гарсан дүгнэлтийг Монголын түүхэнд тэмдэглэж, хойч үедээ дахин давтагдахгүй байх сургамжтайг ямагт сануулж байх нь зүйтэй болов уу.

Хоёр. Нэгэнт эл асуудлаар УИХ-аас шийдвэр гарсаны дараа эл асуудлыг аливаа улс төрийн намууд үндэсний эрх ашигт харшилсан хэлбэрээр тоглолт хийхийг хориглох нь зүйтэй.

Гурав. Нэгэнт монгол үндэстэний хувь заяатай холбогдол бүхий асуудал тул Монголын төрөөс тусгайлан мөнгө гаргаж, хэлмэгдлийн талаар баримтат болон уран сайханы кино хийж түмэн үед хоцроох нь хойч ирээдүйд сургамж болох болов уу.

Дөрөв. Улс төрийн талаар хэлмэгдүүлэлт гарахад гол шалтгаан болж нөлөөлсөн ангичлан ялгаварлах коммунист үзэл хийгээд үүн лүгээ адил монголчуудыг дотор нь хуваан талцуулсан аливаа үзэл суртлыг Монгол улсад хориглох хууль гаргавал зохилтой.

Тав. Төр хэлмэгдэгсдээс уучлал гуйсан нь¹⁵ төр монголын ард түмний өмнө буруу үйлдэл хийсэнээ хүлээн зөвшөөрч буй хэмээн үзэх учиртай. Нэгэнт төрөөс буруутай үйлдлээ хүлээн зөвшөөрсөн учраас хэлмэгдэгсдэд нөхөх олговор олгох нь зүйн хэрэг. Гэвч 1998 онд батлагдсан хуулиар олгосон нэг сая төгрөг нь хэлмэгдсэн хүмүүсийн гомдлыг бүрэн барагдуулж чадаагүй, бөгөөд магадгүй тухайн цаг үеийн эдийн засгийн байдалд таацуулсан байж мэдэх тул эдүгээ монголын улсын төсөв их наядаар яригддаг байдалтай уялдуулан нөхөх олговрыг нэг удаа өсгөн нэмэгдүүлж олгох нь зүйд нийцнэ.

Монгол үндэстэний үнэт зүйлсийг сэргээх, үндэстний эв нэгдлийг хангах эрхэм дээдлэгч зүйлсийн талаар монголын төрөөс шаардагдах хөрөнгийг гар таталгүй гаргаж, дэс дараатай бодлого явуулж, үндэстэний дархлааг бэхжүүлэх шаардлагатай байна.

Ашигласан материал

1. О.Батсайхан Монголын сүүлчийн эзэн хаан VIII Богд Жавзандамба хутагт: амьдрал ба домог, УБ., 2014 он, гурав дахь хэвлэл
2. О.Батсайхан Монгол үндэстэн бүрэн эрхт улс болох замд (1911-1946), УБ., 2007 он, хоёр дахь хэвлэл
3. Цагаатгалын "Цагаан ном" УБ., 1-2 боть, УБ., 2008, 2012 он
4. Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичигт 1920-1952, 1-3 боть, УБ., 2008-2012 он,
5. Г.Цэрэндулам П.Гэндэн Эцгийн тухай дуртгал, УБ., 2000 он
6. С.Л.Кузьмин Социализмын эсрэг 1932 оны Монгол дахь бослого, УБ., 2014 он
7. Т.Гэндэн Гурван түмэн хүний амь, УБ 1999 он
8. М.Ринчин Улс төрийн хэлмэгдүүлэлт ба цагаатгал, УБ 2000 он
9. Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгал Цагаан ном, Улс төрийн хэлмэгдэгсдийн намтрын товчоон, хянан тохиолдуулсан М.Ринчин, Цагаатгах ажлыг Удирдан зохион байгуулах улсын Комиссын дэргэдэх Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн судалгааны төв, УБ., 2004-2008 он, одоогоор наяд гаруй дэвтэр, арван хоёр боть цуврал хэвлэгдсэн.
10. https://mn.wikipedia.org/wiki/их_хэлмэгдүүлэлт
11. Япон үндэсний үзэл, УБ., 2010 он.

15 Коммунист он жилүүдэд МАХН-ын засаглалаас өөр үзэл бодолтой, шашинтай байснаас нь болж хэлмэгдүүлж, устгасан 37000 гаруй хэлмэгдэгсэд, болон тэдний ар гэрийнхнээс Монгол Улсын төр уучлал хүсэх арга хэмжээг Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга байхдаа Ц.Элбэгдорж 1996 онд санаачилж, хэрэгжүүлсэн юм.

12. Л.Бат Очир Догсомын Бодоо, УБ., 2010 он
13. Д.Даш Солийн Данзан, УБ., 1990 он.
14. МАХН-ын долдугаар их хурлын материал
15. О.Батсайхан Монголд гарсан хэлмэгдэл, түүнд өртсөн төр, засаг, намын тэргүүн нарын тухайд өгүүлэх нь, Монголын Улс төрийн хэлмэгдэгсдийн холбооноос Конрад Аденауэрийн сангийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан Монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлт, сургамж (1970-1980) сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд тавьсан илтгэл, 2015.10.08-09
16. Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ, УБ., 1993 он.
17. Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичигт 1920-1952, УБ., 2008-2009 он,
18. Монгол ба Коминтерн, УБ., 1996 он.

КОММУНИСТ ДЭГЛЭМИЙН ҮЕИЙН УЛС ТӨРИЙН ХЭЛМЭГДҮҮЛЭЛТИЙГ ДҮГНЭН ШИНЖЛЭХ, ХЭЛМЭГДЭГСДИЙГ ЦАГААТГАХ ЧИГЛЭЛЭЭР ГЕРМАН УЛСАД ХИЙГДЭЖ БУЙ АЖЛУУД



Др. Хүбертүс Кнабе
Берлин хот дахь Хөөншөнхаузен дурсгалын
цогцолборын захирал

1. Нутаг дэвсгэрийн нэгээхэн хэсэгт оршин байсан коммунист дэглэм

Коммунист дэглэмийн үеийн улс төрийн хэлмэгдүүлэлтийг дүгнэн шинжлэх, хэлмэгдэгсдийг цагаатгах үйл ажиллагаа нь Герман улсын хувьд Европын бусад орнуудтай харьцуулахад өөрийн гэсэн онцлог шинжтэй явагдаж иржээ. Учир нь коммунист дэглэм нь Германы нутаг дэвсгэрийн багаахан хэсэгт оршин тогтнож байсанд байгаа юм.¹ 1949–1989 оны хооронд барууны чиг баримжаа бүхий Холбооны бүгд Найрамдах Герман Улсад 60 гаруй сая хүн ам оршин сууж байсан байхад социалист лагерийн орнуудын тоонд багтаж байсан Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улсын хүн амын тоо ойролцоогоор 16 сая байсан байна. Энэхүү нөхцөл байдал нь БНАГУ-д оршин тогтнож байсан коммунист дэглэмийн хэв маягт ихээхэн нөлөөлсөн. Жишээлэхэд, БНАГУ нь албан ёсоор олон намын тогтолцоотой байсан бөгөөд үүгээрээ ЗХУ-аас ялгаатай байсан.² Дээр дурдсан онцлог байдал нь коммунист тогтолцоо нуран унасны дараагаар коммунист дэглэмийн хэлмэгдүүлэлтийг дүгнэн шинжлэх, цагаатгах үйл ажиллагааны хэв маягт мөн л нөлөөлсөн байдаг.

1 Эрхлэн нийтлүүлсэн Фридрих Кристиан Шрөөдэр, Хэрбэрт Күйппэр: Европын улс орнууд дахь коммунист дэглэмийн улс төрийн хэлмэгдүүлэлтийг дүгнэн шинжлэх, хэлмэгдэгсдийг цагаатгах үйл ажиллагааны хууль эрх зүйн асуудлууд, Майн дахь Франкфурт, 2010 он.

2 Гэрд Рүйдигэр Штэфан/ Андрэа Хэрбст: БНАГУ дахь улс төрөн намууд, тэдгээрийн зохион байгуулалт, Берлин хот, 2002 он.

Аливаа нэг дарангуйлагч дэглэм халагдаж, тухайн нийгэмд тохиосон хэлмэгдүүлэлт, хэлмэгдэгсдийг цагаатгах асуудлыг улс төрийн хамгийн дээд түвшин буюу Парламент, Засгийн газрын хэмжээнд хэлэлцэн шийдвэрлэдэг жамтай. Гэтэл 1990 оны 10 сараас хойш Герман улсын нийт нутаг дэвсгэр дээр явагдах болсон Бундестагийн сонгуулиар парламентэд сонгогдсон иргэдийн дунд БНАГУ-аас гаралтай иргэдийн тоо маш бага хувьтай байсаар ирсэн. Дээр дурдсан хугацаанаас хойш эрх барьж байсан Холбооны Засгийн Газрын хувьд ч мөн л үүнтэй төстэй дүр зураг харагддаг.

Аливаа нэг дарангуйлагч дэглэмийн үйлдсэн улс төрийн хэлмэгдүүлэлтэд дүн шинжилгээ хийх, хэлмэгдэгсдийг цагаатгах ажилд шүүх байгууллага маш чухал үүрэгтэй субъектуудын нэг байдаг. Герман орны хувьд шүүхийн тогтолцоонд Баруун Германд хэрэгжиж хэвшсэн шүүх үйл ажиллагааны зарчим зонхилох шинжтэй байгаа нь ажиглагддаг. Германд Холбооны улсын зарчмын дагуу шүүх байгууллага, түүний эрх мэдлийг холбооны муж улсын түвшинд зохицуулдаг. БНАГУ-ын нутаг дэвсгэр дээр үүсгэн байгуулагдсан таван муж улсын шүүхийн байгууллага мөн л энэ зарчмыг баримтлан ажиллаж байна.³ Харин Холбооны дээд шүүхийн түвшиний шийдвэрүүд нийт 16 муж улсад бүгдэд нь нэгэн адил хүчинтэй байдаг хэдий ч дээд шүүхийн шүүгчийн энэхүү чухал албан тушаалд олон жилийн турш байнга Баруун Германы шүүгчид томилогдож байсан жишиг харагддаг. Мөн өөр нэгэн жишээ дурдахад, аливаа нэг гэмт хэргийг тухайн хэрэг үйлдэгдсэн газрын харъяалалын шүүх хариуцдаг зарчим үйлчилдэг. Энэ зарчмын дагуу БНАГУ-тай холбоотой хуулийн асуудлыг ихэнх тохиолдолд Берлин хотын шүүхээр шийдвэрүүлэх шаардлага гардаг. Харин Берлин хотод хоёр Герман улс нэгдсэнээс хойш буюу 1990 оны 10 сарын 3-аас эхлэн Баруун Берлин хотын шүүхийн байгууллагууд хотын нийт нутаг дэвсгэрийг хариуцан ажиллах болсон байдаг.⁴

Өнгөрсөн үед тохиосон улс төрийн хэлмэгдүүлэлтэд дүн шинжилгээ хийхэд чухал үүрэг гүйцэтгэгч гуравдагч субъект бол олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл байдаг. Бусад социалист улсуудтай харьцуулахад энэ салбарт өрнөсөн үйл явц бас л өөрийн гэсэн онцлог шинжтэй байсан байдаг. БНАГУ-д үйл ажиллагаа явуулж байсан ихэнх радио, телевизүүд хаагдаж, Баруун Германы радио, телевизүүд халааг нь авсан. Харин муж улсуудийн түвшинд Зүүн Германы гэсэн тодотголтой радио, телевизүүд үйл ажиллагаагаа явуулах боломж бий болж, өнөөдрийг хүртэл үйл ажиллагаа явуулж байна. Сонин, хэвлэлийн хувьд хуучин Германы Социалист Нэгдсэн Намын мужийн салбаруудын сонин хэвлэлийг Баруун Германы томоохон хэвлэлийн компаниуд хувьчлан авцгаасан юм. Шинэчлэлт өөрчлөлтийн үеэр шинээр гарч ирсэн цөөн тооны сонин хэвлэлүүд нь Баруун Германы

³ Эрхлэн нийтлүүлсэн Германы Рыцариудын холбоо, 2014-15 он: Эрх зүйн гарын авлага, ХБНГУ-ын шүүх эрх мэдлийн байгууллагууд, Хайделберг хот, 2014 он.

⁴ Хүбертүс Кнабе, Гэмт этгээдүүд бидний дунд: Германы нэгдсэн социалист намын дэглэмийг дэндүү магтан дуулж буй тухайд, 4 дэх хэвлэл, Берлин хот, 2007 он, 92-р хуудас.

эдгээр хүчтэй өрсөлдөгчдөд арга буюу буулт хийн, үйл ажиллагаа нь дуусгавар болсон байдаг.⁵

Герман орныг бусад орнуудтай харьцуулвал улс төрийн хэлмэгдүүлэлтийг дүгнэн шинжлэх үйл ажиллагаа нь маш олон тооны хүчин зүйл дээр өөрийн өвөрмөц шинжтэй байгаа нь ажиглагддаг. Юуны өмнө Зүүн Герман санхүү, эдийн засгийн нөхцөл байдлын хувьд бусад оронтой харьцуулахад хавьгүй илүү байсан. Холбооны засгийн газраас санаачлан 1000 тэрбум Еврогоос хол илүү давсан, асар их хэмжээний санхүүгийн туслалцааг Баруунаас Зүүн Германд үзүүлсэн байдаг.⁶ Үүнээс гадна Зүүн Германы иргэдийг Баруун Германы тэтгэвэр, эрүүл мэндийн даатгалын системд хамруулан, мөн, "Зүүн Герман дахь бүтээн байгуулалт" хөтөлбөрийн хүрээнд их хэмжээний татварын хөнгөлөлт, төрөл бүрийн хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлсэн мөн дэд бүтцийн томоохон төслүүдийг санхүүжүүлсэн зэргийг дурдаж болох юм. Ийм учраас Зүүн Германд амьжиргааны түвшин эрс сайжирсан.

1990 оны 7 сарын 1-ний өдрөөс Д-Маркыг гүйлгээнд хэрэглэх болсон нь нэг талаар амьжиргааны түвшин сайжрах үндсэн хөшүүрэг болж өгсөн ч нөгөө талаар хуучин Зүүн Германд үйл ажиллагаа явуулж байсан үйлдвэрийн газруудын өрсөлдөх чадварыг алдагдуулж, хаагдахад хүргэсэн гол хүчин зүйл болсон билээ. Зөвхөн 1991 оны байдлаар Зүүн Германд нийт 1,1 сая иргэд ажлын байраа алдаж, 1994 он гэхэд ажилгүйдлын түвшин 10-аас 20 % болтлоо өссөнийг тоо баримтаас харж болно.⁷ Үүнээс гадна Зүүн Германы иргэд өөрсдийн амьжиргааны түвшинг хуучин Зүүн Германы амьжиргааны түвшинтэйгээ биш Баруун Германы иргэдийн амьжиргааны түвшинтэй харьцуулах болсноос үүдэж, ихэнх нь амьжиргаандаа сэтгэл дундуур байх явдал элбэг байдаг.

Бусад социалист системийн орнуудтай харьцуулахад бас нэг өвөрмөц ялгаатай зүйл нь Берлиний хана нуран унаснаар үүссэн Зүүн, Баруун Германы хоорондох шилжих хөдөлгөөн юм.⁸ Ихэнх тохиолдолд залуучууд шинэ мэргэжил эзэмших, ажлын байр хайх зорилгоор Баруун Герман руу нүүцгээж байсан бол эдийн засаг, шинжлэх ухааны салбар, улс төр, удирдах ажлын түвшинд Баруунаас Зүүн Герман руу чиглэсэн элитүүдийн шилжих хөдөлгөөн ихээр бий болсон. Жишээлэхэд Зүүн Германд шинээр байгуулагдсан холбооны муж улсын сайдууд, Засгийн Газрын тэргүүнүүд Баруун Германаас гаралтай хүмүүс байх нь элбэг байлаа.

5 Юргэн Вилкэ, ХБНГУ-ын хэвлэл, мэдээллийн хэрэгслийн түүхэн замнал, Кёльн хот, 1999 он.

6 Оливер Швинн, Герман улсын нэгдэх үйл явцын санхүүхжилт. Улс төр, төрийн байгуулалтын өнцөгөөс хийгдсэн судалгаа, Вийзбаден хот, 1997 он; Герхард А. Риттэр: Герман улсын нэгдэх үйл явцын үнэ цэнэ – Нэгдмэл улс бий болсон хийгээд нийгмийн баримжаатай нийгэм дэх хямарлын асуудлууд, Мюнхен хот, 2006 он.

7 1991-2014 онуудын ажилгүйдлийн тоо баримт: http://www.sozialpolitik-aktuell.de/tl_files/sozialpolitik-aktuell/_Politikfelder/Arbeitsmarkt/Datensammlung/PDF-Dateien/abbIV31.pdf.

8 1950-2011 онуудын Зүүн, Баруун Герман улсуудын хоорондох шилжих хөдөлгөөний тухай статистикийн тоо баримтууд: <http://de.statista.com/statistik/daten/studie/36711/umfrage/wanderungen-zwischen-westdeutschland-und-ostdeutschland/>.

Энд дурдсан өвөрмөц онцлогуудаас шалтгаалан улс төрийн хэлмэгдүүлэлтийг дүгнэн шинжлэх, хэлмэгдэгсдийг цагаатгах үйл ажиллагаа нь Герман оронд нухацтай сайн хийгдээгүй юм байна гэвэл эндүүрэл болно. Бусад коммунист системийн улсуудтай харьцуулахад Германы коммунист системийн эрх баригчид нь харьцангуй улс төрийн нөлөө багатай байсан учраас коммунист системийн хэлмэгдүүлэлтийг дүгнэн шинжлэх үйл явц харин ч илүү эрчимтэй явагдсан гэж хэлж болох юм. Харин Баруун Германы элитүүд “эзлэн түрэмгийлэгч” гэсэн нэр зүүхээс болгоомжлон коммунист дэглэмийн үед болж өнгөрсөн үйл явдлыг шүүмжлэхээс аль болох зайлсхийх хандлагатай байсныг мөн энд дурдах хэрэгтэй юм.

Коммунист дэглэм нь Герман улсын нэгээхэн хэсэгт оршин тогтнож байсан нь коммунист дэглэмийн үеийн улс төрийн хэлмэгдүүлэлтийг дүгнэн шинжилж, цагаатгах ажлыг хэрэгжүүлэх арга хэлбэрт ихээхэн хэмжээгээр нөлөөлсөн. Улс төрийн хүрээнд коммунист дэглэмийн үеийн улс төрийн хэлмэгдүүлэлт гэдгээс илүүтэйгээр Баруун, Зүүн Германы хооронд байсан, мөн байсаар байгаа нийгэм, улс төр болон сэтгэлгээний ялгааг хэрхэн арилгах талаар илүү маргаан өрнөх болсон. БНАГУ-ын голлох улс төрийн нам болох Германы нэгдмэл социалист нам (ГНСН) нь нэгдмэл Герман улс үүсэн бий болох явцад Ардчилсан социализмын нам (АСН) гэсэн шинэ нэрийн доор үйл ажиллагаа явуулах болж, улмаар цаашид оршин тогтнох бололцоотой болсон төдийгүй коммунист дэглэмийн эрхтэн дархтануудыг шийтгэн цээрлүүлэх, Зүүн Германд засаг захиргааны байгууллагад боловсон хүчний шинэтгэл хийх аливаа оролдлогыг “Баруун Германы зүгээс Зүүн Германы ард түмний бүтээн байгуулалт”-ыг нуран унагах гэсэн үйлдэл хэмээн эрс шүүмжлэх болсон.⁹ Баруун Германы иргэдийн ихэнх хэсэг нь энэ үйл явцад ажиглагчийн байр суурьнаас, шүүмжлэлтэй бус хандаж байсан төдийгүй энэ үйл явцыг ойлгохгүй байх тохиолдол элбэг байлаа.

2. Тайван замаар өрнөсөн хувьсгал, түүний үр дагавар

Улиран халагдсан улс төрийн тогтолцоонд нийгмийн хандах хандлага нь тухайн улс төрийн системийг өөрчлөх явц ямар байсантай ихээхэн уялдаатай байдаг учиртай. Дарангуйлагч дэглэмээс ардчилсан нийгэмд шилжих үйл явц аажмаар, шинэчлэлт өөрчлөлтийн хэлбэрээр өрнөсөн тохиолдолд хуучин тогтолцооны элит түвшинийхэн ямар нэг залхаан цээрлүүлтэнд өртөхгүй байх нь ажиглагддаг. Харин дарангуйлагч системийг хүчээр түлхэн унагасан тохиолдолд хуучин тогтолцооны эрх мэдэлтнүүдийг залхаан цээрлүүлэх нь элбэг байдаг. Герман оронд өрнөсөн улс төрийн үйл явц энэ хоёр эсрэг тэсрэг туйлын дунд хавьцаа байсан гэж ойлгож болох юм. Нэг талаас БНАГУ-ын эрх баригч коммунист намын эрх мэдлийг олон

⁹ Хүбертүс Кнабе, Хонекерийн өв залгамжлагчид. Зүүнтний намынхны үнэн нүүр царай, Берлин хот, 2009 он.

тооны хүмүүсийг хамарсан гэнэтийн жагсаал цуглааны үр дүнд халж хаясан байдаг.¹⁰ Нөгөө талаас Зүүн Германы сөрөг хүчний хүмүүсийн олонх нь христийн шүтлэгтэй хүмүүс байж, эвлэрэн ойлголцох, хамтдаа "Ардчилсан социализм" байгуулах гэсэн үзэл бодол дээр нэгдэж байсан учраас хуучин дэглэмтэй тооцоо бодох гэдгээс илүүтэйгээр тэнцвэртэй, тайван байдлыг сахих хамгаалах тал дээр илүү анхаарч, коммунист дэглэмийн эрхтэн дархтануудад өршөөлтэй хандах байр суурийг баримталж байлаа.¹¹

Герман улсад өрнөсөн өөрчлөлт шинэчлэлтийн үйл явцад Баруун Германы улс төрийн намууд онцгой үүрэг гүйцэтгэсэн бөгөөд хоёр Герман нэгдэх үйл явцад эдгээрийн үүрэг роль улам бүр нэмэгдсэн. Эдгээр улс төрийн намуудад хуучин БНАГУ-ын улс төрийн албан тушаалтнуудыг яллан шийтгэх ямар нэг сонирхол байсангүй. Баруун Германы улс төрийн намууд, тэр дундаа Германы Социал-Демократ Нам зүүний эрх баригчидтай олон жилийн турш найрсаг харилцаатай байж ирсэн нь энэ асуудалд хойрго хандахад хүргэсэн байх талтай. Германы Социал-Демократ Намын дарга Оскар Лафонтэйн БНАГУ-ын төрийн тэргүүн Эрих Хонекертэй олон жилийн найз нөхрийн харилцаатай байсан байдаг. Нөгөө талаас тухайн үеийн Дотоод Хэргийн Сайдын алба хашиж байсан Вольфганг Шойблэ гэх мэт Христийн Ардчилсан Холбоо Намын нөлөө бүхий гишүүд улс төрийн аюулгүй байдлыг хангах сонирхлын үүднээс Зүүн Германы элитүүдийг хоёр Герман улс нэгдэх үйлсэд татан оруулах тал дээр хүчин чармайлт гаргасан байдаг. Үүний зэрэгцээ Баруун Германы улс төрийн намууд БНАГУ-д өрнөсөн хувьсгалын шинж чанартай үйл явдлаас улбаалан нийт Герман улс, улмаар Европыг хамарсан улс төрийн тогтворгүй байдал бий болохоос болгоомжилсон улс төрийн бодлого баримталж байлаа.¹² Мөн улс төрийн бүлэглэлүүд нийтдээ тухайн үед Зүүн Германы нутаг дэвсгэр дээр бараг хагас сая гаруй цэргийн хүч байрлуулаад байсан ЗХУ буюу өнөөгийн ОХУ-тай найрсаг харилцаатай байх тал дээр нэгэн ижил байр суурь баримталж байсан.¹³ Энэхүү хувьсгалт үйл явцыг дэвэргэхгүй байх, тайван замаар өрнөсөн улс төрийн шинэчлэлийг үргэлжлүүлэх, БНАГУ-ыг Баруун Германы улс төрийн тогтолцоонд аль болох яаралтай нэгдэн оруулах, ингэхдээ Москвагийн эрх баригчидтай илт сөргөлдөхгүй байх гэх мэт олон тооны сонирхлуудын солбицолууд нь Герман улсад оршин тогтнож байсан коммунист тогтолцооны үеийн хэлмэгдүүлэлтийг дүгнэн шинжлэх, цагаатгах ажиллагааны явцад нөлөөлсөн нь дамжиггүй юм.

10 Эрхарт Ноёбэрт, Бидний хийсэн хувьсгал. 1989/90 онуудын түүх, Мюнхен хот, 2008 он.

11 Эрхарт Ноёбэрт, 1949-1989 онуудад БНАГУ-д оршин байсан сөрөг хүчнийхэний түүх, Берлин хот, 1997 он.

12 Вольфганг Шойблэ: Нэгдлийн Гэрээ – Германы нэгдлийн гэрээний асуудлыг хэлэлцэн тохирсон минь, эрхлэн нийтлүүлсэн Дирк Кох/ Клаус Виртгэн, Штуттгарт хот, 1991 он; эрхлэн нийтлүүлсэн Юүргэн Күйстэрс/ Даниел Хофманн: Герман улс нэгдэх үйл явц, 1989/90 оны Холбооны Канцлерын албан актуудаас түүвэрлэн хэвлүүлсэн тусгай хэвлэл, Германы стратегийн бодлогийн бичиг баримтууд, Мюнхен хот, 1998 он.

13 Андрэас Рөддэр, Герман орон - Эвлэлдэн нэгдсэн миний эх орон. Герман улс дахин нэгдсэн түүх, Мюнхен хот, 2009 он.

БНАГУ нь ХБНГУ-ын нэг хэсэг болж холбооны улсын тогтолцоонд нэгдэн орсон, Баруун Германы элитүүд өнөөг хүртэл нөлөө бүхий байр суурьтай байгаа, Зүүн Германд өрнөсөн нийтийг хамарсан эсэргүүцлийн жагсаалуудыг дээрээс удирдан чиглүүлэн өөрчлөлт, шинэчлэлтийг хүч болгон ашиглаж чадсан зэрэг шалтгаануудаас Герман улсад 1989 онд өрнөсөн тайван хувьсгалыг эргэн дурссан ямар нэг албан ёсны арга хэмжээ өнөөг хүртэл байхгүй байсаар байна. Францад гэхэд л 1789 онд Бастиллийн цамхаг руу довтолсон довтолгооныг баяр хөөртэйгээр эргэн дурсдаг, энэхүү довтолгооноор эхлүүлсэн Францын хувьсгал өнөөдрийг хүртэл бүхэл бүтэн үндэстний бахархал болж байхад, Зүүн Германд коммунист системийг түлхэн унагаасан энэ үйл явдалд нийгэм төдийлөн ач холбогдол өгөхгүй байгаа нь ажиглагддаг. Германд 1989 оны тайван хувьсгалыг эргэн дурсах тэмдэглэлт өдөр, түүний нэрээр нэрлэгдсэн гудамж, талбай нэгээхэн ч байхгүй байсаар байна.

3. Бичиг баримтууд

Аливаа нэг дэглэмийг халж хаяхад тухайн дэглэмийн үед үйлдэгдэж байсан ямарваа нэг албан акт, бичиг баримтуудыг устгалаас аварч үлдэх нь чухал ач холбогдолтой юм. Учир нь энэ нь ирээдүйд Улс төрийн хэлмэгдүүлэлтийг дүгнэн шинжлэх, хэлмэгдэгсдийг цагаатгах үйл ажиллагаа явуулах үндсэн нөхцөл болж өгдөг. Эдгээр бичиг баримтууд нь хэлмэгдүүлэлт хэрхэн яаж явагдаж байсан, гэмт үйлдлийн эзэд, тэдгээрийн үйлдсэн хэргүүд, хэн хэн нууц цагдаагийн газартай хамтран ажиллаж байсан зэргийг нотлох баримт болж байдаг. Герман орны хувьд коммунист намын болон Улсыг аюулаас хамгаалах яамнаас үйлдсэн бичиг баримтууд чухал ач холбогдолтой юм.¹⁴

Бусад бүх социалист орнуудын адил БНАГУ-ын Улсыг аюулаас хамгаалах яам 1989 оны хавраас эхлэн бичиг баримтуудыг зохион байгуулалттайгаар устгаж эхэлсэн.¹⁵ Ялангуяа тухайн цаг үед Улсыг аюулаас хамгаалах яамнаас шалгагдаж байсан хэргүүд, гэмт хэргийн чанартай үйлдлүүдийг нотлох бичиг баримтуудыг устгасан байх магадлалтай. Хэдий хэмжээний бичиг баримт устгасныг хэлэхэд бэрх ч, жижиглэн урж тасдсан бичиг баримт бүхий бүхий 15000 шуудай цаас олдсон нь энэхүү устгалын ажлын цар хүрээг илтгэж байгаа юм. Үүнээс гадна бичиг баримтын устгалын ажлыг анхандаа бүрэн автомат ажиллагаа бүхий устгалын машинаар хийж байсныг дурдах хэрэгтэй юм.

Бусад орнуудын ижил төстэй байгууллагуудтай харьцуулахад Германы Улсыг аюулаас хамгаалах яамны ажилтнуудад маш богино, өрдөө хэдхэн долоо хоногийн хугацаанд устгал хийх боломжтой байсан. Германы

14 Дагмар Унфэрхау, „Яанус“-т боломж байсан уу? БНАГУ-ын сүйрэл, ирээдүйд өнгөрсөн үеийн тухай зөв дүгнэлт гаргах боломж бий болгох нь, Берлин хот, 2002 он.

15 Аннэ Ворст, Нэгэн тагнуулын албаны сүйрлийн түүх буюу Штази амьд хэвээрэ байна уу, Берлин хот, 1991 он.

нэгдмэл социалист нам дарга Эрих Хонеккер 1989 оны 10 сарын 17-нд ажлаасаа халагдсаны дараа, тун удалгүй 11 сарын эхээр Улсыг аюулаас хамгаалах яамнаас тус газар хадгалагдаж байсан нууц бичиг баримтууд устгах ажлыг эхлүүлсэн байдаг. 1990 оны 1 сарын дунд хүртэлх хугацаанд БНАГУ-ын удирдлагын зүгээс Улсыг аюулаас хамгаалах яамны аппаратыг хэвээр үлдээх сонирхол байсны улмаас тус яаманд хадаглагдаж байсан бичиг баримт, энэхүү цөм мэдээллийг нэгмөсөн устгах сонирхол байгаагүй. Иймээс энэ хугацаанд тодорхой нэг хэсэг бичиг баримтууд устгалд өртсөн. 1989 оны 12 сараас бичиг баримтыг устгах ажиллагаа улам бүр хүндэрч эхэлсэн. Учир нь бичиг баримтын устгал хийж эхэлсэнийг мэдсэн иргэд Улсыг аюулаас хамгаалах яамны салбарын байруудыг, улмаар тус яамны төв байрыг эзлэн өөрийн мэдэлд авцгаасан. Ингээд тооцохоор бичиг баримт устгах ажил ердөө л 8-10 долоо хоногийн хугацаанд л үргэлжилсэн байх магадлалтай юм.

1990 оны 1-р сард гадаадын тагнуулын үйл ажиллагааг хариуцаж байсан төв салбар өөрийн архивт байсан бичиг баримтыг бүхэлд нь устгалд оруулсан бөгөөд үүнд сөрөг хүчнийхэн ямар нэг байдлаар саад үзүүлээгүй байдаг.¹⁶ Ингэснээр Баруун Германы нутаг дэвсгэр дээр ажиллаж байсан албан бус мэдээлэгч, тэдний үйл ажиллагаанд өртсөн байгууллага хүмүүсийн талаарх мэдээлэл устаж алга болсон. Бусад тохиолдлуудад устгалын ажлыг таслан зогсоож чадсан. Ингэснээрээр нийт 41 сая хувийн хэрэг, 111 км-тэй тэнцэх хэмжээний нийт урттай тавиур дүүрэн бичиг баримтууд хадгалагдан үлдсэн. 1990 онд хоёр Герман улс нэгдсэний дараагаар эдгээр бичиг баримтуудыг Засгийн газрын онцгой эрхт төлөөлөгч, санваартан Иоахим Гаукийн мэдэлд шилжүүлсэн. Тэрээр хожим нь Холбооны өрөнхийлөгчөөр сонгогдон, өнөөг хүртэл тус албан тушаалыг хашиж байна.¹⁷ Улсыг аюулаас хамгаалах яамнаас дотоодод явуулж байсан хянан цагдах үйл ажиллагааны бичиг баримтууд харьцангуй бүрэн хэмжээгээр үлдсэн байхад тус байгууллагын гадаадад явуулж байсан ажиллагааны талаар бичиг баримтууд бүрэн бус байдаг.¹⁸

Коммунист намын гишүүдийн бичиг баримт, хувийн хэргийн тал дээр үйл явдал өөрөөр өрнөсөн байдаг. ГНЧН-ын үйл ажиллагааг зогсоож, татан буулгаагүйн улмаас нийт бичиг баримтууд намын мэдэлд хэвээр үлдсэн.

16 Хүбертус Кнабе: Бүгд найрамдах улсын тогтолцоонд шургалан орсон этгээдүүд. Улсыг хамгаалах албаныхан баруунд, Берлин хот 1999 он; Хүбертус Кнабе: БНАГУ-ын сэтгэл татсан нууцлаг байдал ба барууны хэвлэл мэдээллийнхэн., Берлин Мюнхен хот, 2001 он; Хүбертус Кнабе: Улсыг аюулаас хамгаалах яамны барууны орнуудад явуулж байсан үйл ажиллагаа. Соён гэгээрүүлэх, хариу цохилт өгөх ажлуудын хослол, Берлин хот 1999 он.

17 http://www.bstu.bund.de/DE/BundesbeauftragterUndBehoerde/BStUZahlen/_node.html; Силкэ Шүманн: Устгах уу эсвэл олон нийтэд ил болгох уу? Улсыг аюулаас хамгаалах яамны бичиг баримтыг хянан зохицуулах хуулийг батлах үйл явц, 1990-91 онуудад явагдаж байсан хэлэлцүүлгүүдийн тойм, эрхлэн хэвлүүлсэн БНАГУ-ын Улсыг аюулаас хамгаалах албаны бичиг баримтыг хянан зохицуулах Холбооны засгийн газрын онцгой эрхт төлөөлөгч, Берлин хот, 1995 он.

18 Кнабе: Улсыг аюулаас хамгаалах яамнаас баруунд явуулж байсан үйл ажиллагаа, 38 болон түүний дараах хуудсууд (16-г хар).

Тус нам 1989 онд Германы нэгдсэн социалист нам – ардчилсан социалист нам, 1990 оноос зөвхөн Ардчилсан социалист нам болон нэрээ өөрчлөхдөө хүртэл намын акт бичиг баримтуудыг өөрийн мэдэлд хэвээрээ үлдээсэн. Намын эрхтэн дархтнууд тухайн үед намын гишүүдийн гишүүнчлэлийн картыг устгасан төдийгүй Төв хорооны аюулгүй байдлын хэлтэс, Улс төрийн товчооны гишүүдтэй холбоотой онц чухал бичиг баримтуудыг устгасан байдаг.¹⁹ 1990 оны 6 сарын 1-ээс эхлэн ГНСН, бусад нам, олон нийтийн байгууллагуудын бичиг баримтуудыг БНАГУ-ын ерөнхий сайдаас цохон томилсон хараат бус комиссын мэдэлд байхаар зохицуулсан хууль гарсан боловч энэ практикт тэр бүр хэрэгжиж, жинхэнэ хяналтыг бий болгож чадаагүй. Хоёр Герман улс нэгдсэний дараагаар БНАГУ-ын төрийн байгууллагын бичиг баримтуудыг Холбооны архивын мэдэлд шилжүүлсэн. Намын холбогдолтой бичиг баримтуудыг 1992 онд тус архивт шилжүүлсэн. Нэгэн зүйлийг энд дурдахад улсын үйлдвэрийн газар, байгууллагууд, нийгэмлэгүүд баримт бичгүүдийн устгал хийсэн бөгөөд эдгээрт ямар нэг хяналт байгаагүй энэ устгалд орсон бичиг баримтуудын тоо хэмжээ тодорхойгүй бөгөөд Германы нэгдмэл социалист намаас устгасан бичиг баримтын тоо хэмжээтэй харьцуувал хавьгүй илүү гэдэг нь тодорхой юм.²⁰

4. Мөрдөн байцаах үйл ажиллагаа

Аливаа нэг дарангуйлагч дэглэм нуран унасны дараагаар тухайн дэглэмийн үед үйлдсэн улс төрийн гэмт хэргийг эрүүгийн хуулийн дагуу мөрдөн байцааж, яллан шийтгэх үйл ажиллагаа асар их ач холбогдолтой юм. 1990 оны 10 сарын 3 хүртэл буюу хоёр Герман улс нэгдэх хүртэлх хугацаанд энэ ажлыг БНАГУ-ын шүүх хариуцан ажиллаж байв. Зарим нэг тохиолдлыг авч үзэхэд БНАГУ-ын шүүхийн зүгээс энэ асуудалд тус ажлыг сүүлд хариуцах болсон ХБНГУ-ын шүүхээс илүү шийдэмгий хандсан байдаг нь ажиглагддаг. Жишээлэхэд 1989 оны 11 сарын сүүлчээр Улс төрийн товчооны гишүүдийн оршин суудаг Вандлиц тосгонд Германы нэгдмэл социалист намын эрх дархтнууд онцгой эрх ямба эдлэн амьдардаг нь ил болсонтой холбогдуулан Зүүн Берлин хотын Ерөнхий Прокурорын Газраас мөрдөн байцаах үйл ажиллагаа эхлүүлэн, тухайн жилийнхээ 12 сард нь энэ хэрэгт холбогдуулан Эдийн Засгийн асуудал хариуцсан Төв хорооны нарийн бичгийн даргын алба хашиж байсан Гюнтер Миттаг, Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга Харри Тиш, Улсын аюулгүй байдлын яамны сайд Эрих Мийлке, БНАГУ-ын Сайд нарын зөвлөлийн тэргүүн Вилли Штоф нарыг баривчилж хорьж байсан. Мөн БНАГУ-ын шүүхээс томоохон албан тушаал эрхэлж байсан нэр бүхий 44 хүн, тэр дундаа улс төрийн товчооны 21 гишүүнийг урьдчилан хорих шийдвэр гаргасан байдаг.²¹

19 Кнабе, Хонекерийн өв залгамжлагчид (9-ийг хар).

20 Германы нэгдмэл социалист намын дэглэм, түүний үр дагаварт дүн шинжилгээ хийх үүрэг бүхий „Enquete“ комиссийн тайлан, 1994 он: <http://dipbt.bundestag.de/dip21/btd/12/078/1207820.pdf>, 234-р хуудас.

21 Дэлгэрэнгүйг дараах эх сурвалжаас харна уу. Кнабе: Гэмт этгээдүүд бидний дунд (4-ийг

Эдгээр этгээдүүд ихэнх тохиолдолд улсын хөрөнгө завшсан хэргээр буруутгагдан байцаагдаж байсан бөгөөд хожим нь сонгуулийн үр дүн будлиантуулсан хэргээр нэмэн шалгагдах болсон. 1990 оны 10 сарын 3-ыг хүртэл нийт 100-аас дээш тооны этгээдийг албан тушаалаа урвуулан ашигласан, хээл хахууль авсан, сонгууль будлиантуулсан хэргээр шүүхэд шилжүүлсэн байдаг. Эдгээрийн дөнгөж 27-г нь БНАГУ-ын хуулийн дагуу таслан шийтгэсэн. Харин хүний эрх чөлөөг хязгаарласан, хоригдлуудад хүчирхийлэл үзүүлсэн, хүний амь нас бүрэлгэсэн зэрэг хүнд гэмт хэргүүдийг БНАГУ-ын шүүхийн зүгээс хэрэгсэж үзээгүй үлдээсэн байдаг. Цөөн тооны Ардын цагдаагийн ажилтнуудыг 1989 оны жагсаал цуглааны үеэр жагсагчдад хэрцгий хандсан гэсэн үндэслэлээр шүүхээр таслан шийтгэсэн байдаг.²²

Хоёр Герман улс нэгдсэн тэр үеэс эхлэн шинээр үүсэн байгуулагдсан холбооны муж улсуудын прокурорын газрууд энэхүү хэргүүдийн мөрдөн байцаах үйл ажиллагааг хариуцах болсон. Үүнтэй холбогдуулан Салцгиттер хотод байрлах Мөрдөн байцаах ажиллагааг нэгтгэн шалгах төв газраас БНАГУ оршин тогтнох 40 гаруй жилийн хугацаанд үйлдэгдсэн улс төрийн чанартай гэмт хэргүүдийг нэгтгэн бүртгэж байсан нийт 90 гаруй мянган мөрдөн байцаах актыг холбооны муж улсуудын Прокурорын Газруудад харъяалалынх нь дагуу хүлээлгэн өгч байсан. Шинэ тутам үүсгэн байгуулагдсан муж улсын прокурорын газрууд нь Германы нэгдмэл социалист намын зүгээс үйлдсэн бурангуй үйл ажиллагааг мөрдөн шалгах үүрэг даалгавар бүхий газруудыг дөнгөж 1992 оноос байгуулж эхэлсэн. Харин Берлин муж улсад 1990 оны 10 сарын 3-ны өдөр Засгийн газрын гэмт хэргийн чанартай үйлдлүүдийг хянан шалгах ажлын хэсэг Берлиний Танхимын шүүхийн дэргэд байгуулагдаж үйл ажиллагаагаа эхлүүлсэн байдаг. Тус ажлын хэсэг нь мөн тэр үед шинээр байгуулагдсан Засгийн Газар, Төрийн бүс байгууллагуудын гэмт хэргийн чанартай үйлдэлтэй тэмцэх төв газрын удирдлаган дор үйл ажиллагаагаа явуулж байсан. Шалгах гэмт хэргийн тоо хэмжээ маш өндөр байснаас шалтгаалан дээрх байгууллагууд ажлын ачааллаа дийлэхгүйд хүрч, гэмт хэргийн мөрдөн байцаах үйл ажиллагаа ихээхэн хэмжээгээр сунжирч, үүний улмаас гэмт хэргийн хэрэгсэх хугацаа хэтрэх, гэмт этгээдүүд өндөр настай болж, эрүүл мэндийн шалтгаанаар хэрэг хүлээх чадваргүй болох зэрэг нөхцөл байдал үүсч байлаа. Энэ нь нэг ёсондоо өршөөл үзүүлсэнтэй адил нөхцөл байдлыг бий болгосон байдаг.²³

хар), 87-89-р хуудас; Клаус Марксэн/ Герхард Вэрлэ: БНАГУ-ын үед тохиосон бурангуй үйл ажиллагааг эрүүгийн эрх зүйн үүднээс дүгнэн шинжилхүй, Берлин хот, 2000-2009 он; Клаус Марксэн/ Герхард Вэрлэ/Пэтра Шэфер: Яллан шийтгэл ба БНАГУ-ын үед тохиосон бурангуй үйлдлүүд. Баримтжуулалт. 1-9-р боть, Берлин хот, 2000-2009 он; Клаус Марксэн/ Герхард Вэрлэ/Пэтра Шэфер: БНАГУ-д үйлдэгдсэн бурангуй үйл ажиллагааг мөрдөн шалгаж, ял шийтгэл хүлээлгэсэн байдал. Тоо баримтууд, фактууд. Берлин хот, 2007 он.

22 Кнабе, Гэмт этгээдүүд бидний дунд, (4-ийг хар), 89-р хуудас.

23 Мөн тэнд, 91-94-р хуудас.

Эдгээр асуудлууд төвлөрсөн мөрдөн байцаах газар байгаагүйн улмаас гарч байсан хэдий ч энэ нь 1990 онд үйлдсэн БНАГУ болон Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын холбооны улсын тогтолцоонд элсэн орох тухай нэгдлийн гэрээний заалтуудын улмаас үүсэн бий болсон асуудлуудтай харьуулахад харьцангуй жижиг асуудлууд гэж хэлж болохоор байгаа юм. Тус нэгдлийн гэрээгээр талууд БНАГУ-ын үед үйлдэгдсэн гэмт хэргийг тухайн үед хүчинтэй байсан хуулийн дагуу буюу БНАГУ-ын Эрүүгийн хуулийн дагуу шийдэж байхаар тохиролцсон байдаг. Тус заалт нь үндсэн хуульд тусгагдсан хууль буцаан үйлчлэхгүй байх зарчимд үндэслэгдсэн боловч ихэнх гэмт хэргийг мөрдөн шалгах боломжгүй болгосон заалт байлаа. Учир нь тухайн үеийн БНАГУ-д үйлчилж байсан хуулийн дагуу ихэнх үйлдлүүд хуульд нийцсэн үйлдлүүд байсан юм. Харин Холбооны Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр хил хууль бусаар нэвтрэхээр завдсаны улмаас буудан хороогдсон иргэдийн асуудал гэх мэт зарим нэг тохиолдлууд, мөн тухайн үед үйлчилж байсан БНАГУ-д хуульд үл нийцсэн шүүхийн шийдвэрийг дахин хянаж, ял шийтгэл оноож болох боломжтой болсон.²⁴

Хууль буцан үйлчлэхгүй байх зарчим нь нэгдлийн гэрээнд тусгагдсан, мөрдөн байцаах үйл ажиллагаанд хориг тавьсан цорын ганц заалт байсангүй. 1990 оны 10 сарын 3-аас Зүүн Германы нутаг дэвсгэр дээр ХБНГУ-ын эрүүгийн хууль үйлчилж эхэлсэнээр аливаа гэмт хэргийг энэхүү хуулийн дагуу яллан шийтгэх шаардлага гарч ирсэн. Гэхдээ аливаа үйлдлийг хоёр эрүүгийн хуулийн хоёуланг нь хэрэглэхэд аль алиных нь дагуу ял шийтгэл оноохоор байвал тус гэмт үйлдлийг мөрдөн байцааж байхаар зохицуулсан бөгөөд тухайн хоёр хуулийн аль хөнгөн ял оноох заалттайг нь хэрэглэх зарчмыг барьж байхаар тохиролцсон. Жишээлэхэд хоёр хууль хоёулаа гэмт хэргийг хүчингүй болгох хугацааг заасан байвал, тухайн хоёр хуулийн аль бага хугацаа заасныг нь хэрэглэнэ гэсэн үг юм. Энэхүү тохиролцооны дагуу захидлын нууцыг чандлан хадгалах зарчмыг зөрчсөн гэмт хэргүүдийг хэрэгсэж үзэхээргүй болж байгаа юм. Хэдийгээр хоёр Герман улсын аль алинд нь захидлын нууцыг задруулах нь гэмт хэрэгт тооцогдож байсан боловч Холбооны Герман Улсын хуулийн дагуу хохирогч гэмт үйлдлээс хойш 3 сарын дотор өргөдөл гаргаагүй бол хэргийг хэрэгсэхгүй болгохоор зохицуулагдсан. БНАГУ-д хэнд ч энд дурдсан гурван сарын хугацаанд өргөдөл гаргах боломж байгаагүй нь ойлгомжтой юм.²⁵

Хуулийн үйлчлэх хүрээ хязгаарлагдмал, шүүхийн зүгээс хуулийн заалтад хийсэн тайлбарууд нь хүлэгдмэл, шүүхийн байгууллага боловсон хүчний дутагдалтай зэргээс шалтгаалан хуучин эрх мэдэлтнүүдээс цөөн тооны

24 Нэгдлийн гэрээний 1-р хавсралт: Холбооны эрх зүйн актыг хүчин төгөлдөр болгон хүлээн зөвшөөрөхөд мөрдөгдөх онцгой заалтууд. Чиглэл С, 2-р хэсэг, дугаар 1, 1-р зүйл, Герман улс буцан нэгдэх асуудлуудыг зохицуулах гэрээнүүд, индекс, удиртгал үг бүхий хэвлэл, эрхлэн хэвлүүлсэн Инго фон Мюнх, Мюнхен хот, 164-р хуудас.

25 Кнабе, Гэмт этгээдүүд бидний дунд, (4-ийг хар), 98-р хуудас.

хүмүүс л яллан шийтгэл эдэлсэн байдаг. Герман Улсад хэдийгээр 62 000 тохиолдолд 100 000 гаруй хүнийг мөрдөн шалгасан байдаг боловч эдгээрийн зөвхөн нэг хувьтай тэнцэх тооны хүмүүс шүүхээр таслан шийтгүүлсэн байдаг. Олон тохиолдолд шүүгчид мөрдөн байцаах ажиллагааг зогсоох эсвэл сэжигтнийг цагаатгах шийдвэр гаргасан байдаг. 1998 оны дунд үеийн байдлаар нийт 298 хүн ял шийтгүүлж, үүнээс 40 нь ял эдэлсэн гэсэн тоо баримт байна. Энд дурдахад Германы Нэгдсэн Социалист Намын Ерөнхий нарийн бичгийн даргын албыг хамгийн сүүлд хашиж байсан Эгон Кранц, БНАГУ-ын хилийн цэргийн ерөнхий командлагч байсан Клаус-Дийтэр Баумгартэн нар шоронд суун ял эдэлжээ. Эдгээр хүмүүс дээд тал нь 3 жилийн ял эдэлсэн байдаг. Ингэхдээ зарим нэг нь ял эдэлж, ялын хугацаагаа дуусгасан байхад, нөгөө зарим нь өршөөлийн хуулийн дагуу суллагджээ. Германы нэгдмэл социалист намын даргын албыг хашиж байсан Эрих Хонеккер гадаад руу дүрвэн гарч, тэндээ баривчлагдан Герман улс руу буцаагдаж, түүнийг шүүн таслах ажиллагаа явагдсан ч тэрээр 1993 онд эрүүл мэндийн шалтгааны улмаас суллагдсан байна.²⁶

5. Боловсон хүчний шинэчлэл

Нийгэм дэх боловсон хүчний шинэтгэл нь өнгөрсөн үед тохиосон хэлмэгдүүлэлтийг дүгнэн шинжлэх, цагаатгах ажлын чухал хэсэг нь юм. Засгийн газар, парламент, захиргааны байгууллагууд, цаашлаад эдийн засгийн салбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, шашны байгууллагуудын удирдлагуудыг хуучны кадруудын хяналтаас гаргах шаардлага зайлшгүй бий болдог. Иймээс хянан шалгах процедур буюу лустрац явуулж, олон тооны хүмүүсийг халах хүртэл арга хэмжээ авах шаардлага гарч ирдэг. Харин энэ бүхэн ардчилсан нийгэмд хуулийн дагуу явагдах ёстой байдаг.

Германд энэхүү асуудалд хандахдаа юуны түрүүн хуучнаар Улсыг аюулаас хамгаалах яамны (Германаар Штази гэж нэрлэгддэг, орч.) ажилтнуудыг нээн илрүүлэхэд илүүтэй анхаарсан байдаг. Юуны өмнөс өрөг хүчний толгойлогчдын дунд нууц цагдаагийн газрын мэдээлэгчээр ажиллаж байсан хүмүүс байгаа нь илэрснээс болж Зүүн Германы шинээр бий болсон ардчилсан нийгэмд хуучны Улсыг аюулаас хамгаалах яамны ажилчид шургалан орсон байх вий гэсэн болгоомжлол бий болсон.²⁷ 1990 оны БНАГУ-ын хамгийн сүүлчийн чөлөөт сонгуулийн үр дүнд бий болсон парламентад хуучин мэдээлэгчээр ажиллаж байсан олон тооны иргэд сонгогдсон байдаг бөгөөд тус парламент нь Улсыг аюулаас хамгаалах яаманд хадгалагдан буй хувь хүний хувийн хэрэг, түүнд дэх мэдээллийг зөвхөн Улсын аюулгүй байдлыг хангахад

26 Клаус Марксэн/ Герхард Вэрлэ: БНАГУ-д бурангуй үйл ажиллагааг эрүүгийн эрх зүйн үүднээс дүгнэн шинжилхүй, (21-ийг үз), 156-221-р хуудас; Роман Графэ / Кристоф Шэфгэн: „Бид хийсэн ажилаа дүгнэвэл ажлын үзүүлэлт хангалтгүй байна” - 1990-1998 оны хугацаанд ГНСН-ын бурангуй үйл ажиллагааг мөрдөн байцааж, яллан шийтгэсэн байдал, Германы төв архив, 1999 он дугаар 1, 7-р хуудас.

27 Кристианэ Бауманн Ибрахим хочит Манфрэд Бөөмэ: Урван тэрслэх зарчим, Берлин хот, 2015 он; Биргит Лаханн: Нөхөр Юудас. Ибрахим Бөөмэгийн хоёр амьдрал, Берлин хот, 1992 он.

чиглэсэн нууцын зэрэглэлтэй хянан шалгах үйл ажиллагаанд ашиглаж болохоор заасан хуулийг баталж гаргасан байдаг. 1990 оны нэгдлийн гэрээ, 1991 оны Улсыг аюулаас хамгаалах яамны бичиг баримтуудын зохицуулах тухай хуулиудад өргөн цар хүрээтэй хяналтын механизмуудыг тусгаж өгсөн. Эдгээрийг хуулийн дагуу парламентын гишүүд, намын дарга нар, өмгөөлөгчийн эрх авсан иргэд, шашны байгууллагын ажилтнууд, эдийн засгийн салбарын удирдах түвшиний албан тушаалтнууд, төрийн албаны ажилтнууд Улсыг аюулаас хамгаалах яаманд ажиллаж байсан эсэхийг нэг бүрчлэн шалгах боломжтой болсон. Тус хуулийн заалтууд нь коммунист дэглэмийн үед улсын байгууллагуудад итгэх итгэл алдраад байсан Зүүн Германы иргэдийн итгэлийг олж авахад чиглэсэн чухал алхам байсан.²⁸

Нийт 1,7 сая тохиолдолд хянан шалгалт явагдсан бөгөөд тус үйл ажиллагаанд зориулан Холбооны түвшинд агентлаг байгуулан ажлуулсан бөгөөд ид ачааллынхаа үед 3000 гаруй ажилчин, ажилтантай үйл ажиллагаа явуулж, нийт хоёр тэрбум еврогийн төсвийн хөрөнгийг зарцуулсан байдаг. Нэг чухал зүйлийг дурдахад хянан шалгах үйл ажиллагааг хүн нэг бүр дээр заавал хийх ёстой гэж хуульчлагдаагүй. Тиймээс Бундестагийн гишүүдийн хувьд заавал шалгуулах шаардлагатай байгаагүй. 2006 оноос хойш хянан шалгалтыг зөвхөн удирдах дээд албаны хүмүүст хийх боломжтой болгож хуульчилсан байдаг.²⁹

Төрийн албаны ажилтнуудыг хянан шалгах ажиллагаа тухайн муж улс дахь эрх баригч улс төрийн намуудаас ихээхэн шалтгаалж байлаа. Холбооны муж улсын засгийн газарт эрх барьж буй нам консерватив үзэлтэй байх тусам хянан шалгах үйл ажиллагаа илүү эрчимтэй явагдсан байдаг. Мөн хөдөлмөрийн товчоо гэх мэт холбооны нийт нутаг дэвсгэрийг хамран үйл ажиллагаа явуулдаг төрийн агентлагууд нь Зүүн Германы нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаагаа явуулж эхлэхдээ дээрх хуулийг ашигласан нь их ховор байдаг. Коммунист намын халааг үе залгамжлан авсан Германы ардчилсан социалист нам мөн л өөрийн намын гишүүд болон намаас сонгогдсон парламентын гишүүдийг шалгуулахыг эрс эсэргүүцэж байлаа. Үүнээс гадна өмгөөллийн үйл ажиллагаа явуулах эрх авсан хүмүүсийн дунд Улсыг аюулаас хамгаалах яаманд орон тооны ажилтан байсан 300 гаруй хүн байсан хэдий ч мөн л шалгалтанд хамрагдаагүй байдаг. Түүнээс гадна Баруун Германд Улсыг аюулаас хамгаалах яамны мэдээлэгчээр ажиллаж байсан олон тооны иргэд байсан боловч энэ асуудлаар шалгуулсан хүн бараг байдаггүй. Хувийн хэвшлийн салбарт Улсыг аюулаас хамгаалах яамны олон тооны ажилчид шургалсан нь тодорхой боловч энд мөн л

28 1991 оны 12 сарын 20 өдрийн Улсыг Аюулаас Хамгаалах яамны бичиг баримтыг хянан зохицуулах тухай хууль: <http://www.gesetze-im-internet.de/bundesrecht/stug/gesamt.pdf>.

29 Энэ тухай дэлгэрэнгүйг дараах эх сурвалжаас уншина уу. Үүнд: Кнабе, Гэмт этгээдүүд бидний дунд, 138-р хуудас; Ханс-Кристиан Катэнхүзэн, Шинээр үүсгэн байгуулагдсан муж улсуудын төрийн албадад хийсэн хянан шалгалт. Хөдөлмөрийн болон төрийн албаны хууль эрх зүйн үндэс, түүний захиргааны практикт хэрэгжүүлж буй байдал, Берлин хот, 1999 он.

дээрхтэй адил дур зураг харагддаг. Компаниуд нь хуулийн дагуу гүйцэтгэх захирал, захирлуудын зөвлөл гишүүн, бусад удирдах ажилтан гэх мэт зөвхөн удирдах түвшиний ажилчдыг л шалгуулах боломжтой.

Явагдсан хянан шалгалт тоо хэдийгээр өндөр боловч үнэн хэрэг дээрээ ил тод байдлыг бий болгож чадаагүй юм. Мэдээллийн нууцыг чандлан хадгалах зарчмын үүднээс хянан шалгалтын үр дүнг зөвхөн шалгуулахаар өргөдөл гаргасан этгээд үзэх боломжтой байснаас хянан шалгалтын үр дүн ихэнх тохиолдолд нууц хэвээр үлдэж байсан. Мөн ажлын байраа солин, хянан шалгалтаас зайлсхийх тохиолдлууд гарч байсан. Судалгааны ажилчид, хэвлэл мэдээллийнхэнд сэжигтэй этгээд, байгууллагуудыг нэг бүрчлэн шалгуулах эрх байгаагүй. Хувь хүмүүст мөн адил ийм боломж байгаагүйг дурдах нь илүүц биз. Улсыг аюулаас хамгаалах яамны хэлмэгдэлтэнд өртсөн хүмүүс өөрийг нь тагнан турших үүрэг хүлээн ажиллаж байсан хүмүүсийн албан ёсны нэрийг мэдэх эрхтэй болсон хэдий ч тагнах үйл ажиллагаа хийж байсныг нотлох баримт зайлшгүй шаардлагатай болж байсан. Ийнхүү мэдээлэгч нарын сүлжээ тохиолдлоор, хааяа нэг бүрэн бус хэлбэрээр илрэн гарч ирсэн боловч Улсыг аюулаас хамгаалах яаманд ажиллаж байсан иргэд ихэнх тохиолдолд олон нийтэд нууц хэвээр үлдсэн.

Улсыг аюулаас хамгаалах яамны бичиг баримттай танилцах ажлыг зохион байгуулах тухай хуулинд тус байгууллагад ажиллаж байсан нь тодорхой болсон тохиолдолд ямар нэг арга хэмжээ авах талаар тусгагдаагүй байдаг. Улсыг аюулаас хамгаалах яамны ажилтан байсан хүн, тодорхой нэг албан тушаалыг хашиж болохгүй гэсэн хуулийн заалт байгаа учир хууль эрх зүйн дагуу бол урьд нь Улсыг аюулаас хамгаалах яаманд алба хааж байсан хүн Холбооны ерөнхийлөгч хүртэл байж болох боломжтой юм. Тухайн хүнд ямар арга хэмжээ авах нь ажил олгогчийн эрх мэдлийн асуудал байхаар зохицуулагдсан байдаг. Саксон, Тюрингэн, Саксон-Анхалт, Берлин, Мекленбург-Форпоммерн муж улсуудын төрийн албан хаагч нарын дунд хуучин Улсыг аюулаас хамгаалах яаманд ажиллаж байсан 28000-аас илүү тооны ажилтан ажиллаж байсан гэсэн тоо баримт бий. Энэ нь нийт албан хаагчдын 5 %-тай тэнцэж байна гэсэн үг юм. Тус ажилчдын талаас илүүг нь үргэлжлүүлэн ажиллуулахаар шийдвэрлэсэн байдаг. Ажил олгогчид ихэнх тохиолдолд тухайн хүнтэй нээлттэй ярилцах, эс бөгөөс өөр газар, агентлагууд руу шилжүүлэх арга хэмжээ авсанаар асуудлыг шийдсэн байдаг.³⁰

Холбооны муж улсууд, дүүргүүд, төрийн байгууллагууд тус бүрдээ энэ асуудалд ялгаатай хандаж байсан. Берлиний цагдаагийн газраас хуучны Улсыг аюулаас хамгаалах яаманд ажиллаж байсан ажилчдаа бүгдийг халсан бол Саксон, Бранденбург муж улсуудад хуучин Улсыг аюулаас хамгаалах яаманд ажиллаж байсан олон тооны ажилчдыг цаашид үргэлжлүүлэн

30 Кнабе, Гэмт этгээдүүд бидний дунд (4-ийг хар), 152-р хуудас.

ажиллах боломжоор хангасан. Зүүн Берлиний, Зүүнтний Намын удирдаж байсан дүүргүүдэд ажиллаж байсан багш нарыг үүрэгт ажлаа үргэлжлүүлэн хийх боломжийг олгож байсан бол Саксон муж улсад багш нар үүрэгт ажлаа үргэлжлүүлэн хийх боломж олгоогүй байдаг. Түүнчлэн Германы Социал-Демократ Намын эрх барьж байсан Бранденбург муж улсын Ерөнхий сайд Манфред Штолпег Улсыг аюулаас хамгаалах яамны ажилтан байсан гэсэн хардлага байдаг байсан бөгөөд тус муж улс хянан шалгалт хийхээс бүрмөсөн татгалзсан байдаг. Ингэснээрээ „жигжиг БНАГУ“ гэсэн хоч зүүх болсон жишээ бий.³¹

Хугацаа алдах тусам Улсыг аюулаас хамгаалах яаманд ажиллаж байсан хүмүүст ашигтайгаар эргэж байсан. Нэгдлийн гэрээнд заасны дагуу аливаа албан тушаалд байгаа хүнийг 1993 он хүртэлх хугацаанд л „хувь хүний зан чанарын хувьд таарч тохирохгүй“ гэсэн шалтгаанаар, мөн хуульд заасан хугацаанд ажлаас халах боломжтой байсан.³² Үнэхээр цааш үргэлжлүүлэн ажиллуулах хэцүү нөхцөл байдал үүссэн тохиолдолд хуулинд хугацааг үл харгалзан ажлаас халах боломжтой байхаар хуульчилсан байсан. Мөн удалгүй хөдөлмөрийн шүүхийн тодорхой шийдвэрүүдийн улмаас энэ заалт бараг практик ач холбогдолгүй болсон гэж дүгнэж болох юм. Ажилдаа орохдоо санаатайгар худал мэдээлэл өгөөгүйгээс бусад тохиолдолд хөдөлмөрийн харилцаа үүссэнээс ажлаас халах боломжийг бүр мөсөн хязгаарласан. Улсыг аюулаас хамгаалах яамнаас үлдсэн бичиг баримтыг хянан зохицуулах ажлыг хариуцан ажиллаж байсан Засгийн Газрын онцгой эрхт төлөөлөгчийн алба хашиж байсан Роланд Яан гэхэд л энэхүү хуулийн зохицуулалтын уршгаар түүний удирдаж байсан байгууллагын урьдын дарга нар хүлээн зөвшөөрөн ажилд оруулсан, Улсыг аюулаас хамгаалах яаманд ажиллаж байсан тодорхой 50 гаруй ажилтныг шууд халах боломжгүй болж байсан байдаг.³³

Улсыг аюулаас хамгаалах яаманд хадгалагдаж байсан бичиг баримт, акт, хувийн хэргүүдийг тухайн асуудлыг хариуцсан байгууллагаас дөнгөж 1996 оны үед нэгмөсөн цэгцэлж дуусган, тухайн цаг үеэс эхлэн тус байгууллага нь аливаа хүний өнгөрсөн түүхийн талаар баталгаат мэдээллийг өгөх боломжтой болсон. Энэхүү нөхцөл байдал нь асуудлыг хүндрүүлэх нэг гол шалтгаан байсан. Учир нь 1996 он гэхэд хянан шалгалтын ихээхэн хэсгийг

31 Мөн тэнд, 153-р хуудас; „Enquete“ комиссийн захиалгаар „Бранденбург муж улсад Түүхийн үйл явдлыг дүгнэн шинжлэх, ГНЧН-ын дарангуйлагч дэглэмийн үр дагавартай тэмцэх, ардчилсан эрх зүйт нийгэмд шилжих шилжилтийн ажилд“ дүгнэн шинжилсэн мэргэжлийн: „Бранденбург муж улсын мужийн парламент, мужийн засгийн газар, мужийн захиргаан дахь Боловсон хүчний залгамж байдал, элитүүдийн хувирал өөрчлөлт“ (http://www.parldok.brandenburg.de/parladoku/w5/drs/ab_8500/8500_13.pdf).

32 Тус хугацаа нь 1992 оны 10 сарын 3-аар дуусах байсан бөгөөд хугацааг 1993 оны 12 сарын 31 хүртэл сунгасан, Нэгдлийн гэрээний 1-р хавсралт: Холбооны эрх зүйн актыг хүчин төгөлдөр болгон хүлээн зөвшөөрөхөд мөрдөгдөх онцгой заалтууд, Герман улс буцан нэгдэх асуудлуудыг зохицуулах гэрээнүүд, 471-р хуудас.

33 Ханс Х. Клайн/ Клаус Шрээдэр/ Штэффэн Алиш: Улсыг аюулаас хамгаалах яамны бичиг баримтыг хянан зохицуулах ажлыг хариуцсан Холбоон агентлагт хуучин тус нэр бүхий байгууллагад ажиллаж байсан хүмүү алба хашиж байгаа эсэх талаар мэргэжилтний дүгнэлт, Берлин хот, 2007 он (<https://wikileaks.org/wiki/Stasi-in-bstu.pdf>).

хийж гүйцэтгэсэн буюу 1,3 сая өргөдлийг шалгаж хариу өгчихсөн байсан.³⁴ Үүнээс гадна хуулийн дагуу 1976 оноос өмнө Улсыг аюулаас хамгаалах яаманд ажиллаж байсан бол энэ талаарх мэдээллийг 1998 оны найман сараас эхлэн цааш нь дамжуулах эрхийг хязгаарласан. Дээрх хянан шалгалтын ажил нь нэг талаас хуучны Улсыг аюулаас хамгаалах яаманд ажиллаж байсан хүмүүс хоорондоо хэлхээ холбоотой байж, зохион байгуулалтанд орохоос сэргийлж чадсан ч, нөгөө талаас тус байгууллагад ажиллаж байсан олон тооны ажилтан нөлөө бүхий албан тушаалд томилогдон очихоос урьдчилан сэргийлж чадаагүй. Нэн ялангуяа Зүүнтний намын гишүүд парламентын гишүүний албан тушаалыг хүртэл хашиж байна.

Энд дурдсан хянан шалгалтыг Улсыг аюулаас хамгаалах яаманд ажиллаж байсан эсэхийг шалгахад чиглүүлсэн нь олон нийтийн анхаарал, олон нийтийн мэтгэлцээн Германы нэгдмэл социалист намын эрх барих албан тушаалд байсан эсэх дээр биш, хэн нь хэр хэмжээгээр хэнийг тагнасан бэ гэсэн асуудал руу чиглэх болсон. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд удаан хугацааны туршид олон нийтийн танил ямар ямар хүн хуучны Улсыг аюулаас хамгаалах яамтай хамтран ажиллаж байсан гэдгийг сонирхон эрэн сурвалжиж байсан нь тухайн дэглэмийн жинхэнэ хариуцлагатай этгээдүүд олон нийтийн анхаарлаас зайлсхийх боломж олгосон байдаг. Үүнээс гадна хувь хүн биеэ өмөөрч, хувийн алдаагаа үгүйсгэн Улсыг аюулаас хамгаалах яамны үйл ажиллагааны зарчмын талаар, нэн ялангуяа тэнд ажилж байсан офицерууд албан бичгийг дураараа өөрчлөн үйлдэх боломжтой байсан мэтээр олон нийтэд буруу ойлголт төрүүлэх үйлдэл тохиолдлууд гарч байсан. ГНСН-ын халааг авсан Германы Зүүнтний намын парламентын бүлгийн дарга Грегор Гизиг энд дурдаж болох юм.³⁵

Зарим нэг газар ГНСН-д ажиллаж байсан нь илэрсэн тохиолдолд төрийн байгууллагын албан тушаалаас халах тухай зохицуулалт хийгдсэн байсан. Жишээлэхэд 1991 онд Тюринген муж улсын Засгийн газраас коммунист дэглэмийн үед нэр бүхий тодорхой албан тушаал хашиж байсан бол төрийн албанд ажилд авахгүй байхаар шийдвэрлэсэн байдаг. Тодруулж хэлбэл Германы Нэгдсэн социалист намд орон тооны албан тушаал, мужийн буюу тойргийн намын үүрийн удирдах албан тушаал, Зэвсэгт хүчний байгууллагад намын үзэл сурталын ажилтны албан тушаал хашиж байсан хүмүүс нь төрийн албан тушаал хашихад тохиромжгүй болохыг энэхүү заалтад тусгасан.³⁶ Саксон муж улсад 1994 оны 12 сараас төрийн албан тушаалд өргөдөл гаргаж буй хүмүүс өргөдлийн маягт бөглөхдөө урьд нь намын ямар нэг нөлөө бүхий алба хашиж байсан эсэх тухай асуултад хариулах шаардалагатай болсон.³⁷ Мэдээлэл авах төвлөрсөн газар байхгүй, намын гишүүний хувийн хэрэг нь

34 Кнабе, Гэмт этгээдүүд бидний дунд (4-ийг хар).

35 Кнабе, Хонеккерийн өв залгамжлагчид, (9-ийг хар).

36 Кнабе, Гэмт этгээдүүд бидний дунд (4-ийг хар).

37 Мөн тэнд.

(устаж алга болоогүй бол) намын архивт хадгалагдаж, энэ талаар ямар нэг мэдээлэл авах боломжгүй байсны улмаас шинэ муж улсуудад тэр бүрчлэн ГНСН-д удирдаж албан тушал хашиж байсан эсэхийг шалгаад байгаагүй. Тэгээд ч намын гишүүний хувийн хэргийг 1990 онд шинэчилсний улмаас ямар нэг ач холбогдол бүхий мэдээлэл агуулагдаж байгаагүй нь тодорхой байсан.

Германы цөөн хэдэн салбарт боловсон хүчний шинэтгэлийг тууштай явуулсан байдаг. Жишээлхэд БНАГУ-ын Үндэсний Ардын Армийг Герман улсын нутаг дэвсгэр дээр байх нийт цэргийн тоог хязгаарласны дагуу бараг бүхэлд нь тараасан. Тухайн үед нийт 36000 хүний бие бүрэлдэхүүнтэй байсан офицеруудаас 3200-г нь Холбооны армид элсүүлэн авсан.³⁸ Түүнээс гадна олон их сургуулиудад боловсон хүчний шинэтгэл хийгдсэн. Их сургуулиуд дээр тусгай комисс байгуулагдан хүн нэг бүрийг эрдмийн ажлын үр чадварын шалгалтад хамруулсан. Мөн Зүүн Германы шүүхийн тогтолцоонд ажиллаж байсан хоёр шүүгч тутмыг нэгийг шинэчилсэн байдаг.³⁹

6. Хэлмэгдэгсдэд олгосон нөхөн төлбөр

Аливаа нэг дарангуйлагч дэглэм нуран унасны дараа хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдэнд тохиосон бурангуй үйлдэлд нөхөн төлбөр олгох зэрэг нь нэн түрүүн хийгдэх ёстой ажлуудын нэг байдаг. БНАГУ-д чөлөөт сонгуулиар сонгогдсон ардын танхим 1990 оны 9 сард хэлмэгдэгсдийг цагаатган, нэр төрийг сэргээх тухай хууль батлан, их хэмжээний нөхөн олговор олгохоор хуульчилсан байдаг. Харин хоёр Герман улс нэгдэх үйл явцад ирээдүйд их хэмжээний нөхөн олговор олгох шаардлага гарахаас болгоомжилон Холбооны Засгийн газраас тус хуулийг Холбооны хүчин төгөлдөр хууль эрх зүйн акт болгохоос татгалзсан байдаг. Зөвхөн эрүүгийн хуулийн дагуу шийтгэгдсэн иргэдийг цагаатгах тухай заалт хүчинтэй хэвээрээ үлдсэн.

1990 оны 7 сард ХБНГУ, БНАГУ-ууд БНАГУ-ын үед хураагдсан эд хөрөнгийг эздэд нь буюу тэдгээрийн үр хүүхдүүдэд буцаан олгох тал дээр тохиролцоонд хүрсэн. 1990 оны 9 сард Ардын танхимаас энэ талаар хууль батлан гаргасан бөгөөд тус хууль нь хоёр Герман улс нэгдсэний дараа хүчин төгөлдөр Холбооны эрх зүйн акт болсон. БНАГУ үүсгэн байгуулагдахаас өмнө ЗХУ-ын зүгээс нөхөн төлбөргүйгээр хураан авсан хөрөнгө энэхүү хуульд хамаарагдахгүй байхаар тусгагдсан. Ингэснээр их хэмжээний эдлэн болон үйлдвэрийн газрууд улсын мэдэлд хэвээр үлдэж, буцаан олгогдох боломжгүй болсон.

38 Гуннар Дигуч, Үндэсний Ардын Армийг халж, шинээр байгуулагдсан холбооны муж улсуудад Холбооны армийн бүтэц зохион байгуулалтыг бий болгосон нь, Майн дахь Франкфурт Берлин, 2004 он; Дийтэр Фарвик (Эрхлэн хэвлүүлсэн) Нэг Улс – Нэг арми. Үндэсний Ардын Армиас Холбооны арми хүртэлх түүхэн замнал, Майн дахь Франкфурт, 1992 он.

39 Кнабе, Гэмт этгээдүүд бидний дунд (4-ийг хар).

ГНСН-ын дарангуйлагч дэглэм нуран унасны дараа юуны өмнө хүний эрхийн төлөө тэмцэгчид тэдний нэр дээр нээн хөтөлж байсан Улсыг аюулаас хамгаалах яамны хувийн хэрэгтэй танилцах боломж олгохыг шаардах болсон. Энэхүү асуудлыг зохицуулсан, Ардын танхимаас баталсан хуулийг нэгдлийн гэрээ үйлдэж байх явцад Холбооны Герман Улсын хүчин төгөлдөр хууль эрх зүйн акт болгохоос татгалзсан шийдвэр гарсны дараагаар сөрөг хүчний удирдагч олны танил хэд хэдэн хүмүүс хуучнаар Улсыг аюулаас хамгаалах яамны байрыг эзлэн авч, өлсгөлөн зарласан.⁴⁰ Энэ үйл явдлаас улбаалан хоёр тал нэгдмэл парламент бий болсны дараагаар тус асуудлыг зохицуулсан хууль батлах тухай харилцан тохиролцсон. Тус хууль Улсыг аюулаас хамгаалах яамны хувийн хэрэгтэй танилцах тухай хууль нэртэйгээр 1991 оны 12 сард батлагдан гарч, эхний ээлжийн хүмүүс 1992 оны эхэн гэхэд өөрсдийн хувийн хэрэгтэй танилцах боломжтой болсон. Зүүн Европын иргэд нь ийм хурдан хугацаанд өөрсдийн хувийн хэрэгтэй танилцах боломжоор хангагдаж байгаагүйг энд дурдах хэрэгтэй. 2014 оны сүүлч гэхэд нийт Герман даяар давхардсан тоогоор 3 сая гаруй хүн өөрийн хувийн хэрэгтэй танилцах өргөдөл гаргасан гэсэн тоо баримт бий.⁴¹

1992 онд ГНСН-ын дарангуйлагч дэглэмд хэлмэгдсэн иргэдэд нөхөн төлбөр олгох тухай анхны хуулийг батлан гаргасан. Тухайн үеийн Германы Христ-Социалист намаар удирдуулсан Засгийн газар нацист дэглэмд хэлмэгдэгсдэд нөхөн төлбөр олгох тухай заалтуудыг авч хэрэглэхээс татгалзан, санхүүгийн дарамт багатай нөхөн төлбөрийн шинэ схемийг хэрэгжүүлэхээр болсон. Ингэснээр санхүүгийн эх үүсвэрийг нөхөн төлбөрт бус „Зүүн Германы бүтээн байгуулалт” хөтөлбөрт чиглүүлэх боломжтой болсон.⁴² Германы нэгдмэл социалист намын бурангуй үйлдлийн тухай анхны хууль нь эрүүгийн хуулийн дагуу хилсээр ял шийтгэл эдэлсэн хүмүүсийг цагаатгах, тэдэнд нөхөн төлбөр олгох асуудлыг зохицуулсан байдаг.⁴³ Энэ хуулиар БНАГУ-ын улс төрийн гэмт хэргийн тухай хуулийн тодорхой заалтууд дээр үндэслэсэн шүүхийн шийдвэрүүдийг хүчингүй болгон, ял эдэлсэн нэг сар тутам 300 дойч марк-ийн мөнгөн төлбөр олгохоор заасан. Энэ нь тухайн үед ХБНГУ-ын хуулийн дагуу хилсээр ял эдэлсэн хүмүүст олгож байсан нөхөн төлбөрийн даруй тал хувьтай нь тэнцэх хэмжээний мөнгө байсан. 1998 онд Германы Социал-Демократ нам сонгуульд ялж, энэ хоёр нөхөн төлбөрийн хэмжээг нэгэн ижил түвшинд болгож, ял эдэлсэн сар тутам 306,78 Евро олгохоор шийдвэрлэсэн. Ингэхдээ эхэлсэн сар тутмыг бүтэн сараар тооцон олгох болсон. Нацист дэглэмийн үед шоронд хоригдож байсан хүмүүст нөхөн

40 Шүманн: Устгах үү, олон нийтэд ил болгох үү (17-г хар).

41 http://www.bstu.bund.de/DE/BundesbeauftragterUndBehoerde/BStUZahlen/_node.html.

42 Улрикэ Гукэс: Хэлмэгдэгсдэд нөхөн төлбөр олгох асуудал хоёр өөр шалгуураар явагдсан уу? Нацист болон коммунист дэглэмийн зүгээс үйлдсэн бурангуй үйл ажиллагааг засан залруулж, нөхөн төлбөр олгох ажлын хуулийн үндсэн заалтуудыг харьцуулсан судалгаа, Берлин хот, 2008 он.

43 www.berlin.de/lageso/versorgung/soziales-entschaedigungsrecht/rentenleistungen/opfer-von-sed-unrecht/#strehtag.

төлбөр олгох тухай Холбооны хуулийн дагуу бол хэлмэгдэгсэд үүнээс бараг хоёр дахин их хэмжээний мөнгөн төлбөр авах эрхтэй байдаг.

1994 онд Германы нэгдмэл ёоциалист Намын бурангуй үйлдлийг засан залруулах тухай хоёр дахь хууль батлагдаж, энэ хуулиар улс төрийн хэлмэгдэгсдийн засаг захиргааны статус, хөдөлмөрийн чадвар алдасны нөхөн төлбөрийн хэмжээг зааж өгсөн.⁴⁴ Энэ хуулийн дагуу нөхөн төлбөрийг зөвхөн улс төрийн хоригдлуудад биш, бусад аливаа хэлмэгдэгсдэд олгож байхаар зохицуулсан. Тус хуулийн дагуу тодорхой захиргааны хэргийн шийдвэрүүдийг хүчингүй болгуулах боломжтой болсон. Жишээлхэд хөрөнгө хураасан, их дээд сургуулийн элсэлтээс хассан гэх мэт. Хоёрдугаарт, хоригдсон хугацааг нийгмийн даатгалд нөхөн тооцуулах өргөдөл гаргах боломж бий болсон. Гуравдугаарт, БНАГУ-ын үед ямар нэг мэргэжил эзэмших боломжийг нь хязгаарласан байсан иргэдийг мэргэжил эзэмших боломжоор хангаж, улсын тэтгэлэгт хамруулахаар болсон. Эцэст нь хэлэхэд тус хуулийн дагуу эмзэг бүлгийн иргэдэд сар бүр 184 Еврогийн (тэтгэвэр тогтоогдсон иргэд 123 Еврогийн) тусламж олгож байхаар болсон. Нацист дэглэмд хэлмэгдсэн иргэдийн цагаатгалын тухай хуулиас ялгаатай нь коммунист дэглэмийн хэлмэгдүүлэлтэд өртсөн иргэдэд ажлын байртай болох, ажилгүй байх хугацааны нөхөн төлбөр авах эрхийг олгоогүй.

Дээрх хоёр хууль батлагдан гарсан хэдий ч Германы нэгдмэл социалист намын дэглэмийн хэлмэгдүүлэлтэд өртсөн иргэд эдийн засгийн хувьд маш хэцүү байдалд байсаар байсан. Юуны өмнө эдгээр хүмүүс БНАГУ-ын үед ажил мэргэжилийн хувьд гадуурхагдаж байсны улмаас өндөр насны тогтоолгосон тэтгэвэрийн хэмжээ маш бага байсан. Харин Германы нэгдмэл социалист намд удирдах алба хашиж байсан хүмүүс Холбооны Үндсэн хуулийн цэцийн энэ асуудлаар гаргасан тодорхой шийдвэрүүдийн дагуу БНАГУ-ын үед авч байсан өндөр цалингаараа тэтгэвэр тогтоолгох эрхтэй болж харьцангуй өндөр тэтгэвэр авах болсон. Энэхүү асуудлын улмаас 2007 онд Холбооны Засгийн Газраас хэлмэгдэгсдийн тэтгэвэр гээчийг бий болгон, 180-аас дээш хоног шоронд хоригдож байсан, сарын орлого нь 1035 Еврогоос бага байгаа улс төрийн хэлмэгдэгсдэд сар бүр 250 Еврогийн (2014 оноос 300 Евро) тэтгэлэг олгож байхаар шийдвэрлэсэн.⁴⁵

Германы нэгдмэл социалист намын дэглэмийн үед хэлмэгдүүлэлтэд өртсөн иргэдэд олгож буй нөхөн төлбөр ерөнхийдөө бол билэг тэмдгийн төдий зүйл юм. Тэгээд ч учирсан хохирлыг тэр хэмжээгээр нь нөхөн олгох боломжгүй. Зөвхөн хураан авсан эд хөрөнгийн хувьд л боломжтой байсан. Үүн дээр нэмж хэлэхэд зарим нэг хэлмэгдэгсдийг энэ зохицуулалтад хамруулаагүй. Жишээлэхд хуучин Зүүн Германы нутаг дэвсгэр дээр хоригдож байсан

44 www.berlin.de/lageso/versorgung/soziales-entschaedigungsrecht/rentenleistungen/opfer-von-sed-unrecht/#berrehag.

45 www.berlin.de/lageso/versorgung/soziales-entschaedigungsrecht/rentenleistungen/opfer-von-sed-unrecht/#opferrente.

хүмүүсийг дурдаж болох юм. Ихэнх хохирогчдийн хувьд эрүүл мэндийн хохирол нь шоронд хоригдож байсны улмаас үүдэлтэй гэдгийг нотлох боломж байдаггүй улмаас тахир дутуугийн тэтгэвэрт хамрагдах боломжгүй байдаг.⁴⁶ Эцэст нь хэлэхэд БНАГУ-аас дүрэвсэн иргэдийн хувьд хоёр Герман улс нэгдсэний дараа нөхцөл байдал бүр хүндэрсэн. Учир нь эдгээр хүмүүсийг БНАГУ-ын иргэншилд буцаан хамруулж улмаар тэтгэвэрийн хэмжээг Зүүн Германд авч байсан цалингийн дагуу багасган тогтоосон байдаг.

7. Нийгмийн түвшин дэх дүн шинжилгээ

Дарангуйлагч дэглэм нуран унасны дараа, тухай нийгэмд болж өнгөрсөн хэлмэгдүүлэлтийн талаар олон нийтэд ойлголт өгөх нь чухал бөгөөд чухамхүү энэ нь ажлыг гүйцэтгэх үндсэн шалтгаан нь болж өгдөг.⁴⁷ Энэхүү ажлыг төрөл бүрийн хэлбэрээр хэрэгжүүлэн, зохион байгуулах боломжтой юм. Германд Латин Америкийн олон оронд хэрэгжүүлж байсантай адил „Үнэнийг тогтоох комисс” гэж байгуулагдаж байгаагүй. Харин 1992 оны 3 сард Бундестагаас БНАГУ-ын өнгөрсөн үеийн асуудлыг дүгнэн шинжлэх үүрэг бүхий „Enquete (мөрдөх, шалгах гэсэн утгатай франц үг, Орчуулагч)”-Комисс байгуулах шийдвэр гаргасан. 1994 оны Бундестагийн сонгуулийн дараа мөн ижил төстэй үүрэг даалгавар, бүрэлдэхүүн бүхий парламентын комисс хоёр дахь удаагаа байгуулагдан ажилласан. Эдгээр комиссууд тухайн үед олон тооны мэргэжлийн дүгнэлтүүдийг гаргаж, асуулга гэх мэт ажлыг гүйцэтгэн, ажилласан хугацааныхаа төгсгөлд их хэмжээний материалыг хэвлүүлэн олон нийтэд хүргэсэн байдаг.⁴⁸ 1998 онд үүн дээр үндэслэн Германы нэгдмэл социалист намын дарангуйлагч дэглэмийн үед үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах, хэлмэгдэгсэдийг цагаатгах ажлыг хариуцсан Холбооны сан үүсгэн байгуулагдсан. Энэхүү байгууллага нь өнөөгийн байдлаар ажлын чиг үүргийн дагуу төслүүдийг санхүүжүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэж байна.

БНАГУ-ын Улсыг аюулаас хамгаалах яамыг бүрмөсөн татан буулгаж, хоёр Герман Улсын хооронд хил байхгүй болсноор Улсыг аюулаас хамгаалах яамны харъяа шорон, мөн хил нэвтрэх байгууламжууд зэрэг нь бидэнд коммунист дэглэмийн гэрч болон үлдэж байгаа юм. Иймээс Берлин хотын Хээншөнхаузен дүүрэгт байрлах Улсыг аюулаас хамгаалах яамны урьдчилан хорих газрыг 1992 оноос түүхийн дурсгалт газрын тоонд оруулан хамгаалалтад авч, 1994 оноос түүхийн дурсгалын музей

46 Саксон-Анхалт мужийн улсын улс төрийн хэлмэгдэлтэд өртөгсдийн дурсгалыг хүндэтгэх асуудлыг хариуцсан газраас 10 сарын 26-ны өдөр Магдебург хотод „Германд 1945 оноос хойш шоронд хоригдсоны улмаас үүссэн ур дагаваруудын тухайдэрүүл мэнд, сэтгэл зүйн, улс төрийн дүгнэлт өгөх нь” сэдвээр зохион явуулсан мэргэжил дээшлүүлэх семинар, Магдебург хот, Морицын талбай, 1995 он.

47 Свэн Фэликс Кэллэрхофф, Түүхээс суралцахуй – Дарангуйлагч дэглэмийн хэлмэгдүүлэлтийн дүгнэн шинжлэхэд үйл ажилагаанд зориулсан гарын авлага, Бадэн-Бадэн хот, 2013 он.

48 Эрхлэн хэвлүүлсэн ХБНГУ-ын Бундестаг, ГНСН-ын дэглэмийн хэлмэгдүүлэлтийн түүх, түүний ур дагаварыг дүгнэн шинжилэх үүрэг бүхий Enquete Комиссийн материалаас (Бундестагийн хууль тогтоох үйл ажиллагаа явуулах 12 дахь удаагийн мөчлөг), Бадэн-Бадэн хот, 1995 он.

хэлбэрээр ажлуулахаар шийдвэрлэсэн байдаг. Тус газар нь 2000 оноос олон нийтийн өмчит төрийн сангийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна. Берлиний хананы нэг хэсгийг түүхийн дурсгалын хамгаалалтад авч, дурсгалт газрыг хариуцсан албан газрыг бий болгон, арчилгаа тордолтын ажлыг хариуцуулан ажилуулж ирсэн. Зүүн Германы нутаг дэвсгэр дээр засаг захиргааны хувьд муж улсын харъяалал бүхий төрийн сангууд байгуулагдан, коммунист болон нацист дэглэмүүдийг олон нийтэд үзүүлэн таниулах үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.⁴⁹ Эдгээр газруудын үйл ажиллагааг дэмжих зорилгоор Холбооны Засгийн Газраас 1999 онд дурсгалт газруудын концепц боловсруулсан бөгөөд үүнийг 2008 онд шинэчлэн найруулсан.⁵⁰ Германы хуулийн дагуу түүхийн дурсгалт газруудын үйл ажиллагааны санхүүжилтыг муж улсууд өөрсдөө хариуцах ёстой боловч үндэсний хэмжээний ач холбогдол бүхий түүхийн дурсгалт газруудын санхүүжилтын 50 хүртэлх хувийг Засгийн Газраас санхүүжүүлж байхаар зохицуулсан байна.

Улс төрийн хэлмэгдүүлэлтийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, дүгнэн шинжлэх энэ цогц ажлыг шинжлэх ухаан, хэвлэл мэдээлэл, музейн танилцуулга, хичээл сургалт гэх мэтээр нийгмийн янз бүрийн салбарыг хамруулан төрөл бүрийн хэлбэрээр хэрэгжүүлж болох бөгөөд энэ жижиг хэмжээний ажлын хүрээнд энэ бүгдийг авч үзэх боломжгүй юм. Санал асуулгын дүнгээс харахад Германы иргэдийн дунд коммунист дэглэмийн талаарх мэдээлэл их хомс байгаа нь харагддаг. 2012 онд Берлиний Чөлөөт их сургуулиас явуулсан судалгаагаар судалгаанд хамрагдсан нийт 7500 сурагчдын дөнгөж талаас илүү хувь БНАГУ-д оршин байсан улс төрийн тогтолцоог дарангуйлагч систем хэмээн зөв тодорхойлж чадаж байсан байна.⁵¹ Үүнээс гадна энэхүү ажлын эхэнд дурдсаны дагуу коммунист дэглэм нийт нутаг дэвсгэрийн багахан хэмжээнд оршин тогтнож байсны улмаас Герман оронд оршин байсан коммунист дэглэмийг нацист дэглэмтэй адилаар өргөн хэмжээгээр дүгнэн шинжилсэн зүйл өнөөг хүртэл байдаггүй. Нацист дэглэмтэй харьцуулахад коммунист дэглэмийг харин гэм хоргүй байсан мэтээр ойлгох ойлголт түгээмэл байдаг. Энэ ойлголтыг 21-р зууны эхээр шинээр гарсан Зүүн Германы амьдралын хэв маягийг эргэн дурсах агуулга бүхий телэвизийн шоу нэвтрүүлэг улам батжуулж өгсөн байдаг. Энэ тал дээр Германы нэгдмэл социалист намын залгамж халааг авсан Зүүнтний нам энэ үзэл бодолд өөрийн хувь нэмрийг оруулсан байна.

49 Аннэ Камински, Эргэн дурсахуйн орон зай. ЗХУ-ын мэдэл байсан нутаг дэвсгэр, БНАГУ-ын тухай музей, дурсгалын газрууд, Берлин хот, 2007 он

50 <http://dip21.bundestag.de/dip21/btd/14/015/1401569.pdf>; www.bundesregierung.de/Content/DE/_Anlagen/BKM/2008-06-18-fortschreibung-gedenkstaettenkonzeption-barrierefrei.pdf?__blob=publicationFile.

51 http://www.fu-berlin.de/presse/informationen/fup/2012/fup_12_181/index.html; Моника Доёц-Шрөөдэр/ Клаус Шрөөдэр, Нийгмийн хангамжийн диваажин эсвэл Аюулаас хамгаалах газарт хяналт дахь улс байв уу? БНАГУ-ын тухай сурагчдын бодол – Зүүн Баруун Германыг харицуулсан судалгаа, Мюнхен хот, 2008 он.

Тийм ч учраас БНАГУ-ын улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртсөн иргэд өөрсдийгөө „хоёрдогч ангиллын“ хэлмэгдэгсэд хэмээн гомдоллох нь зүй ёсны асуудал бөгөөд коммунист дэглэмийг эсэргүүцсэн тэдний тэмцэл тэдний хувьд юуны өмнө эдийн засгийн түвшинд ямар ч үр ашиггүй тэмцэл байсан гэж хэлж болохоор байгаа юм. Энэ байдал ойрын үед ч өөрчлөгдөхгүй нь тодорхой билээ.

